



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ СУДАЛГАА

**ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ**

Удиртгал

Монгол Улсын газрын хэвлийгээс 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий 800 гаруй орд, 8,000 илэрцийг олж тогтоосны дотор алтны 181, зэс молибдений 5, хар тугалганы 1, цагаан тугалганы 54, гянт болдын 10, төмрийн 1, мөнгөний 4 гаруй ордууд байна.

2009 оны байдлаар уул уурхайн салбар нь үндэсний нийт бүтээгдэхүүний 28 гаруй хувийг, нийт үйлдвэрлэлийн 56%, нийт экспортын 60 гаруй хувь, улсын төсвийн орлогын 35 гаруй хувийг тус тус бүрдүүлсэн байна. Үүнээс харахад манай улсын эдийн засгийн хөгжилд голлох хувь нэмэр оруулж байгаа төдийгүй бас томоохон эрсдлийг дагуулж байгаа салбар болоод байна.

Уул уурхайн салбарт өнөөгийн байдлаар 42 мянга гаруй (нийт ажиллах хүчний 4 гаруй хувь) хүн ажиллаж байна.

Өнгөрсөн 17 жилийн дотор Монгол улсад алтны үйлдвэрлэл асар хурдацтай өссөн бөгөөд бараг 30 дахин нэмэгдсэн байна. 1990-ээд оны дунд үеэс хэрэгжиж эхэлсэн “Алт” хөтөлбөр энэхүү үсрэнгүй хөгжилд жинтэй хувь нэмэр оруулснаас гадна гадаадын хөрөнгө оруулалтын дүнд 2008 онд алт үйлдвэрлэлтийн хэмжээ 15,2¹ тоннд хүрсэн байна.

2003 онд Дэлхийн банкнаас² хийсэн судалгаагаар Монгол улсад 100,000 гаруй гар аргаар алт олборлогч иргэд байсан бөгөөд тэд жилд дунджаар 100 сая гаруй долларын алт зарж борлуулж байна гэсэн тооцоог гаргасан байдаг.

Харин 2008 онд Ашигт малтмалын газраас³ гаргасан мэдээллээс харахад манай улсын 18 аймгийн 100 гаруй цэгт 54,000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч иргэд үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлсэн байна. Нийт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 90% нь алтны үндсэн ба шороон ордонд ажиллаж байна. Гэхдээ энэ төрлийн үйл ажиллагааг хэдэн хүн эрхэлж байгаа талаар тодорхой мэдээлэл, судалгаа байдаггүй нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог болох алтны гарц, нөөц, түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний урсгалтай шууд холбоотой юм.

Уянга сумын хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн суурь судалгаа нь тус суманд хувиараа алт олборлож буй иргэдийн амьжиргааны түвшин, алт олборлолт ба ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, тэдний орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, эрүүл мэнд болон нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, хувиараа алт олборлогч иргэдийн хамтын ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох, тэдний нийгэм эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллүүдийг үнэлэх зорилгоор хийгдлээ.

¹ АМГ-Уул уурхайн салбарын үйл ажиллагааны тайлан 2008 он

² Overview of ASM in Mongolia, Murray Harrison Ltd & Eco-Minex International Co Ltd. April, 03.

³ АМГгазраас 2009 оны 8-р сард гаргасан мэдээ

Уг судалгаа нь мэдээлэл цуглуулах тоон аргачлалаас гадна оролцогч талуудын төлөөллийг оролцуулж, чанарын судалгааны арга зүйг ашиглан өргөн цар хүрээнд явуулснаараа онцлог юм.

Талархал

Энэхүү судалгааг хийхэд хамтран ажилласан П. Үржинлхүндэвээр удирдуулсан Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл, Өвөрхангай аймгийн Уянга сумын засаг дарга П. Загарзүсэм, засаг даргын орлогч Т. Дашням, байгаль орчны улсын байцаагч Г. Гандулам, мэргэжлийн хяналтын улсын байцаагч Г. Сосорбурам, газрын даамал Г. Батцэцэг, нийгмийн бодлогын ажилтан Б. Оюун-Эрдэнэ, төрийн сангийн төлөөлөгч Ш. Долгорсүрэн, сумын эмнэлгийн дүн бүртгэгч С. Дууяа, нийгмийн эрүүл мэндийн ажилтан Мижиддорж, нийгмийн халамжийн байцаагч П. Баярхүү, 7-р багийн засаг дарга Батмөнх, “Байгаль хамгаалал орон нутаг хөдөлгөөн”-ий тэргүүн Г. Дорж, болон ЗДТГ-ын бусад ажилтан, албан хаагчид, сумын эмнэлэг, цагдаа, татвар, даатгал зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын ажилтан, албан хаагчид, “ХААН” банк, “Монгол шуудан” банк, сумын худалдаа үйлчилгээний газрууд, болон бусад орон нутгийн иргэдэд Хөгжлийн эзэд ТББ-ийн судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлье.

Тус судалгааг гардан зохион байгуулж, аргачлал хөтөлбөр боловсруулах шатнаас үр дүнг хүлээлгэн өгөх хүртэлх ажилд цаг зав, сэтгэл гарган ажилласан судалгааны багийн ахлах зохицуулагч, нийгмийн ухааны магистр, А. Равдандорж, эдийн засагч статистикч Ж. Мөнхжаргал болон судалгаанд мэргэжлийн чиглэлийн дагуу баг болон мэдээ, мэдээлэл цуглуулах, компьютерт мэдээлэл оруулах, үр дүнг боловсруулах, нэгтгэх зэрэгт идэвхийлэн оролцож ажилласан бусад мэргэжил нэгт нөхөддөө чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хөгжлийн Эзэд ТББ-ийн гүйцэтгэх захирал В. Бэрцэцэг

Товчилсон үгс

АМГ	АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОЯ	БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ
ГХГЗЗГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ДБ	Дэлхийн Банк
НХХЯ	НИЙГЭМ ХАМГААЛАЛ ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
МХСМТ	МОНГОЛЫН ХОРШООЛЛЫН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ
МҮОНТ	МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗ
МУИС	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МХЗ	МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД
ХАМО	ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ
ТТБ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ТОБУТ	ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ
УУАА	УУЛ УУРХАЙН АВРАХ АЛБА
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ЭБЭХЯ	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1 унц – 31.1035 грамм
1 лан – 37.5 грамм
1 цэн – 3.75 грамм
1фун – 0,375 грамм

1. *Суурин алт олборлогч иргэд* – жилийн 4 улирлын турш байнга ажилладаг, үндсэн ажил эрхлэлт нь хувиараа алт олборлолт болсон бүлэг хүмүүс
2. *Явуулын алт олборлогч иргэд* – амьдралынхаа хэрэгцээ шаардлагын улмаас цөөхөн хоногоор ирж алт олборлоод буцдаг бүлэг хүмүүс
3. *Уул уурхайн том компани* - хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензтэй, ус, нөөц, газрын төлбөрөө зохих журмын төлж, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг том компаниуд
4. *Бичил уул уурхайн компани* - Санхүүгийн чадавхитай хувиараа алт олборлогч иргэд, хувиараа компани байгуулан Өлтийн хөндийн ашиглалтын лиценз эзэмшигч том уул уурхайн компанитай гэрээ байгуулан уурхайн эфел дээр алт олборлох үйл ажиллагаа явуулдаг байна. Орон нутгийн иргэдийн тодорхойлохдоо бичил уурхайн клмпаниудыг “техниктэй нинжа” нар хэмээн ёжлон нэрлэдэг байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ БУЮУ СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ГАРЧ ИРСЭН ГОЛ МЭДЭЭЛЛҮҮД

Судалгааны багийнхан Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн байдлыг тодорхойлох судалгааг хийх судалгааны үндсэн арга зүй болох холбогдох бичиг баримтуудыг уншиж танилцаж байх явцдаа төслийн зорилго, зорилтууд, гаргахыг эрмэлзэж буй үр дүнгүүдтэй сайтар танилцан дараах товч мэдээлэл, дүгнэлтийг гаргалаа.

ТоБУТөслийн зорилго: ТоБУТ нь Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийн хөдөөгийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, тэднийг эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмэр оруулах болно.

Төслийн зорилготой холбоотой дараах угтвар нөхцөл байдлууд тухайн орон нутагт байгаа нь судалгаагаар гарч ирлээ. Үүнд:

Хүснэгт 1. Орон нутгийн нийгэм эдийн засгийн угтвар нөхцлүүд

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Ядуурлын түвшин аймгийн дунджаар	30.8% ⁴	Аймгийн 2009 оны статистикийн эмхэтгэлээс авсан мэдээгээр
Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрх	24.8%	Сумын 2009 оны хүн ам зүйн судалгаагаар нийт өрхөд эзлэх хувь
Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой хүн ам	42.1%	Сумын 2009 оны хүн ам зүйн судалгаагаар нийт хүн амд эзлэх хувь
Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин ⁵	75.7%	Ажиллах хүчийг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан харьцаа
Хувиараа алт олборлогч иргэдийн олборлолтын газрын зөвшөөрлийн асуудал	0%	Хувиараа алт олборлогч иргэд нь 1613,5 га талбайг хамарсан ашиглалтын 5 лиценз бүхий 4 аж ахуйн нэгж, 21357.5 га талбайг хамарсан хайгуулын 15 лиценз бүхий 10 аж ахуйн нэгжийн талбай, болон хайгуулын болон ашиглалтын лиценз олгогдоогүй сумын алтжилтын

⁴ 2009 оны байдлаар Хангайн бүсийн хэмжээнд амьжиргааны баталгаажих доод түвшин 90600Төг байна.

⁵ 2008 оны Монгол улсын статистикийн эмхэтгэл

		бүсийн эрүүл газарт хууль бусаар олборлолт явуулж байна.
Хувиараа алт олборлогч иргэдээс алт олборлох үйл ажиллагаатай холбоотой осол, гэмтэлд өртөж байсан байдал	85,3%	Хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрийн осол, аваарт орж бйасан иргэдийн тоо давхардсан тоогоор тооцсон болно.

ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН БАЙДАЛ ⁶

Хүснэгт 2. Гэмт хэргийн төрөл

Гэмт хэргийн төрөл		Тохиолдол	Тайлбар
Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг		48	-
Үүнээс	1. Хүн амь	3	-
	2. Хүчин	1	-
	3. Танхай	2	-
	4. ИЭЧЭМЭ ⁷	23	-
	5. Хулгай	5	Мал, орон байр, өмчийн болон бусад хулгайн төрлүүд багтсан болно.
	6. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2, осол 6.	8	Зам тээврийн ослоос эрүүгийн хэрэг үүссэн 2, эрүүгийн хэрэг үүсэхээс татгалзсан осол 6
	7. Бусад	6	Дээр дурдсанаас бусад төрлийн гэмт хэрэг.

Хүлээгдэж буй үр дүн 1: Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлж, хэрэгжилтийг эхлүүлсэн байна

⁶ 2009 оны 12 сарын 25-нд Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас гаргасан гэмт хэргийн бүртгэл

⁷ Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Хүснэгт 4. Хүлээгдэж буй үр дүн 1

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хууль эрх зүйн зохицуулалтын дагуу албан ёсны зөвшөөрөлтэй газар алт олборлолт хийж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	0%	Засгийн газрын 72-р тогтоол, Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журмын дагуу зөвшөөрөлтэй газар алт олборлож байгаа иргэн байхгүй байлаа.
Нийгмийн даатгалд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	0%	Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ сард 12500 төгрөг ⁸
Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, улсаас эрүүл мэндийн үйлчилгээ авч буй хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	8%	Эрүүл мэндийн сайн дурын даатгалын шимтгэлийн хэмжээ сард 500 төгрөг жилд 6000 төгрөг ⁹
ХАОАТ төлдөг хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	0%	Орлогын хэмжээг тодорхойлох боломжгүй иргэдийн ХАОАТ төлөх шимтгэлийн хэмжээ сард 4000 төгрөг ¹⁰

Хүлээгдэж буй үр дүн 2: Бичил уурхайн бүх түвшинд бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулсан байх

Хүснэгт 5. Хүлээгдэж буй үр дүн 2

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын дагуу зохион байгуулалтад орж ажиллаж байгаа	0	Нийт судалгаанд оролцогч иргэдийн дөнгөж 9% нь түр эжурмын анхан шатны мэдлэг, мэдээлэлтэй

⁸ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль

⁹ Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

¹⁰ Монгол улсын ХАОАТатварын тухай хууль

хувиараа алт байсан.
олборлогч иргэдийн
тоо

Хүлээгдэж буй үр дүн 3: Бичил уурхай эрхлэгчдийн үр ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үй ажиллагааг эрхлэх чадвартай болгоход дэмжлэг үзүүлэх

Хүснэгт 6. Хүлээгдэж буй үр дүн 3

Үзүүлэлт	Хэмжих нэгж			Тайлбар	
	Өдөр	Долоо хоног	Сар		
Хувиараа алт олборлогч иргэдийн орлоготой ажилладаг өдрийн тоо	-	5 өдөр	23 өдөр		
Хувиараа алт олборлогч иргэний олборлож буй алтны дундаж хэмжээ (өдөр, долоо хоног, сараар)	0,3гр	1,5 гр	6,9 гр		
Хувиараа алт олборлогч иргэдийн орлогын дундаж хэмжээ (өдөр, долоо хоног, сараар)	13,500 төг	67,500төг	310,500 төг		
Уянга сумын төсвийн болон хувийн хэвшлийн худалдаа, үйлчилгээний байгууллагуудад ажилладаг иргэдийн сарын дундаж цалингийн хэмжээ	-	-	237000төг ¹¹		

¹¹ Өвөрхангайаймгийн статистикийн хэлтсийн гаргасан Эдийн засаг, нийгмийн байдлын тухай мэдээ 2009 оны 10-р сар

Хүлээгдэж буй үр дүн 4: БУ эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдын байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлүүдийг шийдэж чаддаг чадвартай болох

Хүснэгт 7. Хүлээгдэж буй үр дүн 4

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хувиараа алт олборлогч иргэдийн дунд гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн тоо	48	Сумын цагдаагийн тасгийн мэдээнээс
Хувиараа алт олборлох үйл ажиллагаатай холбоотой зөрчил маргаанууд	Олон ¹²	Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаас олж авсан мэдээлэл (уурхайн газар, хөдөлмөр хуваарилалт, шороо угаах ус, ашиг хуваарилалтын байдал, тоног төхөөрөмж түрээс, ашиглалт гэх мэт)
Байгаль орчин, хүний биед сөрөг нөлөө бүхий химийн хорт бодис хэрэглэн алт боловсруулж байгаа байдал	Үгүй	Ашигт малтмалын газар, Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан шалгалтын дүнгээс ¹³
Хувиараа алт олборлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл	Их ¹⁴	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын эвдрэл, ахуйн хог хаягдал, бусад сөрөг үр дагаврууд

¹² Оролцооны аргаар цуглуулсан мэдээллүүдэд олон, дунд, цөөн гэсэн чанарын хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

¹³ 2008 онд Өлтийн хөндийд хийсэн химийн хорт бодисны хэргэлээний талаарх шалгалтын тайлан

¹⁴ Оролцооны аргаар цуглуулсан мэдээллүүдэд их, дунд, бага гэсэн чанарын хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

БҮЛЭГ 1

ТАНИЛЦУУЛГА



1.1 Удиртгал

Монгол улсад албан уурхайн салбарын хөгжлийн зэрэгцээ сүүлийн 20-иод жил хуулийн хүрээнээс гадуурх уурхайн үйл ажиллагаа салбарлан гарч иржээ. Албан бус уул уурхай буюу ашигт малтмал гар аргаар олборлох явдал 1990-ээд оны эхээр үүссэн бөгөөд өөрчлөлт шинэчлэлтийн явцад албан эдийн засгийн гадна үлдсэн ажилгүй иргэдийн амьдрал залгуулах арга болж, 1990-ээд оны хоёрдох хагасаас эрчимжсэн байна. Сүүлийн хэдэн жилд албан бус уул уурхай тэр дундаа албан бус алт олборлох үйл ажиллагаа Монголын хөдөөгийн хүн амын орлогын чухал эх үүсвэр болжээ.

Монголчуудын хувьд албан бус уул уурхайн салбар руу орох нь ерөнхийдөө сайн дурын хэрэг бус зайлшгүй шаардлагын үүднээс хийж байгаа алхам юм. Хөдөөд орлого олох боломж багассан, ган зудын уршгаар мал сүргээ алдаж орлогын эх үүсвэргүй болсон, хот хөдөөд ажилгүйдэл ихэссэний дээр алт олборлолтоос орлого олох болмжтой байгаа нь албан бусаар алт олборлох явдал огцом газар авахад хүргэсэн ба одоо бараг бүх аймагт бий болоод байна.

Ашигт малтмалын газраас ¹⁵ гаргасан мэдээллээс харахад манай улсын 18 аймгийн 100 гаруй цэгт 54000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч иргэд үйл ажиллагаагаа явуулж байгаа талаар өгүүлсэн байна. Нийт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 90% нь алтны үндсэн ба шороон ордонд ажиллаж байна. Гэхдээ энэ төрлийн үйл ажиллагааг хэдэн хүн эрхэлж байгаа талаар тодорхой мэдээлэл, судалгаа байдаггүй нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог болох алтны гарц, нөөц, түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний урсгалтай шууд холбоотой юм.

Гар аргаар алт олборлох үйл ажиллагаа нь хөдөлмөр ихээхэн шаарддаг, ажиллах нөхцөл нь аюултай, хортой бөгөөд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгсэл хэрэглэх нь маш дутмаг байдаг ба энэхүү үйл ажиллагаатай холбогдон архидан согтуурч гэмт хэрэг зөрчилд холбогдох зэрэг нийгмийн гаж үзэгдлийн цар хүрээ нэмэгдэх хандлага их байна.

Өөр нэг анхаарал татаж байгаа асуудал бол албан бус алт олборлох үйл ажиллагаанд хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж байгаа явдал юм. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг даруй устгах арга хэмжээг авахыг шаардсан ОУХБ-ын 182 дугаар конвенцийг Монгол улс соёрхон баталсан ч олон арван хүүхэд гар аргаар алт олборлох ажилд гар бие оролцож байна.

Цаашилбал, иргэдийн албан бусаар алт олборлох үйл ажиллагаанаас болж том уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа, малчид, тариаланчид болон бусад нутгийн иргэдийн хооронд зөрчил үүсэх хандлага газар авч байна.

¹⁵ АМГазраас 2009 оны 8-р сард гаргасан мэдээ

2005 оноос Швейцарийн Хөгжлийн Агентлаг, АМГ-тай хамтран ТоБУТ-ийг Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийн хөдөөгийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх бичил уурхайчдыг эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмэр оруулах зорилгоор хэрэгжүүлж байна.

ТоБУТ-ийн саналаар Өвөрхангай аймгийн Уянга суманд хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх суурь судалгааг явууллаа.

1.2 Судалгааны зорилго, зорилтууд

Уянга сумын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох, тус суманд хувиараа алт олборлож буй иргэдийн үйл ажиллагаа, тэдний орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр болон тэдний үйл ажиллагаатай холбоотой гарч буй осол аваар, зонхилон тохиолдож буй өвчлөл, гэмт хэрэг зөрчлүүд, байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох.

Судалгааны зорилтууд

1. Уянга суманд хувиараа алт олборлож буй иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг судлах
2. Хувиараа алт олборлож буй иргэдийн алт олборлолтын хувь хэмжээ, борлуулалтын зах зээл, үнэ ханш, орлого ба зарлагыг тодорхойлох
3. Хувиараа алт олборлогч иргэдийн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох
4. Хувиараа алт олборлогч иргэд болон сумын оршин суугчдын амьжиргааны түвшинг харьцуулан тодорхойлох
5. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийх
6. Хувиараа алт олборлогч иргэдийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа, бусадтай эвлэлдэн нэгдэх, бүтэц зохион байгуулалтанд орж буй хэлбэр,
7. Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагаа, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн талаархи олон нийтийн ойлголт хандлага зэргийг тодорхойлох

1.3. Судалгааны ажлын зохион байгуулалт, арга зүй

Судалгааг ТоБУТөслийн саналаар Хөгжлийн Эзэд ТББ-ын судлаач нараас бүрдсэн судалгааны баг арга, аргачлал боловсруулах, түүвэр, түүвэрлэлт хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих үйл ажиллагааг зохион байгуулан 2010 оны 01-р сарын 05-наас 2010 оны 02 сарын 01-ны хооронд явуулав.

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах үр дүнгийн хүснэгтийг боловсруулах, тайлан бичих ажилд ТоБУТ-ийн үйл ажиллагааны багийн ажилтнуудаас санал зөвлөгөө авч хамтран ажиллалаа.

Судалгааны зорилго, зорилтуудад хүрэхийн тулд тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд:

- Ажиглалт
- Харьцуулалт
- Төсөөллийн зэрэглэл
- Орон нутагтай танилцах аялал

- Зураглал
- Фокус бүлгийн хэлэлцүүлэг
- Гүнзгийрүүлсэн ярилцлага
- Кейс судлал

Шаардлагатай мэдээ мэдээллийг нийгмийн судалгааны тоон ба чанарын аргыг ашиглан цуглуулсан. Үүнд тоон судалгаанд холбогдох статистик тоо баримт, бусад судалгааны үр дүн асуумжийг ашиглав.

Асуумжийн бүтэц:

- Ерөнхий мэдээлэл (1-хэсэг)
- Өрхийн амьжиргааны байдал (2-хэсэг)
- Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл (3-хэсэг)
- Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал (4-хэсэг)
- Хувиараа алт олборлогч иргэдийн орлого, зарлагын байдал (5-хэсэг)
- Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээ (6-хэсэг)
- Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа (7-хэсэг)
- Уянга суманд гарч буй гэмт хэрэг зөрчлүүд, түүний шалтгаан нөхцөл (8 -р хэсэг) гэсэн хэсэг бүхий асуултаас бүрдсэн.

Асуултын 90 гаруй хувь нь олон сонголт бүхий хариулттай байлаа.

Ярилцлаганд хамрагдсан бүлэг:

- Сумын удирдлага
- Нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, хэлтсүүд
- Сумын хүн эмнэлэг
- Сумын цагдаагийн тасгийн албан хаагчид
- Байгаль орчны байцаагч
- Газрын даамал
- Мэргэжлийн хяналтын байцаагч
- Монгол шуудан банк, ХААН банк
- Шатахуун түгээх станцууд
- “Байгаль хамгаалал – Орон нутгийн хөгжил” хөдөлгөөний тэргүүн, гишүүд
- Тус суманд үйл ажиллагаа явуулж буй ОУБ-ууд

- Бичил уул уурхайн компаниуд
- Хувиараа алт олборлогч иргэд
- Худалдаа, үйлчилгээний газрууд
- Бусад

1.4. Судалгааны түүвэрлэлт

Судалгааны эх олонлогт тухайн үед алт олборлож байсан 18 ба түүнээс дээш настай Монгол улсын иргэдийг хамруулан, энгийн санамсаргүй түүврийн зарчмаар судалгаанд оролцогчдыг сонголоо.

Хувиараа алт олборлогчдын бодит тоог улирлын хэлбэлзэл, онцлог зэргээс шалтгаалан гаргахад хүндрэлтэй байдгийг харгалзан 95 хувийн түвшинд 5.0 хувийн алдааны магадлалтайгаар байхаар тооцон Уянга сумын Өлтийн хөндийд алт олборлогч иргэд, бичил уул уурхайн компаний ажилчид, малчид болон бусад 700 гаруй иргэдийг түүвэрлэн судлахад тохиромжтой гэж үзлээ.

Анкетын судалгаанд хувиараа алт олборлож буй 500 иргэнийг сонгосон ба 27.8% нь Уянга сумын иргэд, 72.2% бусад аймгуудаас ирсэн хүмүүс байлаа.

1.5. Мэдээллийн шинжилгээ

Тоон судалгааны мэдээллийг оруулж, үр дүнгийн шинжилгээ хийн, мэдээлэл боловсруулахад **SPSS-17** программ хангамжийг ашиглав. Чанарын судалгааны мэдээлэл боловсруулалтад Simple text analyse болон үр дүнгийн агуулгын дагуу бүлэглэн матриц үүсгэн, нэгтгэж дүгнэлт хийв.

1.6. Судалгааны явцад тохиолдсон бэрхшээлүүд

- Уянга суманд хувиараа алт олборлогчид нь албан ёсны зөвшөөрөлгүй газар алт олборлож байгаа учир орон нутгийн засаг захиргаа, том уул уурхайн компаниуд болон нутгийн малчдын зүгээс байнгын дарамт шахалтанд өртдгөөс нилээд хаширсан, болгоомжилсон, зайлсхийсэн, дургүйцсэн, бухимдсан хандлагууд гаргаж байсан учир үнэн зөв мэдээллийг олж авахад нэлээд хүндрэл учирсан.
- Мэдээлэл өгөгч талууд нь хувиараа алт олборлох үйл ажиллагааны талаар өөрсдийн эрхэлж буй ажил хөдөлмөр, үүрэг хариуцлагатай холбоотойгоор хэтэрхий туйлширсан эсрэг тэсрэг мэдээлэл өгч байсан нь мэдээлэл боловсруулах, баталгаажуулах, дүгнэлт хийх явцад хүндрэл учруулж байлаа.
- Анкетын судалгааг авах үед хүйтэн, цасан болон шороон шуургатай өдрүүд тохиолдож байсан учир судалгаанд оролцогчид болон судлаачдад бэрхшээлтэй байлаа.
- Хувиараа алт олборлогч иргэдийн дунд өрхийн орлого зарлагаа урьд нь тооцож үзээгүйн улмаас орлого зарлагаа тодорхойлоход нилээд цаг хугацаа зарцуулж байсан.

- Хувиараа алт олборлогч иргэдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Хүн харх”, “Нинжа”, “Зэрлэгүүд” гэх мэтээр нэр гуншин өгч ихэвчлэн сөрөг мэдээлэл цацдаг учир хувиараа алт олборлогчид мэдээлэл өгөх, зураг авахуулах зэргийг эрс эсэргүүцэж байсан.
- Судалгааны багийнханд 16-17 цагаас хойш ажиллахад нилээд аюултай нөхцөл байдлууд тулгарч болзошгүй байсан учраас мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн хоног хугацааг 3 өдрөөр сунгасан.
- Хувиараа алт олборлогч иргэдийн өдрийн болон сарын орлогын талаар судлахад татвар ногдуулах, алтны гарцын танадалт хийн гарц сайтай байвал биднийг хөөх гэж байна уу гэсэн хардлага сэрдлэгэ, болгоомжлолтойгоор хандаж байсан нь үнэн бодит мэдээллийг цуглуулахад хүндрэл учруулж байлаа.

БҮЛЭГ 2

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ



лицензээр 1,085,187 га, хайгуулын лицензээр 12,302 га газар олгогдсон байна. Алт олборлолт хамгийн ихээр явагдаж байгаа аймгуудад Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Баянхонгор, Дархан Уул аймгууд орж байна. Эдгээр аймгуудад хамгийн олон тооны алтны ашиглалтын лиценз олгогдсон байна.

Аймгийн нутагт улсын тусгай хамгаалалттай Хангайн нурууны Орхон голын сав нутаг, Хүйсийн найман нуур, Батхаан уул, Монголын элс, Зүүн хайрхан уул оршдог бөгөөд шинээр Монгол орны төв цэг зүүн Баян-Улаан сумын Хүнгүйн мухар, Баруун Баян-Улаан сумын Хүрэн хадны рашаан зэрэг 21.1 га талбай эзлэх газар нутгийг тусгай хамгаалалтанд авснаар тусгай хамгаалалттай газрын хэмжээ 309.8 мянган га болж нийт нутаг дэвсгэрийн 4.9 хувийг эзэлж байна.

Шилмүүст ой нь нийт 201.390 га талбай эзэлдэг бөгөөд Богд, Гучин-ус, Төгрөг, Баруун Баян-Улаан сумдын нутгаар нийт 75.750 га талбайд заган ой ургадаг. Ойн ихэнх хувийг хар мод эзлэх боловч хуш, бургас, улиангар, улиас, монос, үхрийн нүд, тошлой, заг, хайлаас, нохойн хошуу, харгана зэрэг мод бут ургадаг. Тус аймаг нь ан амьтны аймгийн хувьд долоон баг, 15 овогт хамаарах 49 төрлийн 73 зүйлийн ан амьтад байдаг. Тухайлбал, буга, согоо, хүдэр, гахай, шилүүс, аргаль, янгир, ирвэс, хар сүүлт, зээр, чоно, үнэг, хярс, мануул, туулай, тарвага, зурам, хэрэм, жирх зэрэг ан амьтад хун, галуу, нугас, тоодог, тоншуул, бүргэд, сар, шаазгай, ангир, ятуу, сойр зэрэг жигүүртэн шувууд Орхон, Онги, Таац голуудад төрөл бүрийн загас элбэг байдаг. Мөн эмчилгээний чанартай Хужирт, Хүрэмт, Хятруун, Хүрэн хадны зэрэг халуун хүйтэн рашаан байдаг.

2.2. Өвөрхангай аймгийн хүн ам зүй, боловсролын талаарх ерөнхий мэдээлэл

Засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймаг нь 19 сум, 105 багд хуваагддаг. 2009 оны байдлаар Өвөрхангай аймаг нь нийт 32,349 өрхийн 111,977 хүн амтай. Нийт хүн амын 50,5 % буюу 56,527 эмэгтэй, 49.5% буюу 55,450 эрэгтэйчүүд байгаа бөгөөд 100 эмэгтэйд 98 эрэгтэй ногдож байна. Үүнээс харахад аймгийн хүн амын хүйсийн харьцаа 49,5 х 50,5 байна. Нийт хүн амын 47,6% буюу 53,345 нь аймаг сумдын төвд, 52,4% буюу 58,522 нь хөдөөд амьдардаг.

График 1. Хүн амын нас хүйсийн суварга





График 2. Хүн амын өсөлт бууралт



Нийт хүн амын 64,4% нь залуу болон идэр насныхан, 29,7% нь хүүхдүүд, 5,9% нь хөгшид, өндөр настангууд байна. Сумдуудын өөрсдийнх нь тодорхойлж ирүүлсэн мэдээгээр амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой 7,755 өрхөд 32,800 хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 24,0%, нийт хүн амын 29,3%-ийг эзэлж байна. Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 30,8% нь нэн ядуу өрх байна.

Аймгийн хэмжээнд 180 бүтэн өнчин, 1,796 хагас өнчин хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 2,088, өрх толгойлсон эмэгтэйчүүд 2,792 байна. Нийт өрхийн 8,6% нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

Аймгийн хэмжээнд нийт 31 цэцэрлэгт 3,161 хүүхэд хүмүүжиж байна. Өвөрхангай аймагт нийт 30 ерөнхий боловсролын сургууль байдаг. Ерөнхий боловсролын сургуульд 23,668 хүүхэд суралцдагас 12,671 хүүхэд бага ангид, 8,362 нь дунд ангид үлдсэн 2,635 хүүхэд нь ахлах ангид суралцаж байна.

Аймгийн хэмжээнд жилд дунджаар 4,850 хүүхэд ерөнхий боловсролын сургууль төгсдөг байна. Нийт сурлацагчдаас 10,374 хүүхэд нь малчдын хүүхэд, 121 хүүхэд бүтэн өнчин, 9 хүүхэд асрамжлах хүнгүй, 1,044 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байдаг байна. Мөн аймгийн хэмжээнд нийт 30 дотуур байр байдаг ба эдгээрт 2,813 хүүхэд амьдардаг ба үүнээс 2,734 нь малчдын хүүхдүүд байдаг байна. Сургуулиас гадуур байгаа 6-14 насны 346 хүүхэд бүртгэгдснээс, хамгийн олон сургууль завсардсан хүүхэдтэй 3 сумдын тоонд Арвайхээр, Хужирт, Уянга сумдууд орж байна.

2.3. Хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйчилгээ

Аймгийн хэмжээнд бүсийн эмчилгээ, оншилгооны төв 1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 1, сумын эмнэлэг 16, сум дундын эмнэлэг, их эмчийн салбар 2 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Эмнэлгийн орны тоо 2008 онд 631 байсан бол 2009 онд 637 болж өссөн байна. Эмнэлгийн нэг оронд ноогдох хүн 175,8, ор ашиглалтын хувь 79,6, дундаж ор хоног 7,9, орны эргэлт 33,4 тус тус байна. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа боловсон хүчний хувьд их эмч 187, эмийн дээд мэргэжилтэн 8, эрүүл мэндийн дунд ажилтан 540 байна.

Хүснэгт 8. Сумын эмнэлгийн боловсон хүчний тоо

Үзүүлэлт	2006	2007	2008	2009
их эмч	170	182	185	187
Эмийн дээд мэргэжилтэн	10	9	9	8
Дунд мэргэжилтэн	490	587	528	540
10,000 хүнд ноогдох				
Их эмч	15.7	16.6	16.9	16.7
Эмийн дээд мэргэжилтэн	0.9	0.8	0.8	0.7
Дунд мэргэжилтэн	45.2	53.6	48.2	48.2
1 их эмчид ноогдох хүн	636.6	601.6	597	599
1 эмийн мэргэжилтэнд ноогдох хүн	10.823.4	12.165.8	12.271.1	13.997.1
1 дунд мэргэжилтэнд ноогдох хүн	220.8	186.5	209.1	207.4

Аймгийн эмнэлгүүдэд 2,942 эх амаржиж, 668 хүн нас барж өнгөрсөн оноос төрөлт 8,2%, нас баралт 7,5%-иар нэмэгдсэн байна. Нас баралтын 10,2%-ийг нялхасын нас баралт эзэлж байгаа ба 1000 хүнд ногдох төрөлт 26, нас баралт 6 байна.

2009 онд аймгийн хэмжээнд халдварт өвчнөөр өвчилсөн 996 тохиолдол гарсан ба нийт өвчлөлийн 16,6% халдварт шар өвчин, 7,6%-ийг сүрьеэ, 24,2%-ийг заг хүйтнээр өвчлөгсөд эзэлж байна.

2.4. Ажил эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ

Аймгийн хүн амын 61.4 хувь буюу 68,804 нь хөдөлмөрийн насны хүн байна. Үүний 49,549 нь ажиллагсад, 2,568 нь Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд, 5,814 нь ажилгүй бүртгэлгүй хүн ам, 7,625 нь суралцагсад, 3,248 нь хөдөлмөрийн чадваргүй хүн ам байна.

Хүснэгт 9. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Үзүүлэлт	2008	2009
Хөдөлмөрийн насны нийт хүн ам	68,629	68,804
Ажиллагсад	49,876	49,549
ХЭА -д Бүртгэлтэй ажилгүйчүүд	2,115	2,568
Ажил эрхлээгүй хүн ам	5,618	5,814
Суралцагсад	6,963	7,625

Хөдөлмөрийн чадваргүй хүн ам	4,057	3,248
------------------------------	-------	-------

Ажиллагсдыг эдийн засгийн салбараар авч үзвэл 65% нь хөдөө аж ахуйн салбарт, 9% бөөний болон жижиглэн худалдаанд, 9,5% төсөвт байгууллагад, 16% нь бусад салбаруудад ажиллаж байна.

Хүснэгт 10. Хөдөлмөрийн насны хүн амын тоо

Үзүүлэлт	2008	2009
Нийт хүн ам	110,440	111,977
Хөдөлмөрийн насны хүн ам	68.629	68.804
Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь	50.7%	46.5%
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	51,991	52,117
Ажиллагсад	49,876	49,549
Бүртгэлтэй ажилгүйчүүд	2,115	2,568
Ажиллах хүчний оролцооны түвшин	75.8%	75.7%
Ажилгүйдлийн түвшин	4.1%	4.9%

Сумдаас ирүүлсэн мэдээгээр хөдөлмөр эрхлэгч нийт 563 хүүхэд байгаагийн 46,7% нь хөдөө аж ахуйн салбарт, 19,7% нь уул уурхайн салбарт 11,2% нь албан бус секторт хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст 2,568 хүн ажил хайж бүртгүүлсний 55,0% нь эмэгтэйчүүд байна. Бүртгүүлсэн ажилгүйчүүд 2008 онтой харьцуулахад 21,4%-иар өссөн ба 34,5% нь 25-34 насныхан, 27,4% нь 35-44 насныхан, 23,1% нь 16-24 насныхан, 14,8% нь 45-60 насныхан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 34,4% нь бүрэн дунд, 15,4% нь дээд, 32,6% нь бүрэн бус дунд, 4% нь тусгай дунд, 7,2% нь мэргэжлийн анхан шатны, 5,6% нь бага боловсролтой байна.

2009 онд аймгийн хэмжээнд 1,503 байнгын ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байраар хангагдагсдын 12,4% барилгад, 26,3% нь хөдөө аж ахуйд, 14,7% нь үйлдвэрлэлд, 1,6% нь зочид буудал, зоогийн газарт, 12,4% нь бөөний болон жижиглэн худалдаанд, 1,4% тээвэр холбоонд, 7% нь уул уурхайд, 15,4% төсөвт байгууллагад, 8,9% нь хувийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд ажлын байртай болжээ.

2009 онд нийгмийн халамж, үйлчилгээний хүрээнд давхардсан тоогоор 73,8 мянган хүнд 10,6 тэр бум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж болгосон байна. 2,419 хүнд 1041,4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2,111 хүнд 542,9 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, ниймийн халамжийн тусламж дэмжлэг

шаардлагатай 2,183 хүнд 232,2 сая төгрөгийн тэтгэмж, тусламж, 7,637 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 563,0 са төгрөгийн тусламж, хөнгөлөлт, Хүүхэд хөгжил сангаас 59,206 хүүхдэд 3,9 тэр бум төгрөг олгожээ. Бүх төрлийн тэтгэвэр авагч 13,750 хүнд 13 тэр бум төгрөгийн тэтгэвэр, 3,110 хүнд 530,8 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2.5.Аймгийн макро эдийн засгийн байдал

Тус аймгийн хэмжээд аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй нийт 872 аж ахуйн нэгж байгууллагууд байгаагаас 193 нь төсөвт байгууллага, 91 нь төсөвт байгууллагын салбарууд, 80 нөхөрлөл, 18 хувьцаат компани, 353 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3 нь орон нутгийн өмчит аж ахуйн газрууд, 2 нь төрийн өмчит үйлдвэрийн газар, 70 хоршоо, 14 хадгаламж зээлийн хоршоо, 24 төрийн бус байгууллага, 8 шашны байгууллага, 2 сан, 14 олон нийтийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.


2009 оны 12-р сарын байдлаар аймгийн төсөвт 3,8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн ба үүнээс татварын орлого 3,6 тэрбум төгрөг, татварын бус орлого 226 сая төгрөг, бусад орлого 137 сая төгрөг байсан байна.

График 3. Өвөрхангай аймгийн төсвийн орлогын бүрдэлт




Харин татварын нийт орлогын 10,6% буюу 406 сая гаруй төгрөг нь алтны ашиглалтын лицензийн төлбөрөөс, 0,3% буюу 12,4 сая төгрөг нь ашигт малтмалын нөөцийн төлбөрөөс, 2,1% буюу 82,6 сая төгрөг нь газрын төлбөрөөс, 0,3% буюу 12,1 сая төгрөг ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахтай холбоотой төлбөр хураамжаас тус тус бүрдсэн байна.

График 4. Өвөрхангай аймгийн татварын орлогын бүрдэлт



Харин төсвийн зарлагын бүтцэд ангилалт хийж үзвэл нийт төсвийн 59% нь ажилчдын цалин хөлс, унаа хоолны хөнгөлөлт зэрэгт, 6 хувь нь тэтгэвэр тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын хураамж, 29 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал болох түрээс, бичиг хэрэг, холбоо харилцаа, томилолт, ном хэвлэл, хувцасны хангалт зэрэг бараа үйлчилгээнд зарцуулагдаж, үлдсэн 6% нь хөрөнгө оруулалт, суралцагч нарт олгох амьжиргааны тэтгэлэг, нэг удаагийн бусад тэтгэлэг, хот тохижилт зэрэг үйл ажиллагаанд зарцуулагджээ.

График 5. Өвөрхангай аймгийн төсвийн зарцуулалт



Аймгийн хэмжээгээр иргэд байгууллагын мөнгөн хадгаламж 18,7 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дунджаар 167,3 мянган төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 390,5 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. 2008 онтой харьцуулбал хадгаламж эзэмшигчдийн тоо 24,8 хувиар, хадгаламжийн хэмжээ 52% -иар өсчээ. Аймгийн арилжааны банкуудын дүнгээр 25,824 иргэд, аж ахуйн нэгжид 42,5 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оноос зээлдэгчийн тоо 16%-иар, олгосон зээлийн хэмжээ 39,9%-иар буурчээ. 2009 оны 12-р сарын байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 31,9 тэрбум төгрөг байгаа ба хугацаа хэтэрсэн зээл 1,6% буюу 525,1 сая төгрөг, чанаргүй зээл 3,4% буюу 1,4 тэрбум төгрөг байна. Аймгийн банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү 8,4%-10%, хугацаатай хадгаламжийн жилийн хүү 9,6%-19,8% байлаа.

2009 оны байдлаар аймгийн хэмжээнд мотоцикль 3,263, хүнд машин механизм 68, чиргүүл 112, суудлын машин 2,902, ачааны машин 2,032, автобус 1,214, тусгай зориулалтын машин 29 бүртгэгдсэн байна. Дээрх үзүүлэлтийг 2008 оны тоон мэдээлэлтэй харьцуулан үзвэл автомашин 890 буюу 19,1%-иар өссөн байна. Аймгийн хэмжээнд нийт 9,620 тээврийн хэрэгсэл үзлэг тооллогонд хамрагдаж, үзлэгийн дүнгээр авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 185,3 сая төгрөг, аймгийн авто замын санд 19,7 сая төгрөг, тээврийн хэрэгслийн оношилгоонд 50,8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

2.6. Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал

Мал аж ахуй: 2009 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 3,620,1 мянган толгойд хүрч, 170,4 мянган толгойгоор өссөний дотор тэмээ 15,2 мянга, адуу 183,4 мянга, үхэр 141,1 мянга, хонь 1,691,1 мянга, ямаа 1,589,1 мянга болж тус тус өссөн байна. Малтай өрх 19,888, үүнээс малчин өрх 16,855 байна. Аймгийн нэг малтай өрхөд 182, нэг малчин өрхөд 200 толгой мал ногдож байна. Мянга ба түүнээс дээш малтай 222 өрх байна.

2009 оны 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 111,317 мал хорогдсноос тэмээ 76, адуу 2,408, үхэр 3,348, хонь 41,494, ямаа 63,991 тус тус хорогджээ. Сант, Хайрхан дулаан, Баянгол, Баян Өндөр, Нарийн тээл сумдуудад малын хорогдол хамгийн их гарсан байна.

Газар тариалан: Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 981 га-д үр тариа, 252,6 га-д төмс, 131,6 га-д хүнсний ногоо тариалж намрын ургац хураалтаар 860 га-гаас 702 тонн үр тариа, 252,4 га-гаас 2,392 тонн төмс, 136,6 га-гаас 1446.4 тонн хүнсний ногоо хураан авчээ. Аж ахуйн нэгж иргэд 14,491.9 тонн хадлан, 5,221.8 тонн гар тэжээл бэлджээ.

2.7. Нийгмийн сахилга, дэг журам

Аймгийн цагдаагийн газрын мэдээгээр 355 хэрэгт 385 хүн холбогдон шалгагдаж, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 21 хэрэг байна. Нийт бүртгэгдсэн хэргийн 35,5% нь иргэдийн өмчийн хулгай, 29% нь иргэний эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 9% нь танхай, 5,9% нь эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэг байна.

Хүснэгт 11. Гэмт хэргийн төрөл¹⁶

Гэмт хэргийн төрөл		2007	2008	2009
Үйлдэгдсэн бүх хэрэг		499	545	355
	Бусдыг амь насыг санаатай хөнөөсөн	7	9	5
	ИЭЧЭМЭ	153	109	103
	Албан тушаалын хэрэг	6	0	0
	Танхай	44	22	32
	Хүчин	5	7	6
	Дээрэм булаалт	12	7	6
	Иргэдийн өмчийн хулгай /мал, орон байр/	216	143	126
	Хөдөлгөөний аюулгүй байдалын	41	37	30
	Бусад хэрэг	51	31	28
	Холбогдогч тодорхойгүй	58	27	21

Гэмт хэрэгт холбогдсон 385 хүний 41,6% эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 27,5% нь бүлэглэн, 37,1% согтуугаар гэмт хэрэг үйлдсэн ба 64,2% нь 18-35 хүртэл насны хүмүүс байна.

Хүснэгт 12. Гэмт хэрэг үйлдэгчдийн байдал

Үзүүлэлт		2007	2008	2009
Нийт гэмт хэрэг үйлдэгчид		561	430	385
Үүнээс	Эмэгтэй оролцсон	15	16	
	Хүүхэд	27	20	28

¹⁶ ¹⁶ 2007, 2008, 2009 онуудын Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас гаргасан гэмт хэргийн бүртгэлүүдээс харьцуулан харуулав

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

	оролцсон			
	18-35 насны	358	239	247
	36-аас дээш насны	156	146	110
Нийгмийн байдлаар				
Үүнээс	Ажилгүй	201	166	160
	Ажилчин	104	42	66
	Малчин	181	156	122
	Албан хаагч	26	21	14
	Бусад	11	3	5
Бүлэглэсэн		161	137	106
Согтуу		204	159	143

Хүснэгт 13. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлт		2007	2008	2009
Гэмтэж осолдсон хүн бүгд		224	176	111
Үүнээс	Нас барсан	90	96	69
Нийт хохирол сая.төг		360.9	223.5	251.8
Үүнээс	Нөхөн төлүүлсэн	184.9	157	163.1
	Иргэдэд учирсан хохирол	341.7	182.2	207.5

2.8. Өвөрхангай аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

Аймгийн 2009 оны нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 14 . Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	х/н	2006	2007	2008	2009
1	Газрын сан	га	6289,5	6289,5	6289,5	6289,5
2	ХАА-н эдэлбэр газар	Га	5867,8	5867,8	5867,8	5867,8
3	Нийт өрх	тоо	29,207	29,770	30,782	32,349

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

4	Бүгд хүн ам	тоо	110,150	109,492	110,440	111,977
5	Хөдөлмөрийн насны хүн ам	тоо	63,572	67,083	68,629	68,804
6	Эдийн засгийн идэвхтэй хүн ам	тоо	49,850	51,557	51,991	52,117
	Үүнээс: - ажиллагсад	тоо	47,592	49,410	49,876	49,549
	бүртгэлтэй ажилгүйчүүд	тоо	2,258	2,147	2,115	2,568
7	Хөдөлмөрийн чадваргүй хүн ам	тоо	3,470	3,448	4,057	3,248
8	Бүртгэлгүй ажил эрхлээгүй хүн ам	тоо	5,715	5,685	5,618	5,814
9	Ажилгүйдлийн түвшин /бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон/	хувь	4,5	4,2	4,1	4,9
10	Эдийн засгийн өсөлтийн түвшин	хувь	12,9	31,9	28,1	
11	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэр бум	64,5	85,2	109,2	
12	Нэг хүнд ногдох ДНБ /жилийн дундаж хүн амаар/	мян.төг	591,5	775,9	993,2	1081,0
13	Хэрэглээний үнийн индекс /өмнөх онуудтай харьцуулсан/	хувь	106,0	128,2	112,8	109,0
14	Инфляцийн хурд	Хувь	0,6	22,2	-15,4	-3,8
15	Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	1996,2	3,889	5,164,6	5,357,1
	Үүнээс: улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	сая.төг	532,9	980,8	2,223,3	1,503,8
16	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	сая.төг	680.1	578.9	1.316.2	468.1
17	Зарлага санхүүжилт	сая.төг	40.704.5	16.888.7	26.189.5	27.641.1
	Үүнээс: улсын төсвийн байгууллага	сая.төг	9.507.2	13.141.8	20.806.8	22.859.5
	орон нутгийн төсвийн байгууллага	сая.төг	1.989	3.746.9	5.382.7	4.781.6
18	Хөрөнгө оруулалт	тэрбум			9.8	12.1
19	ЕБС-д суралцагсад	тоо	24,130	24.308	24.307	23.668
20	Бүх шатны сургуулийн багш нар	тоо	906	956	1041	1083
21	Их эмч	тоо	170,0	182	185	187
22	Эмнэлгийн нийт ор	тоо	605	626	631	637

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

23	Хүн амд худалдаалагдсан нийт бараа гүйлгээ	сая.төг	12.342.1	15,620,0	21,050,7	22,087,4
24	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	2.026.6	2.625.1	3.487.4	4.649.9
25	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	2.092.8	2.619.2	3.341.7	4.356.6
26	Малын тоо	толгой	2.623.263	3.190,190	3.449.746	3.620174
27	Тариалсан талбай	га	1.952	1.480.9	1010.7	1.365.2
28	Хураасан ургац	тонн	4.039.7	3311.2	3.708	4.540.4
30	Бүртгэлтэй аж ахуйн нэгж	тоо	721	721	865	872

БҮЛЭГ 3

УЯНГА СУМЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ



3.1. Уянга сумын газар зүйн байршил ба байгалийн нөөцийн тархалт, ашиглалт

Өвөрхангай аймгийн Уянга сум нь Улаанбаатар хотоос 490 километр, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос 60 км зайтай оршдог. Уянга сум нь Өвөрхангай аймгийн баруун хойд хэсэгт Хангайн нурууны салбар уулсын өвөрт оршдог ба газар зүйн байрлал нь хойд өргөргийн 46°48' зүүн уртрагийн 102°19', дэлхийн экваторын бүслүүрээс 51,625 км зайтай, хойд талаараа Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Өлзийт сум, Өвөрхангай аймгийн Бат Өлзийт, Зүүнбаян Улаан сум, урд ба баруун талаараа Тарагт, Хайрхан дулаан, Нарийн тээл сумдуудтай тус тус хиллэдэг. Нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 319 мянган километр квадрат, үүний 28,8%-ийг ойн мод эзэлдэг.

Нутгийн хойд цэг нь Хан Баян уулаас Хужиртын Шар Мухар хүртэл 76 километр, зүүн захын цэг нь Оньдолтын Цагаан Хөтлөөс баруун Жаргалантын нуруу 102 километр юм. Хамгийн өндөр газар нь Цэгээний нуруу, Баруун Зүүн Улаан, Битүүд, Хятруун, Шурангийн нуруу юм. Онгийн голын урт 435 километр урт, өргөн нь 5-35 километр, Таацын голын урт нь 134 километр байжээ.

Уур амьсгалын хувь хангай нуруу, түүний салбар уулсын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж температур 2,1 хэм, агаарын үнэмлэхүй их дулаан +44,8 хэм, үнэмлэхүй бага температур -47,5 хэмд хүрдэг. Сүүлийн 10 жилд жилийн дундаж температур хангай нутагт +0,2 хэмээр дулаарч байгаа ба жилд дунджаас 306,1 мм тунадас унадаг.¹⁷

Хөрсний зохилох шинж нь хүрэн хөрс байдаг ба хөрсөн бүрхэвчийн хувьд Уянга сум нь дараахь хөрсний хэв шинжийн илрэлтэй байдаг.

1. Уулын нуга ба нугат хээрийн хөрс
2. Уулын хар хүрэн хөрс
3. Уулын хар шороон хөрс зэрэг хэв шинжүүд энэхүү суманд зохилдог.

Ургамлын нөмрөг ба амьтны аймгийн хувьд тус сумын бүс нутаг нь ургамалшилтын хувьд өндөр уулын цармын ойн, тал хээрийн ургамлын бүсүүдэд хамаарагдана. Уянга сумын Хангай уулс нь 2,000 метрээс дээш өндөр, уулын цармын бүсэд оршдог. Тус нутагт 200 гаруй нэр төрлийн ургамал ургадгаас газар зүйн мужлалаар хувааж голлох ургамлыг авч үзвэл ойт хээрийн шинэс, шинэсэн –хушин ой, Сибирийн биелэг өвс, зогдор, улулж, яргуй, сөд өвс, улаан бортууль, тал хээрийн бүсэд нугын биелэг өвс, мөлхөө хиаг, ерхөг, сөд өвс, согоовор, шивээ зэрэг ургамлууд тархсан. Хангайн нуруу, Хүйсийн найман нуур орчимд хөвд, биелэг өвс, бортууль зэрэг бэлчээрийн ургамалтай мөн юмдүүжин, алтан гануур, бангинагарав, алтан

¹⁷С. Ичинноров “Өвөрхангай аймгийн нэвтэрхий толь

хундага, нохойн хошуу, чонын элэг, царван ургадаг. Түүнчлэн зэгд, гоньд, хад, тошлой, арц, дарьсугар зэрэг эмийн болон жимс жимсгэнэ ургадаг.

Уянга сумын ойн сангийн нийт талбай 28,217 га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбайн 22,930 га, ойгоор бүрхэгдээгүй талбай нь 4,218 га, ойн бүс талбайн дүн 1,069 га байна. Хангайн нурууны орчим газарт малын хөлийн тахлалт нэлээд ихсэж байгаа, хуурайшилт ган зуднаас болж ургамалжилтын бүтцэд өөрчлөлт оруулж байна. Сүүлийн жилүүдэд адуу ихээр оторлон өвөлжиж, хаваржиж байгаа, үйлийн цагаан оготно ихээр тархаж байгаа нь бэлчээрийн ургамалжилтанд маш сөргөөр нөлөөлж байна.

Сумын газар нутгийн уулархаг бүсэд аргал, янгир ихээхэн байдаг. Талархаг бүсэд туулай, хар сүүлт, цагаан зээртэй ба хулан, хавтгай ховордсон ба хааяа цөөн тоогоор үзэгддэг. Сүүлийн 30 жилд ан амьтад ихээр хорогдож байна. Чоно элбэгтэй, ууландаа тарвагатай, мөн шилүүс мануул, үнэг хярс, булаг, суусар, нохой зээх, өмхий хүрэн, үнэгэн суусар зэрэг махчин амьтад байдаг. Говийн хэсэгт янз бүрийн хорхой шавьж ихтэй ба харвадаг суман могой, могой гүрвэл, хонин гүрвэл, цагаан тэмээ гэдэг том аалз бий. Тас, бүргэд, ёл, хэрээ, харцага, хулан жороо, сар, болжмор, чогчого, ууль, өвөөлж, хөхөө, элээ, шар шувуу, ятуу, хойлог, алтан хараацай, шаазгай, ногтруу, тоодог, тогоруу зэрэг суурин болон нүүдлийн шувууд байдаг

Гадаргын ба гүний усны хувьд 24 том жижиг гол горхитой, 9 нууртай, 8 рашаантай, 8 худагтай, 32 жижиг булагтай. Хангайн нуруунаас эх авсан умард мөсөн далайн савд багтах Орхон, Төв Азийн гадагшаа урсгалгүй савд багтах Онги, Таац зэрэг түргэн урсгалтай голууд нь өөрийн сумын болон аймгийн нутагт 150-250км урсаж, цаашид үргэлжлэн урссаар Улаан нуур, Таацын цагаан нуур, Хаяа нуурт цутгадаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал байгаль цаг уурын нөхцөл, голын эхийн ой модны нөөц багасаж байгаа, голын эхэнд ашигт малтмал олборлож байгаатай холбогдон Онги гол татарч, Улаан нуур ширгэхэд хүрээд байна.

Ашигт малтмалын нөөцийн хувьд Уянга сум нь Бөөрөлжүүт, Өлт, Нарийн, Буянт гол, Маанийн тохойн ус зэрэг газруудад алтны ил ба шороон ордууд, Бөөрөлжүүт багт хүрэн нүүрсний ил орд судлагдаж тогтоогдсон байна. Тус сум нь барилгын материалын төрөл бүрийн нөөцтэй. Уянга сум нь алтжилтын бүсэд оршдог ба 2009 оны байдлаар сумын нийт нутгийн 21,357,4 га талбайд 10 аж ахуйн нэгжийн 15 хайгуулын лицензтэй, 1762,5 га талбайд 4 аж ахуйн нэгжийн 6 ашиглалтын лиценз олгогдсон байна. Өнөөдрийн байдлаар Уянга суманд уурхайд өртсөн нийт талбай 257,6 га байгаагаас Эрэл ХХК-ний эвдсэн талбай 242,6 га буюу 94% байна. Эрэл ХХК нь Уянга суманд алт олборлох үйлдвэрлэл эхэлсэн анхны том компани юм. Энэ суманд 1990 оноос Алт хөтөлбөр хэрэгжих үеэс эхлэн уул уурхайн үйлдвэрлэл ихээр хөгжсөн, газар нутаг нь уул уурхайн эдэлбэрт нэлээдгүй өртөж, тогтмол 50 гаруй бичил уурхайн компаниуд, 5000-аас дээш гар аргаар алт олборлогчид байдаг гэж барагцаалсаар ирсэн боловч, энэ талаар бүрэн гүйцэд судалгаа орон нутгийн түвшинд хийгдээгүй байна.


Хүснэгт 15. Уянга суманд лиценз эзэмшигч аж ахуйн нэгж, компаниуд

№	Компаний нэрс	Талбайн хэмжээ /га/	Лицензийн төрөл
1	Агьт Хангай ХХК	314	А
2	АУМ ХХК	829	А
3	АУМ ХХК	149	А
4	АУМ ХХК	1840	А
5	Цозгор ХХК	108.3	А
6	Геоогоулд ХХК	178.16	А
7	Баярsgоулд ХХК	693	Х
8	Чинтөгс ХХК	7263	Х
9	Баярsgоулд ХХК	4365	Х
10	Эх ногоон нуур ХХК	535	Х
11	Нутгийн Буян ББН	809.9	Х
12	Геоогоулд ХХК	1559.7	Х
13	Их Монгол Майнинг	2868	Х
14	Мазунай сааруу ХХК	812	Х
15	Мазунай сааруу ХХК	710	Х
16	Эрдэнийн ундарга хайрхан ХХК	62	Х
17	Арвайн Бумба ХХК	290	Х
18	Геоогоулд ХХК	926.04	Х
19	Скай рийч ланд ХХК	99.76	Х
20	Баярsgоулд ХХК	364	Х

3.2. Уянга сумын хүн ам зүй, боловсролын талаарх ерөнхий мэдээлэл

Уянга сум засаг захиргааны нэгжийн хувьд 8 багтай, 2,760 өрхийн 9,498 хүн амтай. Нийт хүн амын 49,4% буюу 4,693 эрэгтэй, 50,6% буюу 4,805 эмэгтэйчүүд байгаа бөгөөд 1 эрэгтэйд 1,02 эмэгтэй ноогдож байна. Үүнээс харахад аймгийн хүйсийн харьцаа 49,4% х 50,6% байна. Тус сумын нийт өрхийн 1,044 нь сум багийн төвд, 1,725 нь хөдөө мал маллан амьдардаг.

График 6. Уянга сумын хүн амын нас хүйсийн суварга



Нийт хүн амын 37,9 хувийг 0-18 насны хүүхдүүд, 56,9% нь хөдөлмөрийн насны иргэд, харин 5,2% -ийг тэтгэврийн насны хүмүүс эзэлдэг байна.

Багуудын тодохойлсноор амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой 1,031 өрхийн 5,994 хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 37,4%, нийт хүн амын 63,1% ийг эзэлж байна. Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 34,3% нь нэн ядуу өрх байна. Сумын хэмжээнд өөрийн гэсэн орон гэргүй 23 иргэн байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй 241 хүн байдаг байна.

Сумын хэмжээнд 19 бүтэн өнчин, 234 хагас өнчин хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 399, үүнээс 280 нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

Тус сумын төвд 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг 1, Жаргалант багд 50 хүүхдийн багтаамжтай нэг цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг ба нийт 20 гаруй багш ажилчид ажилладаг байна. Харин тус сумын хэмжээнд цэцэрлэгийн насны буюу 2-5 насны 604 хүүхэд байдгаас дөнгөж 24,8% буюу 150 хүүхэд сургуулийн өмнөх боловсролыг стандартын дагуу авч, цэцэрлэгийн орчинд хүмүүжиж байна. Цэцэрлэгт хамрагдах хүүхдүүдийн

хувьд тавигддаг хамгийн том шалгуур үзүүлэлт бол тухайн сумын албан ёсны бүүртгэлтэй, хамран суралцах тойргийн хүүхдүүд байх ёстой гэсэн шаардлага бөгөөд энэхүү шаардлагын улмаас бусад аймаг сумдуудаас ирж хувираа алт олборлож байгаа иргэдийн хүүхдүүд хамрагдах боломжгүй байдаг байна. Зуны улиралд Өлтийн хөндийд гэр цэцэрлэг ажиллуулан хувирааа алт олборлогч иргэдийн хүүхдүүдэд үйлчилдэг байна. Улсын төсвөөс цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг төлдөг болсноос хойш батлагдсан орон тооноос илүү хүүхэд авах боломжгүй болсон сөрөг талтай ч нэг хүүхдэд ногдох талбай, тоглоом, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны чанар сайжирч байгаа эерэг үр дагаврууд ажиглагдаж байлаа.

Уянгад ерөнхий боловсролын 2 сургууль байдаг ба нийт 1,842 хүүхэд суралцдаг 1,150 хүүхэд бага ангид, 578 нь дунд ангид үлдсэн 114 хүүхэд нь ахлах ангид суралцаж байна.

Сумын хэмжээнд жилд дунджаар 318 хүүхэд ерөнхий боловсролын сургууль төгсдөг байна. Нийт суралцагчдаас 43,8% нь малчдын хүүхэд, 19 нь бүтэн өнчин, 234 нь хагас өнчин, 241 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байдаг байна. Мөн сумын хэмжээнд нийт 2 дотуур байр байдаг эдгээрт 169 хүүхэд амьдардаг ба үүнээс 158 нь малчдын хүүхдүүд байдаг үлдсэн нь хувиараа алт олборлогч иргэдийн хүүхдүүд байдаг байна. Сургуулиас гадуур байгаа 6-14 насны 39 хүүхэд бүртгэгдснээс, 9 хүүхэд нь сургуульд ерөөсөө орж байгаагүй, үлдсэн нь сургуульд суралцаж байх явцдаа завсардсан хүүхдүүд байна.

3. 3. Хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйчилгээ

Сумын хэмжээнд 2 эмнэлэг байдаг ба эмнэлгийн орны тоо 35 ба эмнэлгийн ашигласан ор хоногийн тоо 9,860. Эмнэлгийн нэг оронд ногдох хүн 281,7 байгаа, ор ашиглалтын хувь 89.0, дундаж ор хоног 5,9 тус тус байна. Сумын эмнэлгийн боловсон хүчний хувьд их эмч 5, сувилагч 9, бага эмч 7 ажилладаг. Эмнэлэг нь автомашин-2, мотоцикл 5, ЭХО хэт авиа 1, электрокардиография 1, хиймэд амьсгалын аппарат-2, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч аппарат -2 -той юм байна.

Сумын эмнэлэгт 2009 онд нийт 188 эх амаржиж, 55 хүн нас барсан байна. Эмнэлгийн үзлэгт 10,512 хүн давхардсан тоогоор эмнэлгийн үзлэгт хамрагдсан байна.

2009 онд сумын хэмжээнд бэлгийн замын халдварт өвчний тохиолдол 158 бүртгэгдснээс заг хүйтэн 79, терхоминаз 76, мөөгөнцөр 3 гарсан байна. харин бусад халдварт өвчний тохиолдол 733 бүртгэгдснээс амьсгалын замын цочмог халдвар 717, халдварт шар өвчин 8, хамуу 3, салхинцэцэг 4, гар хөл амны халдварт өвчин 1 тус тус гарсан байна. Харин халдварт бус өвчлөлийн тохиолдол 2,080 гарсан байна. Нийт 1,497 түргэн тусламжийн дуудлагын дагуу эмч нар өвчтнүүдэд очиж үйлснээс 787 нь алсын дуудлага байсан байна.

3.4. Ажил эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ

Сумын хүн амын 62,1% буюу 5,900 хүн нь хөдөлмөрийн насны хүмүүс байна.

Сумын хэмжээнд нийт 5,247 хүн ажил хөдөлмөр эрхэлдгээс мал аж ахуйн салбарт 3,126 хүн, уул уурхайн компаниудад 165, боловсруулах аж үйлдвэрт 15 хүн, төрийн төсөвт байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн газарт 254, төрийн бус байгууллагад 69 хүн, бусад /өрхийн аж ахуй эрхэлдэг, хувиараа бизнес эрхлэгчид, зочид буудал зоогийн газрын ажилчид, хувиараа бизнес эрхлэгчид гэх мэт/ 1,618 хүн тус тус ажиллаж байна. Сумын хэмжээнд албан бус хөдөлмөр эрхэлдэг тухайлбал бичил уурхайн компаниудын ажилчид, хувиараа алт олборлогч иргэд нийлсэн 2,000 гаруй хүн байна. Сумын хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 101 байгаагаас 30 эмэгтэй ажилгүй иргэн байлаа мөн хөдөлмөрийн чадваргүй 237 хүн байна.

Ажилгүй иргэдийг боловсролоор нь авч үзвэл 84 нь бүрэн бус дунд, 8 нь бүрэн дунд, 8 нь дээд боловсролтой, 1 нь мэргэжлийн анхны шатны боловсрол эзэмшсэн хүмүүс байна. 2009 онд сумын хэмжээнд нийт 96 ажлын байр шинээр бий болжээ. Үүнээс 83 нь уул уурхайн олборлох үйлдвэрийн салбарт, 6 нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 1 нь боловсруулах үйлдвэрт, 1 нь цахилгаан дулааны үйлдвэрлэлд, 1 нь барилга, 2 нь худалдааны салбарт, 1 нь төрийн байгууллагад, 1 нь эрүүл мэнд нийгмийн халамжийн байгууллагад тус тус гарсан байна.

Ажиллагсдыг эдийн засгийн салбараар авч үзвэл 59.5% нь хөдөө аж ахуйн салбарт, 1.75% нь уул уурхайн салбарт, 0.25% нь боловсруулах аж үйлдвэрт, 4.8% нь төрийн болон төсөвт байгууллагад, 1.3% нь ТББ-д, 30.8% нь бусад салбаруудад тухайлбал өрхийн аж ахуй эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчид, банк санхүүгийн байгууллагад ажиллагчид, зочид буудал зоогийн газар, дэлгүүрийн ажилчид байна.

2009 оны 12-р сарын байдлаар сумын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэг нийт 109 хүүхэд байна.

Хүснэгт 16. Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо

Үзүүлэлт		Үүнээс		
		тоо	эрэгтэй	эмэгтэй
Нийт хөдөлмөр эрхлэгч хүүхэд		109	80	29
Үүнээс	Сургуульд суралцдаг хүүхдийн тоо	53	42	11
	Сургуулиас завсардсан хүүхдийн тоо	56	38	18
Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг салбараар нь	ХАА-д	39	26	13
	Уул уурхайд	67	51	16
	Албан бус хэвшилд	0	0	0
	Айлд зарцлагддаг	3	3	0

3.5. Уянга сумын эдийн засгийн байдал


Тус сумын хэмжээд сумын татварын хэлтэст бүртгэлтэй нийт 55 аж ахуйн нэгжүүд, үүнээс төсөвт байгууллага 8, салбар 5, нөхөрлөл 6 , хоршоо 3, хязгаарлагдмал хариуцлагатай компани 32 , 1 шашны байгууллага тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн түүнчлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд худалдаа үйлчилгээний байгууллагуудын талаар судаллаа.

Хүснэгт 17. Уянга суманд үйл ажиллагаа явуулж байгаа цэг, салбарын судалгаа

№	Үйл ажиллагааны чиглэл	Нэгжийн тоо
1	ТҮЦ	4
2	Хүнсний лангуу	18
3	Барааны лангуу	9
4	Чингэлэг	34
5	Гутал засвар	1
6	Хувийн эмийн сан	2
7	Түүхий эдийн ченж	7
8	Бар, ресторан	2
9	Гуанз, цайны газрууд	5
10	Зочид буудал	1
11	Гараж	1
12	Талх, нарийн боовны цех	1
13	Үсчин	3
14	Халуун ус	1
15	Тоглоомын газар	3
	Нийт	91

2009 оны 12-р сарын байдлаар Уянга сум нь улсын төвлөрсөн төсөвт 24045,5 мянган төгрөг, аймгийн төвлөрсөн төсөвт 193928,3 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 173140,6 мянган төгрөгийн орлого тус тус оруулсан байна.

График 7. Уянга сумын төсвийн орлого



Уянга суманд ХААН банк, Монгол шуудан банкны салбарууд үйл ажиллагаа явуулдаг ба үйлчлүүлэгчдэд нийт 7 төрлийн зээлийн багцыг санал болгодог байна. Үүнд:

Хүснэгт 18. Зээлийн төрлүүд

Зээлийн төрлүүд	Нийт олгож буй зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
Бизнесийн зээл	49%	500,0-5,000,0 төгрөг хүртэл
Малчны зээл	30%	200,0-2,000,0 төгрөг хүртэл
Цалингийн зээл	5%	цалингийн хэмжээнээс хамаарч 1-10 сарын цалинтай тэнцэх
Тэтгэврийн зээл	7%	тэтгэврийн хэмжээнээс хамаарч 1-10 сарын тэтгэвэртэй тэнцэх
Лизинг	5%	100,0-1,000,0 төгрөг хүртэл
Орон сууц барих худалдан авах зээл	2%	5,000,0-30,000,0 төг хүртэл
Хадгаламж барьцаалсан зээл	2%	нийт хадгаламжийн 75%-тай тэнцэх

2009 оны байдлаар Монгол шуудан банк иргэд аж ахуйн нэгжүүдэд зээл олгоогүй ба харин ХААН банк нийт 700-800 сая төгрөгийн зээлийг гаргасан

байна. Сумын банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү 8,4%- 10%, хугацаатай хадгаламжийн жилийн хүү 9,6%-19,8% байлаа.

№	Автомашины болон өрөө явагч хэрэгслийн төрлүүд	Өвөрхангай аймгийн хэмжээнд	Уянга суманд
1	Мотоцикл	3263	367
2	Хүнд машин механизм	68	67
3	Чиргүүл	112	10
4	Суудлын машин	2902	429
5	Ачааны машин	2032	96
6	Автобус	1214	64
7	Тусгай зориулалтын машин	29	-

Дээрх мэдээллээс харахад Өвөрхангай аймгийн хэмжээнд 68 уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн машин механизм байдгаас 67 нь Уянга суманд байгаа нь Уянга сум уул уурхайн үйлдвэрлэлийн хувьд тэрүүлэгч том төв болох нь харагдаж байна.

3.6. Уянга сумын хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал

Мал аж ахуй: 2009 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 225,887 толгойд хүрч, үүнээс тэмээ 8, адуу 11,498, үхэр 32,419, хонь 88,532, ямаа 93,430 байна. Малчин өрх 1,990, малгүй өрх нь 779 байна. 10 хүртэл малтай 178 өрх, 11-30 тооны малтай 308 өрх, 31-50 малтай 223 өрх, 51-100 малтай 408 өрх, 101-200 малтай 571 өрх, 201-500 малтай 271 өрх, 501-999 малтай 23 өрх, 1000-1499 малтай 7 өрх, 1500 -2000 малтай өрх байхгүй, харин 2000 дээш малтай 1 байдаг байна.

Нийт малчин өрхийн 858 нь нарны цахилгаан үүсгэвэр, 141 нь салхины цахилгаан үүсгэвэр, 22 нь бага оврын цахилгаан үүсгэвэр мотор, 7 нь бусад төрлийн үүсгэвэр ашиглан цахилгаанаа гаргадаг байна. 227 малчин өрх давхардсан тоогоор 232 машинтай, мөн 555 малчин өрх мотоцикльтай, 1 малчин өрх трактортай байна.

2009 оны 1-сарын байдлаар Өвөрхангай аймгийн нийт сумын 45 гаруй хувьд нь зудны нөхцөл байдал үүссэн байна. Өнөөдөр Уянга сумын малчид зудтай тэмцэж, байгалийн хахир хатуу нөхцлийн даван туулахын төлөө нойр хоолгүй зүтгэж ажиллаж байгаа боловч нийт 5,235 мал хорогдуулснаас адуу 412, үхэр 1,542, хонь 1,253, ямаа 228 тус тус хорогджээ.

Газар тариалан: Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 11,4 га-д төмс, 2,1 га-д хүнсний ногоо тариалж намрын ургац хураалтаар 66,4 тонн төмс, 11 тонн хүнсний ногоо хураан авчээ. Аж ахуйн нэгж иргэд 41,4 тонн өвс, 79,7 тонн гар тэжээл бэлджээ.

Уянга суманд нийт 5 худаг шинээр гаргасан. 2009 оны эцэст хийсэн худгийн тооллогоор нийт 24 худаг тоологдсноос инженерийн худаг 19, энгийн уурхайн 5 худаг байна. Нийт худгийн 7 нь хувийн аж ахуйн нэгжийнх, 12 нь бэлчээрт байршдаг худаг, 5 ашиглагддаггүй эвдэрсэн худаг байна.

3.7. Нийгмийн сахилга, дэг журам

Сумын цагдаагийн тасгийн мэдээгээр 2009 оны 12-р сарын байдлаар 48 хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн хэргийн 35,5% нь иргэдийн өмчийн хулгай, 29% нь иргэний эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 9% нь танхай, 5,9% нь эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэг байна.

Хүснэгт 19. Гэмт хэргийн төрөл¹⁸

Гэмт хэргийн төрөл	2007	2008	2009
Үйлдэгдсэн бүх хэрэг	56	57	48
Бусдыг амь насыг санаатай хөнөөсөн	3	1	3
ИЭЧЭМЭ	29	29	23
Албан тушаалын хэрэг	0	0	0
Танхай	7	1	2
Хүчин	0	0	1
Дээрэм булаалт	1	1	0
Иргэдийн өмчийн хулгай /мал, орон байр/	11	13	5
Хөдөлгөөний аюулгүй байдлын	3	6	6
Бусад хэрэг	3	4	8
Холбогдогч тодорхойгүй	2	-	5

¹⁸ 2007, 2008, 2009 онуудын Өвөрхангай аймгийн Цагдаагийн газраас гаргасан гэмт хэргийн бүртгэлүүдээс харьцуулан харуулав

2.7. Уянга сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

Сумын 2009 оны нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг доорхи хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 20. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	х/н	2009
1	Газрын сан	га	313,936
2	ХАА-н эдэлбэр газар	Га	274,319
3	Нийт өрх	тоо	2,760
4	Нийт хүн ам	тоо	9,498
5	Хөдөлмөрийн насны хүн ам	тоо	5,900
6	Эдийн засгийн идэвхтэй хүн ам	тоо	5,348
	Үүнээс: - ажиллагсад	тоо	5,247
	бүртгэлтэй ажилгүйчүүд	тоо	101
7	Хөдөлмөрийн чадваргүй хүн ам	тоо	237
8	Инфляцийн хурд /аймгийн жишгээр/	Хувь	3,8
9	Хөрөнгө оруулалт	Сая.төг	249,1
10	ЕБС-д суралцагсад	Тоо	1,842
11	Сургуулийн багш нар	Тоо	66
12	Эмч, сувилагч	Тоо	21
13	Эмнэлгийн нийт ор	Тоо	35
14	Малын тоо	Толгой	225,887
15	Тариалсан талбай	Га	13,5
16	Хураасан ургац	Тонн	77,4
17	Бүртгэлтэй аж ахуйн нэгж	тоо	55

БҮЛЭГ 4

УЯНГА СУМЫН ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ХҮН АМ ЗҮЙН БОЛОН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ



4.1. Уянга сумын ашигт малтмалын нөөц, уул уурхайн салбарын өнөөгийн байдал, бичил уурхай үүссэн түүхээс

Социализмын үед уг сумыг Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол бүс нутаг болгон хөгжүүлж байсан түүхтэй. Социалист системийн уналт, жил дараалан тохиолдсон ган зуд зэрэг байгалийн гамшгуудаас шалтгаалан малчид өөрсдийн эрхэлж байсан хөдөө аж ахуйн бизнес, үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болсон. Тиймээс орон нутгийн иргэд орлого олох, амьжиргаагаа залгуулах өөр өөр боломжуудыг хайн зарим нь хот суурин газар луу нүүж, үлдсэн зарим хэсэг нь хувиараа алт олборлон амьжиргаагаа залгуулах болсон байна.

Өнөөгийн байдлаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлт, Бөөрөлжүүтийн хөндийд байрлаж буй гар аргаар алт олборлогч иргэд нь Улаанбаатар хотоос 495-508 км зайд, Арвайхээр сумаас 65-78км зайд, Уянга сумын төвөөс 1 км зайтайгаар хойш буюу зүүн хойш чиглэлтэйгээр уртаашаа 18км, өргөнөөрөө 4км орчим талбайд тархан байрлаж байна.

Хувиараа алт олборлогч иргэдийн байрлаж буй талбайн дийлэнх хэсэг нь буюу 97 орчим хувь нь хуучнаар Эрэл компаний ашиглалтын талбай одоогоор Чех Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай АУМ ХХК-ны ашиглалтын талбай байна.

Өвөрхангай аймгийн Уянга суманд 1993 онд алтны нөөц байгааг тогтоосон бөгөөд үүнээс хойш Эрэл ХХК 1993-2005 онд бие даан нийт 5,2 тонн алт олборлож, угаасан эфел дээр нь ажилладаг иргэд, бичил уурхайн компаниудын тоо жил тутам нэмэгдсээр иржээ. Эрэл компани нь 15 жил ажиллаж 5,2 тонн алт олборлохдоо сорчлон ашигласнаас одоог хүртэл уурхайн эфел нь алтны агууламжтай байна.

Эрэл ХХК нь энэ хугацаанд Өлтийн амны 251,6 га-д алт олборлох үйл ажиллагаа явуулжээ. Гэтэл Эрэл ХХК-ний олборлолтод өртсөн Өлтийн амны 251,6 га талбайд 2002 оноос хойш жил бүр 5,000-30,000 гаруй хувиараа алт олборлогч нар, 20-60 гаруй бичил уурхайн компаниуд ажиллаж, алт олборлосноор ирсэн байна.

Эрэл ХХК нь 2007 оны сүүлчээр Уянга суман дахь ашиглалтын тусгай зөвшөөрлөө Монгол Чехийн хамтарсан АУМ ХХК-д шилжүүлсэн байна. Эрэл ХХК-ний лицензийг шилжүүлэн авсан АУМ ХХК нь 2008 оноос ашиглалтын 251,6 га талбайдаа 60 гаруй бичил уурхайн компаниудтай эфел ашиглах гэрээ байгуулан ажиллуулж байна.

Судалгаа хийж байх явцдаа хувиараа алт олборлогч иргэдийн нийт гэр, оромж, дуганцаг зэргийг тоолж гаргалаа. Тооллогын дүнгээс харахад Зүүн Баруун модот мухар хэмээх газар нутгийн голдуу 80 гаруй өрх, Зүүн Бүргэдэйд 250 гаруй өрх, Хүрэн хошууд 200-аад өрх, алт олборлогч иргэдийн нэрлэж заншснаар Нарантуул гэдэг газарт 150-иад өрх, Бор хошуунд 70 гаруй өрх, Улаан хадны энгэр буюу Хар хадны эрэгт 20 өрх, Өндөр толгой болон Хүүшийн аманд 120- иод өрх нийтдээ 890 гаруй гэрээр хороолол маягаар нэг дороо бөөгнөрөн суурьшсан байлаа. Ер нь нэг гэрт

дунджаар 6,2 хүн амьдарч байна гэж үзвэл өнөөдөр 5,518 хүн байх магадлалтай боловч нийт гэрүүдийн 30 орчим хувь нь эзэнгүй, хүмүүс нь гэрээ айлынхаа хүнд захиж орхин Говь Алтай аймаг руу алт олборлох боломж хайн явсан гэж нутгийн хүмүүс ярьж байлаа. Өнөөдөр ойролцоогоор 3,500 гаруй хүн хувиараа алт олборлох үйл ажиллагааг Өлтийн хөндийд хийж байна.

Орон нутгийн засаг захиргааны зүгээс хувиараа алт олборлож байгаа иргэдийг зохион байгуулалтад оруулах, тэдний байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2007 оноос хойш удаа дараа арга хэмжээ авч ажиллаж ирсэн байна. Тухайлбал алт олборлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор тус сумын Өлт, Бөөрөлжүүтэд үүсээд байгаа нөхцөл байдал, хууль бусаар худалдаа наймаа эрхэлж буй иргэдийн хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 15, цагдаагаас 15, онцгой байдлаас 10, байгаль орчин аялал жуулчлалын газраас 5, сумаас 15 бүгд 60хүний бүрэлдэхүүнтэй баг 5 хоног ажиллан Өлтийн хөндийд худалдаа гуанз ажиллуулж буй өрхүүдийг 4 газар төвлөрүүлэн хууль бус эм, шатах, тослох материал, согтууруулах ундаа худалдахыг хориглож, орчны хог хаягдлыг цэвэрлүүлсэн байна. Үүний зэрэгцээ ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж нөхөн сэргээлтийн ажлын явцад шалгалт хийжээ.

Мөн 2005 онд Уянга суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийг бүртгэлжүүлэх ажлыг улс, аймаг, сумын Иргэний Бүртгэл мэдээллийн төвийн ажилтнууд хамтран хийх оролдлогыг хийсэн боловч төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Мөн 2008 онд улсын хэмжээнд хувиараа алт олборлож байгаа иргэдийг бүртгэлжүүлэх ажлыг улс, аймаг сумын нийгмийн халамж үйлчилгээ, иргэний бүртгэл мэдээллийн төвээс явуулсан боловч Уянга суманд алт олборлогч иргэдийг үнэн зөв тоолж, бүртгэлжүүлж чадаагүй байна.

Эндээс харахад энэхүү үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байгаа нь ажиглалт, ярилцлагын явцад харагдаж байлаа. Бичил уурхайг хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөгжүүлж чадсан тохиолдолд олон тооны ажлын байр бий болох, ажилгүйдэл ядуурал буурах, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах боломж асар их байгаа нь харагдсан. Өнгөрсөн хугацаанд засгийн газар бичил уурхайтай холбоотой хэд хэдэн чухал эрх зүйн акт, журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай Засгийн газрын 28-р тогтоол
2. Монгол улсын засгийн газрын Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр
3. Монгол улсын засгийн газрын хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, 72-р тогтоол


Эдгээр тогтоол, журмуудыг гарган мөрдүүлэх ажлууд энэ суманд хангалтгүй явагдсан байна. Зөвхөн санхүүгийн боломжтой хувь хүмүүс компани байгуулан машин техник ашиглан бичил уурхайн хэлбэрээр алт олборлосноор иржээ. Харин бусад орон нутгаас орлого олох, амьжиргаагаа залгуулахаар ирсэн ядуу иргэдийн хувьд хөдөлмөрийн бүтээмж муутай, гар багаж хэрэгслээр алт олборлох хүнд, амь өрссөн ажлыг хийж өдөр хоногийг өнгөрөөж байна.

Судалгаанд хамрагдсан алт олборлогч иргэдийн нас хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, шилжилт хөдөлгөөний талаар энэ бүлэгт харуулна.

4.2. Хүн ам зүйн шинж байдал

Уянга суманд алт олборлож байгаа алт олборлогч иргэдийн 67,4%-ийг эрэгтэйчүүд, 32,6%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүйсийн харьцаа 1,9 буюу нэг эмэгтэй тутамд 1,9 эрэгтэй ноогдож байна. Энэ нь шороон ордод алт олборлох үйл ажиллагааг эрхлэхэд ялангуяа нүшх ухах, нүхнээс шороогоо зөөж гаргах, давчуу хүйтэн харанхуй нөхцөлд газар доор удаан хугацаагаар биеийн хүчний ажмал эрхлэн удаан хугацаагаар ажиллах маш хүнд хэцүү тул эрэгтэйчүүдийн оролцоог ихээр шаарддагтай холбоотой юм.

График 8. Хүн амын нас хүйсийн суварга



Судалгааны явцад 19-24 насны эрэгтэйчүүд, 36-40 насны эмэгтэйчүүд хувиараа алт олборлох үйл ажиллагаанд нилээд идэвхтэй оролцож байгаа нь харагдаж байлаа. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олоборлогчдын дундаж нас 32,2 байлаа.

Ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа үргэлжлүүлэн их, дээд сургууль, коллежуудад элсэн орж чаддаггүй, хот суурин газрууд болон хөдөө орон нутагт ажлын байр дутмаг зэрэг шалтгааны улмаас залуучуудын дунд алт олборлож мөнгө олох явдал элбэгшиж байна.

Харин 24-өөс доош насны эмэгтэйчүүдийн алт олох ажилд оролцдогч хэдий ч тэдний хувьд гэр орны ажил, бага насны хүүхдээ асрэх, хоол цай хийх, юм угаах, цэвэрлэх, жижиг худалдаа наймаа хийх, хоол хийж зарах зэрэг ажилд илүү оролцдог байна.

Харин алт олборлох ажилд 36-40 насны эмэгтэйчүүд нилээд түлхүү хийж байгаа нь судлагаанаас дүнгээс харагдаж байна.

4.3. Уянга сумын хувиараа алт олборлогч иргэдийн гэрлэлтийн байдал

Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн гэрлэлтийн байдал, гэр бүлийн бүтцэд хийсэн ажиглалт судалгаанаас харахад нийт оролцогчдын 55,5% нь баталгаатай гэр бүлтэй гэж хариулж байсан ч “шороо дагаж” амьдралаа залгуулах шаардлагын эрхээр гэр бүл, үр хүүхдээсээ хол амьдраад удаж байна гэж хариулж байлаа. Харин 21% нь ганц бие залуучууд, 10% нь хамтран амьдрагчийнхаа хамт амьдардаг, 8% нь бэлэвсэн, 5,5% нь гэр бүлээсээ салсан хүмүүс байлаа.

Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн хувийн жин, сонгогдсон үзүүлэлтүүд

Сонгогдсон үзүүлэлт	Өлтийн орд
Хүйс	
Эрэгтэй	67,4%
Эмэгтэй	32,6%
Насны бүлэг	
16-18	13%
19-24	30%
25-30	33%
31-35	26%
36-40	36%
41-45	27%
46-50	20%
51-55	9%
56-60	5%
61 ба түүнээс дээш	1%

Гэрлэлтийн байдал

Гэрлэсэн	55,5%
Ганц бие	21%
Хамтран амьдардаг	10%
Бэлэвсэн	8%
Салсан	5,5%


Тухайн орон нутагт бүртгэлтэй эсэх

Бүртгэлтэй	18%
Бүртгэлгүй	82%

Бүгд	100%
------	------

Судалгаанд 16-аас дээш насны хувиараа алт олборлогч иргэдийг хамруулсан ба 56 ба түүнээс дээш насны хүмүүс хамгийн бага хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 82% нь өөр орон нутгаас ирсэн Уянга суманд бүртгэлгүй, шилжилт хөдөлгөөнөө зохих журмын дагуу хийлгээгүй байсан.

График 9. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн гэрлэлтийн байдал



Өлтийн алтны уурхайд ажиллаж байгаа хүмүүсийн гэр бүлийн байдалд хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнд энд ажиллаж байгаа ихэнх хүмүүс нь гэр бүлтэй боловч гэр бүлээсээ ажиллаж байна. 25-аас доош насны эмэгтэйчүүдийн хувьд алт олборлох ажлыг хийж эхэлснээсээ хойш найз залуутай буюу хамтран амьдрагчтай болсон гэж хариулж байлаа.

Би Архангай аймгийн Чулуут сумаас хамаатныхаа хүнийг дагаж алт олохоор ирсэн. Энд ирээд Дундговийн залуутай танилцаж, хамтран амьдраад 2 жил болж байна. Эмэгтэй хүний хувьд алт олборлоно гэдэг маш хэцүү ажил. Нүх ухах, алттай шороогоо бусдад дээрэмдүүлэхгүй байх, өөрийгөө янз бүрийн хүмүүсээс хамгаалах гэх мэт олон дарамт, хүндрэлүүдтэй тулгардаг байлаа. Найзтайгаа хамтран ажилладаг болсоноос хойш байдал дээрдсэн, бид хоёр амьдралдаа хүрэлцэхүйц мөнгөө хийснийхээ дараа гэр бүлээ батлуулна.

21 настай, эмэгтэй, Ц

Эрэгтэй хувиараа алт олборлогч нартай хийсэн бүлгийн ярилцлагын үеэр эрэгтэйчүүдийн ихэнх нь гэр бүлээсээ тусдаа амьдардаг, гэртээ мөнгөтэй болсон үедээ хааяа нэг очдог байснаа, харин сүүлийн үед эндхийн алтны нөөц багассанаас орлого нь эрс буурсан учраас харьж чадахаа байсан тухайгаа ярьж байлаа. Мөн гэрлэсэн эрэгтэйчүүдийн дунд алт олборлож байх хугацаандаа гэр бүлээс гадуур харилцаанд орж, хамтран амьдардаг бйадал их байна.

Би Булган аймгаас ирсэн. Олж байгаа юм бага учраас гэр бүлдээ тэр бүр мөнгө явуулж, очиж уулзаад байж чаддаггүй. Жилд ганц удаа л харьдаг. Энд алтны гарц муудаж байгаа учир энэ хавар Говь-Алтайн Бигэр сум руу галынхантайгаа явна. Ойр байхдаа очиж чаддаггүй юм чинь Бигэр явбал бүр холдоод хэцүүдэх л байх даа...

35 настай, эрэгтэй, Ч

Хүснэгт18 . Өрхийн ам бүлийн байдал

Ам бүлийн тоо	Эзлэх хувь
1 – 2	16%
3 – 4	29%
5 – 6	37%
7- оос дээш	18%
Нийт	100%

Судалгаанд хамрагдсан иргэдийн 35% нь гэр бүлийнхээ хамт Өлтийн уурхайд амьдарч алт олборлож байгаа ба нэг гэр бүл нь дунджаар 5 гишүүнтэй байлаа. Бусад хүмүүсийн хувьд найз нөхөд, хамаатан садангуудтайгаа нийлж “нэг гал” болон нэг гэр, оромж дуганцагт 6-12-уулаа амьдарч байлаа.


Хувиараа алт олборлох үйл ажиллагаа тогтмол эрхэлж байгаа 500 хүний ард дунджаар 4 гэр бүлийн гишүүд болох эхнэр, хүүхэд, өндөр настай эцэг эх, өвөө эмээ, хөдөлмөрийн чадваргүй хүмүүс байна гэж үзвэл алтнаас олох орлогоос дунджаар 2000 гаруй хүний амьдрал, амьжиргаа шууд

хамааралтай байгаа нь харагдаж байна. Үүнээс үзэхэд нийгэм, хууль эрх зүйн хүрээнд бүрэн утгаараа хүлээн зөвшөөрөгдөөгүй “хууль бус” хэмээн нэрлэгдэж, хөөгдөж туугдан, дарамт шахалтан дор ажиллаж, амьдарч байгаа хэдий ч хувиараа алт олборлогчид маань гэр бүлийнхээ өмнө, цаашилбал орон нутгийн, аймаг улсын хэмжээнд төр, засгийн газрын хүлээх ёстой үүрэг, хариуцлагыг үүрэлцэж, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмрийг оруулж байна.

4.4. Бичиг үсэг тайлагдалт, боловсролын байдал

Судалгаанд хамрагдсан иргэдийн 91% нь бичиг үсэг мэддэг, 9% нь бичиг үсэг мэддэггүй гэж хариулсан байна¹⁹. Ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа үргэлжлүүлэн их, дээд сургууль, коллежуудад элсэн орж чаддагүй, орон нутагт ажлын байр дутмаг байдаг зэрэг шалтгааны улмаас залуучуудын дунд алт олборлож мөнгө олох явдал элбэг байгаагийн нэг тод жишээ энд харагдаж байлаа.

График 10. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогчдын боловсролын түвшин, хүйсээр



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин эмэгтэйчүүдийн хувьд эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр байлаа. Энэ нь Монголчуудын эмэгтэй хүүхдээ хайрлан гэр бүл, үр хүүхэдтэй болохоос нь өмнө мэргэжил боловсрол эзэмшүүлэхийг чухалчилдаг уламжлалт хандлага, харин эрэгтэй хүүхдүүдийг хар бор ажил ч болсон хийгээд амьдралаа залгуулчихна, гэрлэж

¹⁹ Бичиг үсэг тайлагдалтын улсын дундаж 97,6% (2008 оны Монгол улсын Статистикийн эмхэтгэл)

үр хүүхэдтэй болсон ч сурахад оройтохгүй гэж үздэг өрөөсгөл ойлголт, хандлагатай холбоотой юм.

4.5. Хувиараа алт олборлогч иргэдийн давхар ажил эрхлэлтийн байдал

Судалгаанд оролцогчдын давхар ажил эрхлэлтийн байдлыг судалж үзэхэд ихэнх хувь нь буюу 78% нь дан ганц алт олборлох ажил эрхлэн амьжиргаагаа залгуулдаг, харин үлдсэн 22% нь мал аж ахуй эрхлэх, гэрээр хүнсний өргөн хэрэглээ, шатах, тослох материал, түлээ нүүрс зарах зэрэг худалдаа наймаа хийх, хоол цай хийж гэр гуанз ажиллуулах, алт худалдаж авах, дулааны улиралд билльярд тоглуулах, хүн ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх, ус зарах зэрэг бизнесийг алт олборлох үйл ажиллагаатай давхар эрхлэн нэмэлт орлого олдог болох нь харагдаж байлаа.

Хүснэгт 19. Хувиараа алт олборлогч иргэдийн ажил эрхлэлтийн байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Өлтийн орд
Давхар ажил эрхлэлт	
Ажил эрхэлдэг	22%
Ажил эрхэлдэггүй	78%
Хувиараа ашигт малтмал эрхэлж буй хугацаа	
1 жил хүртэл	5%
1-3 жил	28%
4-7 жил	32%
8-11 жил	21%
12-15 жил	9%
15-18 жил	5%
19 дээш	0
Нийт	100%
Хувиараа ашигт малтмал олборлож байгаа дундаж хугацаа	6,3 жил

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 32% нь хувиараа алт олборлох ажлыг 4-7 жилийн хугацаанд эрхэлж байгаа бөгөөд ажил эрхлэлтийн дундаж хугацаа нь 6,3 жил байна. Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай болон өрх толгойлсон эмэгтүүчүүд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд давхар ажил хөдөлмөр эрхлэх явдал байхгүй байсан ба тэдний амьжиргааны түвшин бусад хүмүүстэй харьцуулахад харьцангуй доогуур байлаа. Эдгээр хүмүүс тээвэрлэлтийн явцад хаягдсан алттай шороог

шүүрдэн авч угаах замаар орлого олдог байна. Харин залуу, эрүүл, биеийн хүчний ажил хийж чадахуйц эрэгтэй хүмүүсийн хувьд эрүүл газарт 20-оос дээш метрийн гүнтэй нүх ухан судал гаргаж, олборлолт хийж байна. Мөн бага цалинтай болон улирлын чанартай ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, малчид орлогоо нэмэгдүүлэх зорилгоор хувиараа алт олборлодог байна.

Кейс -2

Би 56 настай Уянга сумын уугуул иргэн. Би бага охинтойгоо хамт шороо шүүрдэж, паажгараар алт ялгаж авдаг. Хэдийгээр шороо тоос ихтэй хэцүү байдалд ажилладаг ч хоногийн хоолоо л арай гэж залгуулах мөнгө олдог. Бүл хүчтэй хүмүүсийн адил газар шороо ухаж чадахгүй юм, тэгвэл арай л дөнгүүр амьдрах байсан байх даа....

Ярилцагч 56 настай, эмэгтэй, А

3.5. Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл

Хүн амын шилжих хөдөлгөөн Монгол улсын үндсэн хуулиар баталгаажуулсан эрхийн нэг бөгөөд иргэн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох, нийгмийн суурь тусламжийг хүртэх эрхтэй. Монгол улс хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг үндсэн хууль, иргэний бүртгэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн баримтаар зохицуулдаг.

Бид хувиараа алт олборлогч иргэдийн шилжилт хөдөлгөөнд оролцож буй байдал, тэдний орон нутгийн иргэний бүртгэлд хамрагдалттай холбоотой асуудлыг энэ хэсэгт харуулав.

Судалгаанд хамрагдсан 500 хувиараа алт олборлогч иргэдийн 18% нь Уянга сумын бүртгэлтэй уугуул оршин суугчид, үлдсэн 82% нь тухайн орон нутагт бүртгэлгүй, алт олборлохоор ирсэн хүмүүс байлаа. Гадны орон нутгаас ирэн бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн дийлэнх хэсэг нь Булган аймгийн Рашаант, Дашинчилэн, Хишиг Өндөр, Архангай аймгийн Чулуут, Цэнхэр, Төвшрүүлэх, Цэнхэр, Цэцэрлэг, Дундговь аймгийн хойд болон баруун хойд талын сумдуудын иргэд байсан ба ерөнхийдөө Монгол улсын 19 аймгаас ирсэн хүмүүс байсан ба энэхүү судалгааны санамсаргүй аргаар хийсэн түүвэрлэлтэнд Баян-Өлгий, Ховд, Дорнод аймгаас ирсэн хүмүүс хамрагдаагүй байлаа.

График 9. Уянга суманд алт олборлогчдын тоо

/жил бүрийн 7 сарын байдлаар /



Уянга сумын Өлт, Бөөрөлжүүлтийн хөндийд иргэд хувиараа алт олборлох үйл ажиллагаа эрхлэх болсон 20 гаруй жилийн хугацаанд тус суманд хувиараа алт олборлож байгаа хүмүүсийн тоо харилцан адилгүй байсан. Хувиараа алт олборлогчдын тоо нь улирлын байдлаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд дулааны улирал, оюутан, сурагчдын амралт эхэлсэн үед ажиллагсдын тоо эрс нэмэгддэг.

Эрэл ХХК-ий олборлолтод өртсөн Өлтийн амны 251,6 га талбайд 2002 оноос хойш хувиараа алт олборлогчдын тоо огцом өсч оргил үедээ буюу 2004, 2005 онуудад 30,000–д хүрч байсан тоо баримтыг судалгаанд оролцогч талууд өгч байлаа.

Эдгээр иргэдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, үйл ажиллагааг нь зохицуулах, бүртгэлжүүлэх оролдлогыг сум, аймгийн засаг захиргаанаас лиценз эзэмшигч том компаниудтай хамтран удаа дараалан хийж байсан ч дорвитой үр дүнд хүрч чадалгүй байсаар өдийг хүрсэн байна.

Судалгааны багийнхан тус хөндийд ажиллаж байсан хувиараа алт олборлогч иргэдийн нийт гэр, оромж, дуганцаг зэргийг 2010 оны 1-р сарын байдлаар тоолж гаргалаа. Тооллогын дүнгээс харахад Зүүн, Баруун Модот Мухар хэмээх газар нутгийн голдуу 80 гаруй өрх, Зүүн Бүргэдэйд 250 гаруй өрх, Хүрэн Хошуунд 200-аад өрх, алт олборлогч иргэдийн нэрлэж заншснаар “Нарантуул” гэдэг газарт 150-иад өрх, Бор Хошуунд 70 гаруй өрх, Улаан Хадны энгэр буюу Хар хадны эрэгт 20 өрх, Өндөр толгой болон Хүүшийн аманд 120-иод өрх, нийтдээ 890 гаруй гэрээр тосгон маягаар нэг доргоо бөөгнөрөн суурьшсан байлаа.

Ер нь нэг гэрт дунджаар 6,2 хүн амьдарч байна гэж үзвэл өнөөдөр 5,500-гаад хүн байх магадлалтай боловч нийт гэрүүдийн 30 орчим хувь эзэнгүй, хүмүүс нь гэрээ айлынхаа хүнд захиж орхин Говь Алтай аймаг руу алт олборлох боломж хайн явсан гэж нутгийн хүмүүс ярьж байлаа.

Сүүлийн саруудад Өлтийн хөндий дэхь алтны гарц өмнөхтэйгөө харьцуулахад улам буурч байгаатай холбоотойгоор өөр аймаг, сумд, хотоос ирсэн алт олборлогч иргэд олноороо буцаж, өөр гарц сайтай газар хайх боллоо гэж нутгийн иргэд ярьж байлаа.

БҮЛЭГ 5

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ОРЛОГО БА ЗАРЛАГА



Судалгаанд Уянга сумын хувиараа алт олборлогч 500 иргэнийг хамруулсан бөгөөд тэдгээр бүлэг иргэдийг эдийн засгийн идэвхитэй хүн ам болон орлого олох зорилготойгоор ажил эрхэлж байгаа ажиллах хүч хэмээх ойлголтод хамааруулсан болно. Судалгаагаар алт олборлох болсон шалтгаан, олж буй орлого, түүний зарцуулалт, хуримтлалын асуудлыг тодрууллаа.

5.1. Алт олборлох шалтгаан

Хувиараа алт олборлогчдоос анх алт олборлох ажилд татагдан оролцох болсон шалтгааныг нь тодруулан асуухад нэгж оролцогч нэгээс дээш сонголтоор хариулж давхардсан байдлаар дараах хариултуудыг өгсөн.

Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан иргэдийн хувиараа алт олборлож эхэлсэн шалтгаан, хувийн жин

Үзүүлэлт	Хувиар
Хувиараа алт олборлох болсон шалтгаанууд	
Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх	35.1
Орон байр авах	15.1
Өр зээлээ төлөх	17.6
Эмчилгээний зардал олох	12.0
Ажлын байргүй	68.4
Амьжиргаа залгуулах	72.1
Зуданд малаа алдсан	35.0

Алт олборлож эхэлсэн шалтгааныг судлахад 72,1 хувь нь амьжиргаагаа залгуулах, 68,4 хувь нь ажилгүйдлийн улмаас, 35 хувь нь зуданд малаа алдсны улмаас, 35,1 хувь нь хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, 17,6 хувь нь өр зээлээ төлөх, 15,1 хувь нь орон байрныхаа нөхцөл байдлыг сайжруулах, 12 хувь нь эмчилгээний зардал олохын тулд анх алт олборлож эхэлсэн гэж хариулсан байна.

5.2. Алт олборлолтын хэмжээ, мөнгөн орлого

Хувиараа алт олборлогч иргэдийн өдөрт, долоо хоногт, сард олборлодог алтны хэмжээг тодорхойлох замаар тэдний орлогын хэмжээг, цаашилбал сум орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодрууллаа. Шороон орд дээр ажилладаг хувиараа алт олборлогч иргэдийн хувьд тэдний өдөрт олборлодог алтны хэмжээг тодорхойлоход нэлээд хэцүү байлаа. Яагаад гэвэл Уянга суманд алт олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн хөдөлгөөнүүд, том болон бичил уул уурхайн компаниуд хүлээн зөвшөөрдөггүй ба удаа дараа зохион байгуулалтад оруулах нэрэн дор хөөх, тараах арга хэмжээ, оролдлогуудыг хийж байсан учир хувиараа алт олборлогч иргэд нэлээд нээлттэй бус, асуулгад оролцохоосоо зайлсхийх, зугтаах, худал мэдээлэл өгөх, орлогоо дарах, нууцлах сөрөг хандлагуудыг гаргаж байсан юм.

Хүснэгт 21. Хувиараа алт олборлогчдын өдөрт/ долоо хоногт/ сард олборлож буй алтны хэмжээ, мөнгөн орлогын дундаж

Үзүүлэлт	Мөнгөн орлого° /дунджаар/	Эзлэх хувь	Хувиараа алт олборлогч нарын тоо
Өдөрт олборлодог алтны хэмжээ /граммаар/			
0-0.5 грамм	0- 19,330	78.5	393
0.5-0.75 грамм	19,331-28,995	13.5	67
0.75-1.0 грамм	28,996-38,660	6	30
1.0-1.5 грамм	38,661-57,990	2	10
1.5-2.0	57,991-77,200	-	
2.0+	77,201+		
Долоо хоногт олборлодог алтны хэмжээ /граммаар/			
0-1 грамм	0-38,660	7.1	35
1-2 грамм	38,661-77,320	48	240
2 -3 грамм	77,321-115,980	35.9	180
3 -4 грамм	115,981-154,640	7	35
4 ба түүнээс дээш	154641+	2	10
Сард олборлодог алтны хэмжээ /граммаар/			
0-5 грамм	0-193,300	18.5	93

° Уянгын Өлтийн уурхайн гэр дэлгүүрүүдэд 2010-оны 01-р сарын байдлаар 1 цэн алтыг 145,000 төгрөгөөр авч байлаа.

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

5.0-10.0 грамм	193,301-386,600	55.3	276
10.0-15.0 грамм	386,601-579,900	22.1	110
15.0-20.0 грамм	579,901-773,200	3	15
20.0+	773,201+	1.1	6

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн сарын дундаж орлогыг тооцож үзэхэд 310,000 төгрөг байлаа. Алтны орлого нь Өлтийн шороон ордны алтны олдоц, гарц, ашиглаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүчин чадал, хөдөлмөрийн бүтээмж, ажиллаж буй хүмүүсийн дадлагажилт, ур чадвар, нас хүйс зэрэг олон хүчин зүйлээс хамааран харицлан адилгүй байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн бүтээмж нь эмэгтэйчүүдийнхээс харьцангуй их байгаа нь харагдаж байна. Мөн зарим үед гарсан зардлаа ч нөхөж чадахгүй байх үе их тохиолддог хэмээн ярьж байлаа.


Уянга суманд төсвийн байгууллагад ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж цалин 237,000²⁰ уул уурхайн компаний ажилчдын сарын дундаж цалин 275,000²¹ төгрөг байхад хувиараа алт олборлогч иргэдийн сарын дундаж орлого 310,000 төгрөг байлаа. Эндээс харахад орлого их олох боломжтой, ажил олгогчийн зүгээс дарамт шахалт бага, мэргэжил мэдлэг шаарддаггүй, харьцангуй эрх чөлөөтэй, гэр бүлээрээ хийх боломжтой ажил учир иргэдийн дунд алт олборлох сонирхол түлхүү байна.

Нийт судалгаанд хамрагдсан 500 иргэдээс давхар ажил эрхлэлтийн байдлыг судалж үзэхэд ихэнх хувь нь буюу 78 хувь нь буюу 390 иргэд дан ганц алт олборлох ажил хөдөлмөр эрхэлдэг болох нь харагдаж байсан бол үлдсэн 22 хувь нь буюу 110 хүн мал аж ахуй эрхлэх, гэрээр хүнсний өргөн хэрэглээ, шатах, тослох материал, түлээ нүүрс зарах зэрэг худалдаа наймаа хийх, хоол цай хийж гэр гуанз ажиллуулах, алт худалдаж авах, дулааны улиралд билльярд тоглуулах, хүн ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх, ус зарах зэрэг бизнесийн үйл ажиллагааг алт олборлох үйл ажиллагаатай давхар эрхэлж байна.

²⁰ Уянга сумын 2009 оны статистикийн мэдээ

²¹ Бичил уурхайн компаний ажилчдын төлөөллүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагын дүнгээс

График 12. Хувиараа алт олборлогч иргэдийн давхар ажил эрхлэлтийн байдал



Кейс- 3: Уянга суманд алт олборлохын зэрэгцээ гэр дэлгүүр гуанз ажиллуулж байгаа өрх дээр хийсэн өрхийн амжьжиргааны байдлын шинжилгээ

Манайх ам бүл тавуулаа. 3, 6, 8-р ангийн 3 хүүхдээ аймгийн төвд айлдаа захиад үлдээсэн. Охин маань 2 дүүгээ асарч, гэр орноо харж ханддаг. Нөхөр маань найз нартайгаа хамт нүх ухаж, алт олборлох ажил хийдэг. Харин би өдөрт 20,000-25,000 төгрөгний хоол хийж зардаг, гэр дэлгүүртээ 30,000-35,000 төгрөгний хүнсний болон өргөн хэрэглээний бараа зардаг. Мөн нэмэлт орлого олох зорилгоор алт авдаг 1 цэнгээс 2000-3000 төгрөг унагадаг, 100,000 төгрөгний нэгж зарахад мобикомоос 3000 төгрөгний урамшуулал өгдөг гэх мэтчилэн өдөрт нөхрийн орлогоос гадна би дунджаар 15,00-20,000 төгрөгний ашигтай ажилладаг. Гэхдээ миний орлогод алтны гарц, бусад хүмүүсийн орлого маш их нөлөөлдөг...

38 настай, эмэгтэй, Н

Энэхүү кейсээс харахад энэ гэр бүлийн хувьд үр хүүхдүүдээ аймгийн төв дээр эцэг эхийн хайр халамжаас гадуур орхисон хэдий ч амьжиргаагаа залгуулах орлогын эх үүсвэр хайж ирэн чадлынхаа хирээр хоёр зэрэг ажилласнаар өрхийн сарын орлогоо дунджаар 750,000 төгрөгт хүртэл нэмэгдүүлэн амьдралаа өөд нь татах гэж зүтгэж яваа 115 гаруй өрхүүдийн амьдралын нийтлэг хэв маяг, төрхийг эндээс харж болох юм. Гэхдээ амьдралын ухаан, өрхийн орлого зарлагаа тооцох мэдлэг, дадлага дутмаг, архи тамхины зохисгүй хэрэглээнээс шалтгаанаас амьдрал нь олсоныхоо хэрээр төдийлөн дээшлэхгүй олны ярьж заншснаар “Гэртээ ч харихгүй, гэдсээ ч өлсгөхгүйгээр” энэхүү хүнд хэцүү ажлыг хийсээр байгаа байдал ажиглагдаж байлаа.

5.3. Алт олборлолтын зардал

Бүлгийн ярилцлагад оролцогчдын ярьснаар сард ойролцоогоор 5 хүний бүрэлдэхүүнтэй нэг гал 20 гаруй метр нүхийг 20 хоног ухахдаа ойролцоогоор 450,000-550,000 төгрөгний зардал гаргадаг байна. Энэхүү мэдээллийг гүнзгийрүүлэн судлан ярилцах замаар хамтран тооцоо хийхэд нэг хувиараа алт олборлогч иргэний сард дунджаар 200,000 орчим төгрөг зардал хоол хүнс, тамхи, түлээ мод, багаж хэрэгсэл, алтаа угаалгах зэрэг зүйлд зарцуулж, өдөрт дунджаар 13,500 төгрөгний орлого олдог байна. Эндээс харахад тэд ойролцоогоор 6500-аад төгрөгний цэвэр ашигтай ажилладаг байна.

Харин жилийн дөрвөн улирлаас алт олборлох үйл ажиллагаанд хамгийн их зардал гаргадаг улирал бол өвлийн улирал гэж судалгаанд оролцогчид 100% хариулж байлаа. Энэ нь нэг талаас хүйтрэлтэй холбоотой ахуйн хэрэглээ өсөх, мөн нөгөө талаас алт олборлох үйл ажиллагаанд хэрэглэх хөлдүү газар гэсгээх түлээ нүүрс, паяльник, цахилгаан үүсгэвэр, бензин түлш зэрэг зүйлд мөнгө их зарцуулдаг байна.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн хэрэглэдэг өргөн хэрэглээний хүнсний болон барааны зах зээлийн үнэнд харьцуулсан судалгаа хийхэд Өлтийн уурхайд худалдаалагдаж байгаа бараа бүтээгдэхүүний үнэ нь сум, аймгийн үнээс 70-500 төгрөгөөр илүү үнэтэй байлаа. Ялангуяа ундны цэвэр ус сумын төвийн худгуудад 1литр нь 2 төгрөг байсан бол өлтийн уурхайн ус зардаг жолооч нар 1 литр усыг 10 дахин илүү үнээр буюу 20 төгрөгөөр зарж байлаа.

Өлтийн уурхай дээрх гэр дэлгүүрүүд нь худалдан авагч нартаа зээлээр голдуу бараа бүтээгдэхүүнээ өгдөг ба өөрсдөө ч гэсэн бөөний бараа зардаг явуулын агентаасаа бараагаа зээлээр авч тооцоог 3-7 хоногийн дотор төлдөг байна.

Хүснэгт 22. Гол нэрийн бүтээгдэхүүний үнийн харьцуулалт /аймгийн төв, сумын төв, сайтаар/

№	Өргөн хэрэглээний барааны нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Арвайхээр суман дахь зах зээлийн дундаж үнэ	Уянга суман дахь зах зээлийн дундаж үнэ	Өлтийн уурхай дээрх зах зээлийн дундаж үнэ
1	Алтан тариа /1-р зэрэг/	Кг	1	750	800	900
2	Хэрчсэн гурил	уут нь	1	320	380	500
3	Орос гоймон	Кг	1	1500	1650	1800
4	Алтан тариан гоймон	боодол	1	450	500	800
5	Цагаан будаа	кг	1	1220	1300	1500
6	Өгөөжийн өнгөт мөөхий	Кг	0.9	2050	2200	2200
7	Өгөөжийн еэвэн	Кг	0.9	2100	2200	2300
8	Элсэн чихэр	кг	1	1650	1800	1900

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

9	Доширак	хайрцаг	1	780	850	1000
10	Том аягатай бэлэн хоол	хайрцаг	1	800	950	1100
11	Өглөө сүү	л	1	1600	1650	2000
12	Коко Кола /бидний/	л	1.5	1050	1200	1500
13	Хонины мах	кг	1	2100	1800	2500
14	Ямааны мах	кг	1	1850	1200	1800
15	Боргио пиво /2л/	л	2	3800	4000	4500
16	Харзтай /орон нутгийн архи	л	0.5	3100	3200	3500
17	Ургамлын тос	л	1	2200	2400	3000
18	Вест тамхи	хайрцаг	1	1100	1200	1500
19	Улаан шонхор тамхи	хайрцаг	1	550	650	800
20	Ус	л	25	50	50	500
21	АИ 80 бензин	л	1	1270	1300	1500
22	Дизель	л	1	1400	1430	1800
23	Нүүрс	шуудай	1	3000	4000	5000
24	Мод	шуудай	1	3200	3000	4000
25	Аргал	шуудай	1	1800	1500	2000
26	Бээлий	хос	1	330-1000	350-750	500-1000
27	Толгойн гэрэл	ш	1	1400-2500	1500-2000	2500-3500
28	Лаа	боодол	1	250	280	350
29	“Ок” барааны саван	ш	1	390	450	550

Кейс 4.

Би алт олборлох ажлыг 4 дэхь жилдээ хийж байна. Анх шорооноос олсон мөнгөөрөө зардлаа нөхөөд, ар гэртээ тав, арван цаас илүүчилдэг байлаа. Харин сүүлийн нэг жилд шорооноос олох орлого эрс багасаад зээлээс зээлийн хооронд амьдардаг болоод байна. Ийм байдлаар цааш үргэлжлэх боломж байхгүй болж байна. Энэ хавар Бигэрт нинжа нарт газар тавьж өгсөн ч, өгөөгүй ч амь насаараа дэнчин тавьж очин шорооны ажил хийх болно. 2009 оны намар Говь-Алтайн иргэд, аймаг сумын удирдлагууд гадны “нинжа” нарыг цэрэг цагдаагийн хүчээр хөөж, багаж хэрэгслийг хураан авч, “нинжа” нарыг эр эмгүй зэрлэгээр зодох зэргээр багахан хэмжээний иргэний мөргөлдөөн болсон. Цагдаа нар бидний нэг тус бүр нь 200,000 төгрөгний паажгаруудыг хураан нэг ЗИЛ130, портер машины ачаагаар дүүртэл ачиж авсан. Дараа нь сонсоход хураасан паажгаруудыг орон нутгийн нинжа нартаа нэг бүрийг 30,000 төгрөгөөр зарсан байна билээ. Энэ явдлаас Бигэрээс хөөгдөж зодуулж, багажаа хураалгаж ирсэн “нинжа” нар Говь-Алтай аймгийнханд гомдсон гомдлоо замд дааралдсан Говь-Алтай номертай машинуудын шил, дугуйг нь хагалах, жолооч нарыг нь бүлэглэн зодох, мөн Уянгад ирснийхээ дараа Говь-Алтайгаас ирсэн “нинжа” нарыг зодох, гэр орныг нь шатаах зэргээр хорслоо тайлсан. Энэ зөрчлийн улмаас хотод сурч байсан Говь-Алтай, Өвөрхангай аймгийн оюутнуудын хоорондоо муудалцан зодолдсон шүү дээ. Энэ хавар яадаг ч байсан Бигэр явна, энэнээс ч хэцүү юм болж магадгүй байх даа, төрөөс тодорхой зохицуулалт хийхгүй тэнд иргэний дайнч болж

магадгүй шүү.....

36 настай, эрэгтэй, Г

5.4. Алт борлуулалт ба хуримтлал

Олборлосон алтаа борлуулахтай холбоотой асуудлыг судлахад хувиараа алт олборлогч иргэдийн 96 хувь нь олборлосон алтаа гэр дэлгүүрт, 3 хувь нь явуулын ченжүүдэд, үлдсэн 1 хувь нь сумын дэлгүүрүүдэд борлуулдаг байна. Эндээс харахад гэр дэлгүүрийг “нэг цэгийн үйлчилгээ” гэж нэрлэж болохоор байна. Тэд хувиараа алт олборлогч нарыг өргөн хэрэглээний хүнсний болон барааны бүтээгдэхүүнээр хангах, зээлээр бараа бүтээгдэхүүн олгох, халуун хоол цайгаар үйлчлэх, бензин, дизель зарах, түлээ нүүрс зарах зэрэг бүхий л төрлийн худалдаа үйлчилгээг нэг дор төвлөрүүлэн үйлчилдэг юм байна.

Гэр дэлгүүрүүдэд алтны ченжүүд 1,500,000-2,500,000 төгрөг байршуулан алт сайтан дээрээс худалдаж авахуулдаг байна. Мөн хувиараа алт олборлогч иргэд ч алтаа худалдаад нэг дороос буюу худалдсан газраасаа бараа, бүтээгдэхүүнээ худалдан авдаг учир гэр дэлгүүрийн эзэд ч гэсэн алт худалдан авах бизнес хийх ихээхэн сонирхолтой байдаг байна. Тэд дунджаар нэг цэн алт тутмаас 2,000-3,000 төгрөг унагаадаг байна. Харин худалдаж авсан алтаа цааш нь яаж борлуулдгийг танадалтын аргаар судалсан боловч аймаг, хотын алтны ченжүүд л авдаг гэхээс өөр хариулт өгсөнгүй.

Өөрсдийн олборлосон алтаа цаашид хэрхэн борлуулвал тэдэнд ашигтай, аюулгүй талаар судлахад алтаа зарж байгаа өнөөгийн практикт сэтгэл хангалуун байгаагаа тэд илэрхийлж байлаа.


Судалгаанд оролцогчдоос орлогоосоо мөнгө хадгалах боломжтой эсэх талаар асуухад 16 хувь нь боломжтой, 84 хувь нь боломжгүй гэж хариулсан.

График 13. Алтнаас олсон орлогоосоо хуримтлал үүсгэж чадахгүй байгаагийн шалтгаан



2009 оны байдлаар Монгол шуудан банк иргэд аж ахуйн нэгжүүдэд зээл олгоогүй ба харин ХААН банк нийт 700-800 сая төгрөгийн зээлийг гаргажээ. Сумын банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү 8,4%-10%, хугацаатай хадгаламжийн жилийн хүү 9,6%-19,8% байлаа.

График 14. Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн банкны зээлийн үйлчилгээнд хамрагдсан байдал /2009 онд/



Зээл авсан иргэдийн талаар судлахад 90 гаруй хувь нь Уянга сумын уугуул оршин суугчид байлаа. Бусад хувиараа алт олборлогч иргэдийн хувьд техник төхөөрөмж, мотоцикль болон машин худалдан авах, бизнес эрхлэх, өргөн хэрэглээний цахилгаан болон бусад бүтээгдэхүүн худалдан авах

хэрэгцээ шаардлага их байдаг хэдий ч тухайн орон нутагт албан ёсоор бүртгүүлээгүй, шилжилт хөдөлгөөнөө хийлгээгүй, иргэний бичиг баримтын зөрчилтэй, барьцаа хөрөнгө байхгүй зэрэг шалтгааны улмаас банкнаас зээл нөхцөл, шаардлагыг хангаж чаддагүй юм байна.

Алт олборлож буй иргэдийн хувьд орлого, мөнгөний эргэлт харьцангуй өндөр байдаг боловч олсныхоо хэрээр бодлогогүй зарцуулах, өдөр тутмын болон тамхи, согтууруулах ундааны хэрэглээнд түлхүү үрдэг байдал ажиглагдаж байлаа.

БҮЛЭГ 6

АЛТ ОЛБОРЛОЛТ БУЮУ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



Энэ бүлэгт хувиараа алт олборлогчдын олборлолтын үйл ажиллагааны ерөнхий байдал, ажлын байрны хүчин зүйлс, түүнийг үүсгэж байгаа нөхцөл, ашиглаж байгаа гар багаж, тоног төхөөрөмж, олборлолтын ажилд учирч байгаа бэрхшээл зэргийг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулж боловсруулалт хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд “иргэд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ч эрх ашгаа хамгаалуулах эрхтэй юм.

6.1. Өлтийн хөндий дэхь алт олборлолтын байдал

Өнөөдрийн байдлаар Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлт, Бөөрөлжүүтийн хөндийд байрлаж буй хувиараа алт олборлогч иргэд нь Улаанбаатар хотоос 495-508 км зайд, Арвайхээр сумаас 65-78км зайд, Уянга сумын төвөөс 1 км зайтай газарт хойш буюу зүүн хойш чиглэлтэйгээр уртаашаа 18км, өргөнөөрөө 4км орчим талбайд тархан байрлаж байна.

Хувиараа алт олборлогч иргэдийн байрлаж буй талбайн дийлэнх хэсэг нь буюу 97 орчим хувь нь хуучнаар Эрэл компаний ашиглалтын талбай одоогоор Чех Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай АУМ ХХК-ний ашиглалтын талбай байна.

Өвөрхангай аймгийн Уянга суманд 1993 онд алтны нөөц байгааг тогтоосон бөгөөд үүнээс хойш Эрэл ХХК 1993-2005 онд бие даан нийт 5,2 тонн алт олборлож, угаасан эфел дээр нь ажилладаг иргэд, бичил уурхайн компаниудын тоо жил тутам нэмэгдсээр иржээ. Эрэл компани нь 15 жил ажиллахдаа 5,2 тонн алт олборлохдоо сорчлон ашигласнаас одоог хүртэл уурхайн эфел нь алтны агууламжтай байна.

Эрэл ХХК-ний олборлолтод өртсөн Өлтий амны 251,6 га талбайд 2002 оноос хойш жил бүр 5,000-30,000 гаруй хувиараа алт олборлогч нар, 20-60 гаруй бичил уурхайн компаниуд ажиллаж, алт олборлосоор байна.

Эрэл ХХК нь 20007 оны сүүлээр Уянга суман дахь ашиглалтын тусгай зөвшөөрлөө Монгол Чехийн хамтарсан АУМ ХХК-д шилжүүлжээ. Эрэл ХХК-ний лицензийг шилжүүлэн авсан АУМ ХХК нь 2008 оноос ашиглалтын 251,6 га талбайдаа 60 гаруй бичил уурхайн компаниудтай эфел ашиглах гэрээ байгуулан ажиллуулж байна.

Өлтөд хувиараа алт олборлогч иргэдийн тоо алтны гарц их байх үедээ 30 гаруй мянгад хүрч байсан түүхтэй ч өнөөдрийн байдлаар 3500 гаруй хүмүүс алт олборлож байлаа. Эдгээр иргэдийг зохион байгуулалтад оруулах, үйл ажиллагааг нь зохицуулах, бүртгэлжүүлэх оролдлогыг сум, аймгийн засаг захиргаанаас лиценз эзэмшигч том компаниудтай хамтран удаа дараа хийж байсан ч тодорхой үр дүнд хүрч чадалгүй байсаар өдийг хүрсэн байна.

Судалгаанд хамрагдсан 500 хувиараа алт олборлогч иргэдийн 18% нь Уянга сумын бүртгэлтэй уугуул оршин суугчид, үлдсэн 82% нь тухайн орон нутагт бүртгэлгүй, алт олборлохоор ирсэн хүмүүс байлаа. Энэ суманд байгаа хувиараа алт олборлогч иргэдийн дийлэнх хэсэг нь Булган, Архангай, Дундговь, Банхонгор, сэлэнгэ, Төв зэрэг 19 аймгаас ирсэн хүмүүс байсан бөгөөд Баян-Өлгий, Ховд, Дорнод гэсэн аймгуудаас ирсэн хүмүүс судалгаанд хамрагдаагүй байлаа.

Энд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор доорхи байдлаар ангилж тодорхойллоо. Үүнд: Уул уурхайн компаниудыг *том болон бичил уурхайн компани*, харин хувиараа алт олборлож байгаа иргэдийг *суурин болон явуулын* гэж тус тус ангиллаа.

5. *Суурин алт олборлогч иргэд* – жилийн 4 улирлын турш байнга ажилладаг, үндсэн ажил эрхлэлт нь хувиараа алт олборлолт болсон бүлэг хүмүүс
6. *Явуулын алт олборлогч иргэд* – амьдралынхаа хэрэгцээ шаардлагын улмаас цөөхөн хоногоор ирж алт олборлоод буцдаг бүлэг хүмүүс
7. *Уул уурхайн том компани* - хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензтэй, ус, нөөц, газрын төлбөрөө зохих журмын төлж, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг том компаниуд
8. *Бичил уул уурхайн компани* - Санхүүгийн чадавхитай хувиараа алт олборлогч иргэд, хувиараа компани байгуулан Өлтийн хөндийн ашиглалтын лиценз эзэмшигч том уул уурхайн компанитай гэрээ байгуулан уурхайн эфел дээр алт олборлох үйл ажиллагаа явуулдаг байна. Орон нутгийн иргэдийн тодорхойлохдоо бичил уурхайн клмпаниудыг “техниктэй нинжа” нар хэмээн ёжлон нэрлэдэг байна. Эдгээр бичил уурхайн компаниуд нь техникийн бааз сайтай, баяжуулах төхөөрөмж, эксковатор, бульдозар, самосвал, цахилгаан үүсгэвэр, усны насос, ачааны машин зэрэг тоног төхөөмжийг ашиглан алт олборлолтын үйл ажиллагааг 5 сараас 11 сарын хооронд хийдэг байна. Энд ажиллаж байгаа ажилчдын дундаж цалин 200,000-350,000 төгрөг байдаг ба хүнд машин механзм дээр ажилладаг ажилчдын хувьд 350,000 гаруй төгрөгний цалин, харин туслах ажилчид нь 200,000 гаруй төгрөгний цалин авдаг байна.

6.2. ХАМО иргэдийн алт олборлох үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 32% нь хувиараа алт олборлох ажлыг 4-7 жилийн хугацаанд эрхэлж байгаа бөгөөд тэдний энэ ажлыг эрхэлсэн дундаж хугацаа нь 6,3 жил байна.

Хүснэгт 23. Хувиараа ашигт малтмал эрхэлж буй хугацаа

Сонгосон үзүүлэлтүүд	Өлтийн орд
Хувиараа ашигт малтмал эрхэлж буй хугацаа	5%
1 жил хүртэл	28%
1-3 жил	32%
4-7 жил	21%
8-11 жил	9%
12-15 жил	5%
15-18 жил	0
19 дээш	
Нийт	100%
Хувиараа ашигт малтмал олборлож байгаа дундаж хугацаа	6,3 жил

Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, бага насны хүүхэдтэй эхчүүдийн хувьд удаан цагаар алт олборлон ажлыг хийж чаддаггүй байна.

Судалгаанд оролцогчдийн 85 гаруй хувь нь алт олборлох ажлыг цаашид орхих бодолгүй байгаагаа ярьж байсан ба энэ нь аймаг сумын хэмжээнд ажлын байр шинээр бий болохгүй байгаа, нийгэм эдийн засгийн байдалд дорвитой өөрчлөлт орохгүй байгаатай холбоотой байж болох юм.

Геологи уул уурхайн чиглэлээр хийгдсэн мэдээ судалгааны материалуудтай танилцаж байх явцад болон холбогдох мэргэжлийн хүмүүстэй уулзаж ярилцаж байхад том уул уурхайн компаниудын бүрэн олборлолт хийж чадаагүй алтны агууламжтай хаягдал, том компаниудын хувьд эдийн засгийн үр өгөөжгүй нөөцүүд манай орны хувьд их байдаг тул хувиараа алт олборлох бизнес ойрын 20 жилд зогсохгүй гэсэн таамаглалууд нэлээд гарч байлаа.

Өлтийн уулын амуудад иргэд алт олборлоод 20 гаруй жил болсон тул гадаргын алтны нөөц дуусч, өнөөдөр алт олборлогч иргэд 20-иос дээш гүнд алт олборлох үйл ажиллагаа явуулж байна. Хэдийчинээ гүнд үйл ажиллагаа явуулах тусам агааргүйтэх, угаартах, гүнзгий нүхэнд хүн, мал унаж бэртэх, амь насаа алдах зэрэг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой хүндрэлүүд гарах эрсдэл өндөр байна.

6.3. Хувиараа алт олборлох үйл ажиллагааны эрх зүйн нөхцөл, байдал

Одоогийн байдлаар Өлтийн хөндийд Зүүн, Баруун модот мухар, Зүүн Бүргэдэй, Хүрэн хошуу, Нарантуул, Бор хошуу, Улаан хадны энгэр буюу Хар

хадны эрэг, Өндөр толгой болон Хүүшийн ам гэсэн газруудад нийт 3,500 гаруй хүмүүс ажиллаж байна.

Эдгээр хүмүүсийн төлөөллүүдтэй уулзаж ярилцаж байхад тэд алт олборлох газрын асуудлыг нэлээд хөндөж байлаа. Уянга суман дахь алт олборлогч иргэдийн 91 хувь нь Монгол Улсын Засгийн Газрын 72-р тогтоол, хувиараа алт олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаар ямар мэдлэг, мэдээлэлгүй, харин үлдсэн 9% нь энэхүү түр журмын талаар харилцан адилгүй түвшний мэдлэг, мэдээлэлтэй байлаа. Энэхүү түр журам нь тэдэнд алт олборлох газрын зөвшөөрлийн талаар тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэж чадахуйц эрх зүйн зохицуулалт мөн үү гэдэг талаар тодруулахад тэд энэхүү түр журам нь тэдний үйл ажиллагааг зохицуулж чадахуйц, амьдралд нийцсэн журам биш хэмээн дүгнэж байлаа.

Яагаад ингэж дүгнэж байгаа талаар тодруулан асуухад АУМ ХХК нь өөрийн лицензтэй талбайд алт олборлох үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг бичил компаниудад гэрээлэн өгдөг болохоос биш “нинжа” нарт албан ёсоор ашиглуулах сонирхолгүй байдаг талаар ярьж байлаа. Мөн орон нутгийн засаг захиргааны зүгээс хувиараа алт олборлолтыг албан бус үйл ажиллагаа хэмээн үздэг бөгөөд энэ төрлийн үйл ажиллагааг таслан зогсоох хатуу байр суурийг баримталдаг учир тэдэнтэй ойлголцон зөвшилцөх боломжгүй. Нөгөө талдаа эдгээр иргэд өөрсдөө бичиг баримт, хаягийн зөрчлийн улмаас шилжилт хөдөлгөөнөө хуулийн дагуу хийлгэдэггүй учир энэ төрлийн зохицуулалтанд орох боломжгүй талаараа хуваалцаж байсан.

АУМ ХХК –ний ашиглалтын талбайд эфел ашиглах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа 60 гаруй бичил уурхайн компаниудаас зөвхөн 19 нь орон нутгийн татварын албанд бүртгэлтэй ажиллаж байгаа ба бусад нь гэсэн хуулиас гадуур ажиллаж байгаа юм байна.

Энэхүү үйл ажиллагааг цаашид хэрхэн зохицуулах бодлого чиглэлтэй байгаа талаар орон нутгийн удирдлага, иргэд, иргэний хөдөлгөөний төлөөлөлүүдтэй уулзаж ярилцахад 2009 оны УИХ-ын хаврын ээлжит чуулганаар батлагдсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг мөрдлөг болгон ажиллана. Энэ ажлын хүрээнд гол мөрний эх, усны сан болон ойн сангийн хилийн заагийг бодитой, гол мөрөн бүрэн хамгаалагдахуйц байдлаар тогтоох бэлтгэл ажлуудад анхааран ажиллаж байгаа ба Өлт, Бөөрөлжүүтийн хөндий ч гэсэн усны урсац бүрэлдэх эх гэсэн ангилалд багтаж байгааг онцлон тэмдэглэж байлаа.

Албан бус алт олборлолттой холбогдон архидан согтуурах, зодолдох, танхайрах, дээрэмдэх зэрэг нийгмийн гаж үзэгдэл гарсаар байгаа төдийгүй хувиараа алт олборлогчдын дийлэнх нь нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй бйана. Өөр нэг анхаарал татаж байгаа асуудал бол хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж байгаа явдал юм. Цаашилбал, албан бус хувиараа алт олборлолтоос болж албан ёсны бүртгэлтэй алтны компаниуд, бичил уурхайн компаниуд, орон нутгийн малчид, эдгээр компаний газар дээр зөвшөөрөлгүй ажиллаж байгаа хувиараа алт олборлогчдын хооронд зөрчилдөөн үүсч байна.

6.4. Хувиараа алт олборлогч нарын ажлын ачаалал, амралт, чөлөөт цаг

Судалгаанд оролцсон иргэдийн 90 гаруй хувь нь алт олборлох үйл ажиллагааг байнга хийдэг гэж хариулсан бол үлдсэн 10 хувь нь мөнгө хэрэг болсон үедээ олборлолт хийдэг гэсэн байна. Алт олборлох үйл ажиллагааг хоногт хэдэн цаг хийдэг талаар тодруулахад хувиараа алт олборлогч нар доорх мэдээллийг өгч байлаа.

Хүснэгт 24. ХАМО иргэдийн ажлын цаг

Сонгогдсон үзүүлэлтүүд	Хүйс		Дундаж
	Эрэгтэй	Эмэгтэй	
Хоногт ажилладаг цаг			
1-8 цаг	5%	65%	35%
9-14 цаг	82%	35%	58,5%
15 ба түүнээс дээш °	12%	2%	7%

Алт олборлох ажлынхаа хэдий хугацааг газар дор ажиллаж өнгөөрдөг талаар судлахад тэдний асуулгад оролцогч иргэд “Бидний хайж байгаа зүйлс газар доор л байдаг учир ажиллаж байх хугацааныхаа 90%-ийг газар доор өнгөрөөдөг. Зөвхөн амрах, хоол унд идэх үедээ л газар дээх гарч ирдэг” гэж байлаа.

Кейс

Би урьд нь төрийн байгууллагад ажилладаг байсан. Тэр үед хагас бүтэн сайны амралт, баярын амралт, жилийн амралт авах зэргээр ажил амралтаа зохицуулдаг байсан. Харин шорооны ажил хийдэг болсноос хойш миний амьдралд амралтын өдөр, чөлөөт цаг гэдэг ойлголт байхгүй болсон. Алт олохын төлөө өдөр шөнөгүй л ажилладаг.

42 настай, эрэгтэй, М


Хавар цас хайлах, шар усны үер буух, бороо орох үед нүхнүүд усаар дүүрч, зарим тохиолдолд бэлхүүсээр татсан их устай болдог учир ажиллах хамгийн хэцүү нөхцөл байдаг гэж судалгаанд оролцогч нар ярьж байлаа.

6.5. Алт олборлогчдын хөдөлмөрийн байрны нөхцөл байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэд өөрсдийгөө маш хүнд хэцүү, ажлын байрны тав тух, аюулгүй байдлын наад захын хэрэгцээ шаардлагад нийцээгүй хамгийн их эрсдэл дагуулсан нөхцөл байдалд ажилладаг гэдгээ мэддэг ч үүнээс өөр сонголт, орлого олох боломж бололцоо байхгүй учраас энэхүү ажлыг хийсээр байгаагаа ярьж байлаа.

[°] Зөвхөн алтны агуулга сайтай газар олсон тохиолдолд нүхээ манаж хоног, яаралтай алттай шороогоо гаргаж авах тохиолдолд бараг өдөр шөнөгүй, амралтгүй ажилладаг гэж ярьж байлаа.

График 15. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг, туршлага олж авсан байдал



Алт олборлогчдын дунд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаарх мэргэжлийн мэдлэг мэдээлэл маш их хэрэгтэй байдаг юм байна.

Алт олборлож байгаа бараг бүх иргэд ажлын хувцас хэрэглэдэг гэж хариулж байсан хэдий ч энэ нь уул уурхайн ажилд зориулагдсан тусгай хувцас хэрэглэл биш харин өдөр тутам хэрэглэдэг хувцсаа хэлж байлаа. Нийтийг хамгаалах ямар ч хэрэгсэл байхгүй харин хувийн хамгаалах хэрэгслийн хувьд хэрэглэхээс аргагүйд хүрдэг усны гутал, резинэн бээлий, амны хаалт, ажлын бээлий зэргийг хэрэглэж байна. Эдгээрээс гадна газар доор ажиллахад хамгийн тохиромжтой ажлын хувцас нь малгайтай цамц гэж судалгаанд оролцогч нар ярьж байлаа. Учир нь энэ нь газрын гүнд ажиллахад дээрээс шороо унах, хорхой шавьж хүзүү хоолойгоор орохгүй, салхи шорооноос хамгаалах зэрэг давуу талуудтайг дурьдаж байлаа.

Шороон орд дээр ажиллаж байгаа хувиараа алт олборлогч нарын хувьд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ямар хувцас, хэрэгсэл нэн тэргүүнд хэрэгцээтэй байдаг, мөн өөрсдийн аюулгүй байдлаа хамгаалахын тулд ямар хувцас хэрэгслийг тогтмол хэрэглэдэг шалтгааныг нь тодруулан асуухад нэгж оролцогч нэгээс дээш сонголтоор хариулж давхардсан байдлаар дараах хариултуудыг өгсөн.

Хүснэгт 25. Хувиараа алт олборлогчдын хэрэглэдэг ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл

Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл	Хувь
----------------------------------	------

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

1	Ажлын өмд, цамц	100%
2	Зузаан өмд цамц	100%
3	Каска	0
4	Дулаан малгай	100%
5	Ажлын гутал	100%
6	Эсгий гутал	0
7	Усны гутал ²²	45%
8	Резинэн бот, шаахай	-
9	Ажлын даавуун бээлий	100%
10	Дулаан бээлийн	100%
11	Резинэн бээлий	82%
12	Нүд хамгаалах шил	0
13	Чихний бөглөө, чихэвч	0
14	Амны хаалт, маска	42%
15	Тоосноос хамгаалах хушуувч	0
15	Татлага олс	92%
Оролцсон хүмүүс		500 хүн

Дандаа тоос шороотой нөхцөлд ажилладаг учир тэдний хувьд хамгийн хэрэгцээтэй зүйл нь маск байдаг хэдий ч агааргүй, битүү орчинд ажилладаг болохоор тэр болгон шаардлагад нийцсэн маскыг байнга, цэвэр хэрэглэх, худалдан авах боломжгүй байдаг учраас өдөр болгон хэрэглээд байж чаддаггүй гэж хариулж байсан. Хамгаалах нүдний шил, усны гутал, бэхлэгч, ажлын гутал, каск зэрэг хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, хувцас хэрэглэх тал дээр тодорхой ойлголт, мэдээлэлгүй байлаа.

Харин толгойн гэрэл, бэхэлгээний олс зэрэг багаж нь тэдний үйл ажиллагаанд зайлшгүй чухал шаардлагатай байдаг учир байнга хэрэглэдэг ба гэр дэлгүүрүүдэд ч гэсэн эдгээр зүйлсийг байнга худалдаалдаг байна. Харин багаж хэрэгслийн хувьд тэд ярихдаа аль болох хүмүүсийн гар ажиллагаа, хөдөлмөрийг хөнгөвчилсөн багаж, тоног төхөөрөмж хэрэглэхийг

²² Усны гутал ер нь байдаг

хүсдэг ч санхүү мөнгөний боломжгүйгээс шалтгаалан авч хэрэглэж чаддаггүй. Шороон ордод ажиллахад хамгийн хэрэгцээтэй тоног төхөөрөмж бол компрессор буюу цохилтот өрөм, шат, сков, леботик, паажуур зэрэг багажууд тэдний ажлыг нэлээд хөнгөвчилдөг. Эдгээр багажуудыг худалдан авч чадахгүй тохиолдолд тэд бусдаас түрээслэн авч түр хэрэглэдэг байна.

Ердийн гар багажуудыг тэд байнга хэрэглэдэг бөгөөд өөрсдөө худалдан авч хэрэглэх боломжтой ба эвдэрсэн тохиолдолд гагнах, хадах зэргээр засдаг.


Судалгаанаас үзэхэд шороон ордоос алт олборлож байгаа хүмүүс нүх ухах, нүхнээс шороо гаргах, хайраглах, үүрч зөөх, машинд ачиж буулгах, баяжуулах зэрэг ажлуудыг хийдэг байна. Тээврийн ажлыг хувийн портер маркийн машинтай хүмүүс нэг ачаа шороог 10,000 төгрөгний тээвэрлэлтийн хөлстэйгээр гүйцэтгэдэг байна.

Хүснэгт 26. Ажлын байрны хортой хүчин зүйлийн түвшин

	Хортой хүчин зүйлс	Хүний тоо	Их (муу)		Дунд зэрэг		Бага (сайн)	
			тоо	%	Тоо	%	тоо	%
1	Тоос	500	500	100%	-	-	-	-
2	Шуугиан	500	60	12%	241	48,2%	199	39,8%
3	Доргио	500	40	8%	168	33,5%	207	41,5%
4	Агаарын хүрэлцээ муу	500	265	53%	151	30,3%	84	16,7%
5	Хортой хий, бодис	500	42	8,3%	142	28,5%	316	63,2%
6	Гэрлийн хүрэлцээ	500	428	85,6%	49	9,8%	23	4,6%
7	Биеийн хүчний ачаалал	500	448	89,7	52	10,3	-	-
8	Сэтгэл санааны дарамт	500	438	87,5%	62	12,5%	-	-
9	Согтууруулах ундаа хэрэглэх	500	261	52,3%	152	30,4%	87	17,3%
10	Ажлын цагийн үргэлжлэл	500	427	85,3%	74	14,7	-	-

Тоосжилт, агааргүйдэлт, гэрэлгүй харанхуй байдал, сэтгэл санааны дарамт, согтууруулах ундааны хэрэглээ, биеийн хүчний ачаалал, ажлын цагийн үргэлжлэл ажлын хортой хүчин зүйлсийн нөлөөллийн түвшин тэдний дунд өндөр байлаа.

График 16. ХАМО нарын алт олборлоход хэрэглэдэг багаж хэрэгсэл



Хүснэгт 27. ХАМО нарын алт олборлоход хэрэглэдэг багаж хэрэгсэл

	Ажлын багаж	Хувь
1	Хүрз	100
2	Жоотуу	100
3	Лоом	100
4	Сков	100
5	Леботик	38,3
6	Шат	-
7	гэрэл	100
8	Алх /лантуу	91,8
9	Хуурай угаагч	36,8
10	Агаар хэмжигч	0

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

11	Олс	100
12	Шуудай	100
13	Шигшүүр	100
14	Шлюз	22,5
15	Усан буу	17,9
16	Сэнс	29,8
17	Компрессор	7,9
18	Хувин/ түмпэн	100
19	Бусад	5,9

Шороон ордны хувьд биеийн хүчний хөдөлмөр ихээр шаарддаг бөгөөд гар багаж ихээр хэрэглэгддэг онцлогууд анзаарагдаж байлаа.

2008 онд Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар, Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан шалгалтаар Өлт, Бөөрөлжүүтийн хөндийн олборлолтын долоон газраас хөрс, усны дээж авч шинжилгээнд явуулсан ба шинжилгээгээр цианит натри, мөнгөн ус хэрэглээгүй гэсэн хариу иржээ.

Хүснэгт 28. Алт олборлолтыг сурсан байдал

Ажил үүрэг		Хувь
1	Уул уурхайн дээд боловсролтой	-
2	Уул уурхайн тусгай дунд боловсролтой	-
3	Уул уурхайн тусгай мэргэжилтэй	2,7%
4	Мэргэжилгүй	97,3%
5	Үүнээс 1.Туршлагатай хүмүүсийг дагалдаж сурсан	70,3%
	2. Курс дамжаанд сурсан	-
	3. Өмнө нь алт олборлох үйлдвэрт ажиллаж байхдаа сурсан	12,6%,
	4. Бусдыг хараад сурсан	17,1%

БҮЛЭГ 7

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ



Хүн ямар ч үед эрүүл мэндийнхээ төлөө санаа тавих эрүүл мэндээ хамгаалуулах эмнэлгийн тусламж авах эрхтэй. Энэ тухай Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг хуулиар тогтооно” гэж баталгаажуулсны дагуу уг харилцааг эрүүл мэндийн тухай, иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, эмийн тухай, ариуйн цэврийн тухай зэрэг болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Иргэд эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд холбогдох хууль журамд заагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдана.

7.1. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж

Уянга сумын эмнэлэг 1937 онд байгуулагдсан, 1964 онд тус эмнэлэг нь их эмчийн салбартай болон өргөжсөн. Сумын их эмчийн салбар нь сумын төвөөс 60 км зайд оршдог Жаргалант багт оршдог. 2003 оны 1-р сард сумын төвийн эмнэлэг нь хуучин сумын сургууль байсан байрнаасаа нүүн шинэ эмнэлгийн байрандаа үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. 2007 онд Дэлхийн Зөн ОУБ-ийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн өргөтлийг барьж ашиглалтанд оруулсан. Нийт 49 ажилтантай үүнд их эмч 7, сувилагч 9, эх баригч 2, бага эмч 1, багийн бага эмч 4, бусад үйлчилгээний ажилтан 26 байдаг. Тус эмнэлэг нь сумын хүн амаас гадна Өлтийн алтны уурхайд албан бусаар хувиараа алт олборлогч 5,000-15,000 орчим хүн ам, Өлтийн алтны уурхайн компаниудын 200-300 орчим ажилчид нийт 15,000-25,000 хүнд эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үзүүлдэг. Эмнэлэг нь дотор, мэс засал, хүүхэд, төрөх, амбулатори зэрэг хэсгээс бүрддэг. Сумын эмнэлгийн жилийн нийт төсөв 255 сая төгрөг ба 100% улсын төсвөөс санхүүждэг. Сумын эмнэлгийг төсөвт орны тоо 35, түргэн тусламжийн 3 автомашинтай, эмнэлэг тоног төхөөрөмжийн хувьд доорхи тоног төхөөрөмжүүдтэй.

Хүснэгт 29. Тоног төхөөрөмжийн нэрс

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Тоо
1	ЭХО хэт авиа	1
2	Хиймэл амьсгалын аппарат	2
3	Электрокардиография	1
4	Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч аппарат	2
5	Инкубаторын аппарат	2
6	Бусад	4

2009 онд сумын төвийн эмнэлэг төвийн доторх 624 дуудлага, алсын 786 дуудлага хүлээн авч эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Дуудлагын төрлөөр авч үзвэл осол гэмтлийн 133, төрөлтийн 120, бусад 1157 дуудлага байжээ. Амбулаторийн нийт үзлэгийг төрлөөр нь доорхи хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 30. Амбулаторийн нийт үзлэг төрлөөр

Амбулаторийн нийт үзлэг төрлөөр	Нийт үйлчлүүлэгчийн тоо
Урьдчилан сэргийлэх үзлэг	5347
Гэрийн идэвхтэй үзлэг	786
Диспансерийн хяналтын үзлэг	1066
Өвчний учир	4496
Гэрийн дуудлагын үзлэг	397
Нийт дүн	12092 (давхардсан тоогоор)

Эмзэг бүлгийн хүн амыг амбулаторийн үзлэгт хамрагдсан байдлыг авч үзвэл урьдчилан сэргийлэх үзлэг 496, гэрийн идэвхтэй үзлэг 273 , өвчний учир 231 хүн байв.

7.2. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал.

Хувиараа алт олборлож байгаа иргэдийн хувьд усан дотор зогсох, газар доор агааргүй, хүйтэн, харанхуй орчинд биеийн хүчний ажил хийснээс зүрх судас, амьсгалын тогтолцоо, бөөр, нуруу, шээсний замын өвчин зэрэг эмгэгээр өвдөх цаашилбал хөдөлмөрийн чадваргүй болох тохиолдлууд багагүй тохиолддог байна. Хувиараа алт олборлогч иргэдийн дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, зовиуруудын байдлыг дараах бүдүүвчээр харууллаа.

График 17. Хувиараа алт олборлогч иргэдийн дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, зовиур



Хувиараа алт олборлогч иргэдийн дунд хамгийн ихээр тохиолдсон өвчлөл, зовиур нь бөөр өвдөх, шээс ойр ойрхон хүрэх, ууц нуруугаар өвдөх зовиурууд байлаа. Хүйтэн, нойтон, чийгтэй орчинд байнга хүнд хүчир ажил эрхэлж, хүнд юм өргөж зөөх, удаан хугацаагаар зогсох зэргийн улмаас хувиараа алт олборлогч иргэд нь энэ төрлийн өвчлөлд өртөмхий байдаг гэж мэргэжлийн хүмүүс ярьж байлаа. Энэ төрлийн өвчлөл нь 35-аас дээш насны эмэгтэйчүүд, 45-аас дээш насны эрэгтэйчүүдийн дунд нийтлэг тохиолдож байгаа нь мэдээлэлд шинжилгээ хийх явцад харагдаж байлаа.

Харин хувиараа алт олборлогч иргэдийн дунд мөн түгээмэл тохиолддог өвчлөл, зовиурын тоонд цээжээр хатгуулах, ханиалгах, амьсгал давчдах, хоолой өвдөх зэрэг өвчнүүд ордог байна. Сумын эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдээлснээр хувиараа алт олборлогч иргэдийн дунд сүрьеэ өвчин болон амьсгалын тогтолцооны бусад өвчлөл нэлээд гардаг. 2009 оны хувьд сүрьеэгийн тохиолдол 6, вируст гепатитийн 10 тохиолдол бүртгэгджээ. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд ордоггүй, цаг алдалгүй эмнэлгийн үйлчилгээ аваагүйгээс өвчин хүндэрч архагших, тэр байтугай амь насаа алдах явдлууд гардаг байна. Эмнэлгийн дүн бүртгэлээс гаргасан мэдээнд 2009 оны хувьд нэг сүрьеэ өвчин туссан хувиараа алт олборлогч иргэн амь насаа алдсан тохиолдол бүртгэгджээ.

2009 оны байдлаар Уянга суманд бэлгийн замын өвчнөөр нийт 169 хүн өвчилснөөс 80 хүн заг хүйтэн, 10 хүн тэмбүү, 76 хүн трихомоназ, 3 мөөгөнцрөөр өвдөж, эмчлүүлсэн тохиолдлууд бүртгэгдсэн. Эдгээр тохиолдлуудын 60% нь 20-35 насны эмэгтэйчүүдийн жирэмсний үеийн эмчийн хяналтын үед оношлогдож, эмчлэгдсэн байна. Эндээс харахад хувиараа алт олборлогч иргэд нь сайн дураараа бэлгийн замын өвчлөлийн оношлогоо, шинжилгээнд хамрагддаггүй л болохоос биш бэлгийн замын халдварт өвчний тархалт их байх магадлал өндөр байгааг харуулж байна.

7.3. Хувиараа алт олборлогч иргэдийн осол гэмтэлд өртөж буй байдал


Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн дунд давхардсан тоогоор 63,3% нь гэмтэж байсан, 22% осолд орж байсан, 32% нь гэмтэж байгаагүй гэж хариулжээ.

Хүснэгт 31. Хувиараа алт олборлогч нарын дунд нийтлэг тохиолддог гэмтлийн төрлүүд

Гэмтлийн төрлүүд	Тохиолдол хувиар
1 Нүх нурж дарагдсан	17,3%
2 Малталтын дээвэр нурсан	5,2%
3 Нүхэнд унасан	58%
4 Өндрөөс унасан	37,9%
5 Түлэгдсэн	16%
6 Ажлын байран дээрээ бусдад зодуулсан	7,5%
7 Хүйтэнд хөлдөх	22,7
8 Согтуурсны улмаас гэмтэх	42,7
9 Угаартсан	12,1%
10 Бусад	7,1%

Сумын эмнэлгийн сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухай дүн бүртгэлийн мэдээнээс харахад бэртэл, гэмтэл, хордлогын тохиолдол 2007 онд 97, 2008 онд 123, 2009 онд 257 тохиолдлыг бүртгэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэсэн байна. Эндээс 2009 оны хувьд гэмтэл, бэртлийн тохиолдол нь 2007 оныхоос 1,3 дахин, 2008 оныхоос 2 дахин тус тус өссөн байна. Эндээс харахад жил ирэх тутам алтны нөөц багасаж, хувиараа алт олборлогч нар илүү гүнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны наад захын шаардлагыг хангалгүй ажиллаж байгаагаас осол гэмтэлд өртөх нь ихсэж байна.

График 18. Бэртэл хордлого



Гурван жилийн өмнө манай компани “нинжа” нарын ажиллаж байсан газар алт олборлох зөвшөөрөл аван үйл ажиллагаа эхлэн хөрс хуулалт хийж байх явцад хүний цогцос гарч ирж байсан. Холбогдох байгууллагууд нь шалгаад алт олох гэж яваад шороонд дарагдаж нас барсан хүн болохыг олж тогтоож байсан. Эндээс харахад “нинжа” нарын дунд осол гэмтэл маш их гардаг, энэ бүх тохиолдлуудад тэд эмнэлэг, цагдаагийн байгууллагуудад мэдэгдээд байдаггүй, нас барсан хүмүүсээ авч чадахыг нь чадаад, чадахгүйг нь тэр чигт үлдээдэг байж магадгүй гэж би боддог.

Э, бичил уурхайн компаний ажилтан

7.4. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал

Өлтийн хөндийд алт олборлогч иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хэрхэн хамрагдаж буйг судлахад тэдний 62% нь өвчин хүндрээгүй тохиолдолд эмнэлгийн байгууллагад хандалгүй найз нөхөд, танилуудынхаа зөвлөсний дагуу гэрээр эмчилгээ хийдэг гэж хариулж байлаа.

Ажиглалтын явцад уурхай дээр жижиглэн худалдаа, наймаа хийж буй гэр дэлгүүрүүдийн 52 орчим хувь нь өргөн хэрэглээний эм, эмийн зүйл зарж байлаа.

Хамгийн их эрэлт хэрэгцээтэй эм, эмийн зүйлийн талаар худалдагч нараас асуухад анальгин, цитрамон, парацетамол, ампициллин (уухаар, тариагаар), пенциллин тариагаар, амоксициллин болон бусад төрлийн антибиотекууд, фталазол, шархны лент, боолтын материал зэрэг эм, эмийн зүйлсийг нэрлэж байлаа. Харин судалгаанд оролцсон эм зарж байгаа бүх хүмүүс эм зүйн анхан шатны боловсролгүй байснаас гадна, хэзээ ч эмийн жороор үйлчилж байгаагүй гэж байлаа.

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн 92 хувь буюу 460 нь эрүүл мэндийн даатгалгүй, харин 8 хувь буюу 40 нь эрүүл мэндийн даатгалтай гэж хариулсан байлаа.

График 19. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн тусламж авахад тохиолддог бэрхшээлүүд



Эдгээр иргэдээс яагаад эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байгаа талаар тодруулахад албан ёсоор шилжилт хөдөлгөөнөө хийлгээгүй, хаягийн бүртгэлгүй, иргэний бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, иргэний үнэмлэхний сунгалт хийгдээгүй зэргийн улмаас эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байна гэж 90 гаруй хувь нь хариулж байсан бөгөөд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, даатгалын төрөл, даатгалд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл суртчилгааны ажил байдаггүй учраас даатгалд хамрагдаагүй гэж давхардсан тоогоор 70 гаруй хувь нь хариулж байлаа.

Хувиараа алт олборлогч иргэдийн оршин суугаа хаяггүй, тодорхой бус байршдаг учраас тэднийг олж туслалцаа үзүүлэхэд хүндрэлтэй байдаг талаар эмч нар ярьж байлаа.

Өнөөдөр хувиараа алт олборлогч иргэдийн хувьд эрүүл мэндийн даатгалд хамрагдахаасаа илүү зөвхөн найдвартай орон байр, хоол хүнс гэсэн хэрэгцээнд гол анхаардлаа хандуулдаг ба амь нас, эрүүл мэндээ төдийлөн анхаардаггүй байна.

БҮЛЭГ 8

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



8.1. Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа

Хувиараа алт олборлогч иргэдийн тогтвортой амьжиргааг бий болгох нэг үндсэн чухал асуудал нь хамтын нэгдсэн зохион байгуулалтад орж, байгалийн нөөцийн хамтын, тогтвортой менежментийг эрхлэх асуудал юм. Байгалийн нөөц, алтны гарц сайн байвал тэр хэмжээгээрээ алтны гарц сайн байна. Иймээс хувиараа алт олборлогч иргэдийн хамтын зохион байгуулалтанд оролцох чадавхийг хөгжүүлэх, тэдний байгалийн нөөцийг зөв зохистой, тогтвортой ашиглах чадварыг дээшлүүлэх гол хүчин зүйл нь тэдний хүч хөдөлмөрийг зөв хорших, хамтын ажиллагааг хэрхэн сайжруулахаас шууд шалтгаална.

Өлтийн хөндийд алт олборлож буй иргэдээс ямар зохион байгуулалттайгаар хэрхэн хөдөлмөрөө хоршин ажиллаж байгаа талаар тодруулахад нийт оролцогчид маань найз нөхөд, хамаатан садан, нутгийнхантайгаа хамтран “нэг гал” болон ажилладаг гэж хариулж байлаа. Тэдний ажиллаж амьдарч, хөдөлмөрөө хоршиж буй хэв маягийг судалж үзэхэд тэд нэг гал буюу бригадаараа нийлэн нэг гэрт амьдарч, нэг тогооноос хооллож, хамтдаа нүх ухах, алтаа угаах зэрэг ажлыг хоорондоо тохиролцон хуваарилах зарчмаар ажиллаж, олсон орлогоо буюу “ёндoo”-гоо тэнцүү хуваах, хийсэн ажил, оруулсан хөрөнгө хүчнийхээ хэмжээгээр тохиролцон хуваан авдаг байна.

Хувиараа алт олборлогч иргэдийг ямар төрлийн харилцаа холбоо бүхий хүмүүстэй илүү нэгдэж нэг гал болон ажиллаж, амьдарч байгаа талаар судлахад нийт судалгаанд оролцогчдын 78% найз нөхөдтэй, 58% гэр бүлийн гишүүд, хамаатнуудтайгаа, 42% нутгийнхантайгаа гэж хариулсан байлаа.


Хүснэгт 32. Галын гишүүд

Галын гишүүд	Хувь
Гэр бүл, хамаатнуудтайгаа хамтран	78
Нутгийнхантайгаа хамтран	58
Найз нөхөдтэйгээ хамтран	42
Бүртгэгдээгүй нөхөрлөл маягаар	0
Хоршоо маягаар	0
Бусад	3

Эндээс харахад ойролцоо насны найз нөхдийн харилцаа бүхий хүмүүс хоорондоо нэгдэн нэг гал болон ажиллах хандлага их байгаа нь тодорхой байгаа бөгөөд уурхай дээр хийсэн ажиглалтын явцад ч энэ байдал илэрхий анзаарагдаж байсан. Гэхдээ нийт судалгаанд хамрагдсан 185 галын 65% нь холимог бүтэцтэй ах дүү, хамаатан садан болон найз нөхдийн хүрээлэлээр бүрдсэн, 21% дан найз нөхөд, үе тэнгийнхнээс бүрдсэн гал, 12% дан ганц

гэр бүлийн гишүүд, эхнэр хүүхдүүдээс бүрдсэн, үлдсэн 4% нь урьд өмнө нь бие биеэ таньдаггүй байсан өөр өөр орон нутгаас ирсэн санаа нийлэн ажиллаж байгаа хүмүүсээс бүрдсэн бүтэцтэй галууд байлаа.

Галын бүтцийг зураглан харуулбал доорхи байдалтай байна.



Судалгаанд оролцсон нийт галуудаас дундын сан, хуримтлалтай эсэх талаар асуухад нийт галуудын 78% нь олсон орлогоосоо дундын сан үүсгэдэг гэж хариулж байсан, түүнийг хэрхэн захиран зарцуулдаг талаар лавлахад галын ахлагчийн удирдлага, зааварчилгаан дор ил тодоор олборлолтын үйл ажиллагаа болон хоол, хүнс, тээвэр, тоног төхөөрөмж авах, түрээслэх зэрэгт зарцуулж, орлогоо тэнцүү хуваадаг талаараа ярьж байлаа. Харин үлдсэн 22% нь ажлын явцад гарсан зардлаа тухай бүрд нь галын гишүүдээс хураан авч төлдөг байна. Харин олсон орлогоо оруулсан мөнгө, хийсэн ажлынхаа хэмжээгээр харилцан адилгүй хэмжээгээр хуваадаг гэж ярьж байлаа.

8.2. Хувиараа алт олборлогч иргэдийн албан бус бүтцийн давуу ба сул талд хийсэн үнэлгээ

Ганц мод гал болдоггүй, ганц хүн айл болдоггүйтэй адил алт олборлох энэхүү хүнд хүчир биеийн хүчний ажлыг хамтаар хөдөлмөрөө хоршин хийхээс аргагүй байдаг байна.

Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр
Тэгвэл бид хүнд ажлаа сайнаар нугалах болно
Хэрэв нэг нь ойчих аваас нэг нь нөхрөө аварна
Харин ганцаар байвал унахын цагт түүнийг босгох хүн байхгүй учир

хөөрхийлөлтэй....

42 настай, Архангай аймгийн харъяат, эрэгтэй, Б-гийн ярианаас

Уянга хувиараа алт олборлож байгаа бүлэглэлийн хэлбэр нь доорх давуу, сул талуудыг агуулдаг болохыг бүлгийн өргөтгөсөн ярилцлагаар тодрууллаа.

Хүснэгт 33. Галын бүтцийн давуу ба сул талууд

Давуу тал	Сул тал
Хөдөлмөрөө хөнгөвчилдэг	Албан бус, хөдөлмөр хорших хэлбэр
Багаж хэрэгслээ хувааж хэрэглэдэг	Орлогоо хуваарилах тал дээр тэгш бус байдал гарах магадлалтай
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдал сайжирдаг	Шударга бус хөдөлмөрийн хуваарилалт
Мэдлэг мэдээлэл авах, нэг нэгнээсээ суралцах боломж их	Бүл чадал муутай хөгшид эмэгтэйчүүдийг гадуурхах хандлагатай
Асуудлаа хамт олноороо шийддэг	Гал дотор дарангуйлагч бий болох
Гишүүдийн аюулгүй байдлыг хангах	Гал дотор гишүүдийн сэлгээ их
Хамт олонч нийтэч сэтгэлээг төлөвшүүлнэ	Гал доторх зөрчил, сонирхлын бүлэг
Ажлын орчныг тав тухтай байдлыг хангана	Гишүүдийн нийгэм хөгжлийн асуудал биш, зөвхөн мөнгө олоход чиглэгдсэн
Эмэгтэйчүүдийн оролцоо, хөдөлмөр хуваарилалтыг шударга зохион байгуулна	Гишүүдийн нийгмийн хөгжлийг орхигдуулсан
Ажлын ачаалал, стрессийг хамтран үүрч, нэгж гишүүнд ирэх дарамтыг хөнгөлнө	Нэг хүнээс хэт хамаарах хандлага
Нүхээ булаацалдах, зөрчидөх шалтгаан багасна	Гал доторх шийдвэр гаргалтанд хүчирхэг нь давамгайлах
Иргэдийн хоорондын харилцаа, итгэлцэлийн нэмэгдүүлнэ	Галаараа нийлж дарвих, архидах, зодолдох, хэв журмын зөрчил гаргах

8.3. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаарх мэдлэг, мэдээлэл авсан байдал

Монгол Улсын засгийн газраас хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр хэд хэдэн эрх зүйн актыг 2008 онд батлан гарсан байна. Тухайлбал:

- “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” 28-р тогтоол
- Монгол улсын засгийн газрын Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр
- “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах 72-р түр журмыг тус тус баталжээ.

Эдгээр эрх зүйн акт, журмын талаар Уянга суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийн мэдлэг мэдээлэл, тэдгээрийг үйл ажиллагаандаа ашиглан мөрдлөгө болгож байгаа эсэхийг шинжлэхэд дараах дүр зураг гарч байна.

Хүснэгт 33. Түр журмын мэдлэг мэдээллийн байдал

Хариултын сонголт	Хувийн жин
Тийм	9%
Үгүй	91%

Эндээс харахад хувиараа алт олборлогч иргэдийн дунд түр журмын талаар, мэдлэг мэдээлэл, сурталчлан таниулах ажил шаардлагатай байгаа нь харагдаж байна. Эдгээр тогтоол, журмуудыг гарган мөрдүүлэх ажлууд энэ суманд хангалтгүй явагдсан байна. Зөвхөн санхүүгийн боломжтой хүмүүс компани байгуулан машин техник ашиглан бичил уурхайн хэлбэрээр алт олборлодог бол бусад орлого олох, амьжиргаагаа залгуулахаар ирсэн ядуу иргэдийн хувьд хөдөлмөрийн бүтээмж муутай, гар багаж хэрэгслээр алт олборлох хүнд, амь өрссөн ажлыг хийж өдөр хоногийг өнгөрөөж байна. Мөн энэхүү үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байгаа нь ажиглалт, ярилцлагын явцад харагдаж байлаа. Бичил уурхайг хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөгжүүлж чадсан тохиолдолд олон тооны ажлын байр бий болох, ажилгүйдэл ядуурал буурах, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах боломж асар их байгаа нь харагдсан.

8.4. Хувиараа алт байгаа иргэдэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа олон улсын болон дотоодын ТББ-ийн үйл ажиллагаа, цаашдын хамтын ажиллагаа

Уянга суманд нийт 3 олон улсын байгууллага ажиллдаг байна

1. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Хүнс хөдөө аж ахуйн яамны хамтран хэрэгжүүлж буй “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент”
 - о Энэ төслийн гол зорилго нь Өвөрхангай аймгийн сумдуудад цөлжилт, газрын доройтлыг бууруулах, улмаар цөлжилтийн нийгэм эдийн засагт үзүүлж буй сөрөг үр нөлөөг багасгах, нөхөн сэргээхэд чиглэгдэнэ. Энэ зорилгын хүрээнд газрын тогтвортой менежментийг төлөвшүүлэн хөгжүүлэх, энэ чиглэлийн үндэсний болон орон нутгийг байгууллагуудын чадварыг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан газрын тогтвортой менежментийн оновчтой арга хэлбэрүүдийг практикт нэвтрүүлэх явдал юм.
2. Монгол улсын засгийн газар, Дэлхийн банк, Европын холбоо, Япон улсын засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй тогтвортой амьжиргаа 2 төсөл
 - о Тогтвортой амьжиргаа 2 төсөл нь иргэн та санаачил бид дэмжье гэсэн уриан дор орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас гаргасан оновчтой цаг үеэ олсон, санал санаачлагыг дэмжих замаар орон нутаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршдог байна. Төсөл хэрэгжүүлэх гол чиглэлүүдэд сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр, нийтийн эзэмшлийн зам, гүүр, номын сан, соёлын төв, нийтийн халуун ус тохижуулах, өргөжүүлэх үйл ажиллагаанууд байдаг. Мөн түүнчлэн хөдөө аж ахуй, газар тариалан, фермер, фермерийн аж ахуйг дэмжих, байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагааг багасгах, эмзэг бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг жижиг төсөл хөтөлбөрүүдийг шалгаруулан, санхүүжилт өгдөг байна.
3. Дэлхийн Зөн ОУБ-аас хэрэгжүүлж буй Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр
 - о Орон нутагт оршиж буй асуудлыг хүүхэд төвтэйгээр шийдэж, хөгжүүлэх үндсэн зорилго, зорилт бүхий урт хугацааны орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг Дэлхийн Зөн ОУБ-аас хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь эрүүл мэндийн салбарыг дэмжих, эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах, олон нийтэд хүртээмжтэй болгох, боловсролын салбарыг хөгжүүлэн хүүхдүүдийн

сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн усан хангамжийг бууруулах, өрхийн орлого нэмэгдүүлэх жижиг төсөл дэмжих, ядуурлыг бууруулах зорилгоор хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэхэд ард иргэдийг сургах, нөөц боломжоор хангах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна. .

БҮЛЭГ 9

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ, ТҮҮНЭЭС ҮҮДЭН ГАРЧ БАЙГАА ЗӨРЧЛҮҮДИЙН ЗУРАГЛАЛ



9.1. Байгалийн нөөц ашиглалт ба нөхөн сэргээлт

Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагаагаа явуулж байгаа Өлтийн хөндий нь Уянга сумын төвөөс 1 километрийн зайд уртаашаа 18км, өргөнөөрөө 4км орчим талбайд тархан байрладаг юм байна.

Байгалийн нөөц ашиглан амьдрал ахуйгаа залгуулж байгаа эдгээр иргэдийн байрлаж буй талбайн дийлэнх хэсэг нь буюу 97 орчим хувь нь хуучнаар Эрэл компаний ашиглалтын талбай одоогоор Чех Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай АУМ ХХК-ны ашиглалтын талбай байна.

Эрэл ХХК-ний олборлолтод өртсөн Өлтийн амны 251,6 га талбайд 2002 оноос хойш жил бүр 5000-30,000 гаруй хувиараа алт олборлогч нар, 20-60 гаруй бичил уурхайн компаниуд ажиллаж, алт олборлосоор байна. Орон нутгийн иргэдтэй алтны олборлолт хийгдсэн газрын нөхөн сэргээлтийн байдлын талаар ярилцахад нөхөн сэргээлтийн огт хийгдээгүй эрх бүхий том, жижиг компаниудын дунд энэ ажил хэзээнээс орхигдож ирсэн гэж учирлаж байлаа.

Манайх энэ нутагтаа Мод мухартаа нутаглаж ирсэн хүмүүс. Манай энд хаа сайгүй алтны уурхайнууд, төмпөн үүрсэн нинжа нар байх боллоо. Эд нар алт олборлож болно.Хамгийн гол нь ашигласан талбайдаа нөхөн сэргээлт хийх хэрэгтэй байна.Манай нутаг Өлт ямар гоё байгаль байлаа. Алтны уурхай гарч ирээд л ийм боллоо.

Уянга сумын иргэн 36 настай Б. эрэгтэй

Энд одоогоор уул уурхайн том жижиг компаниудаас гадна 3500 гаруй хувиараа алт олборлогч иргэд алт олборлож байна.

Өлтийн хөндий олон мянган хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжилд ихээхэн түлхэц болсон ч гэсэн байгаль орчин, гол усны ундарга, байгаль экологид маш сөрөг үзүүлэн байгалийн унаган төрхийг дахин сэргэхээргүй эвдэж сүйтгэсэн байна.

Алтны уурхай ихэсч,гол багасч,дэлхий дэлэгнэхээ болилоо. Бидний амны усыг улаан цагаанаар нь хордуулаад байна

Уянга сумын уугуул иргэн 48 настай, эмэгтэй, Б

Тухайлбал хуучин олборлолт явуулж байсан нөхөн сэргээлт хагас дутуу хийсэн талбай дээр манайхан хэдэн халтар төгрөгийг нь бодоод хаягдлыг дахин ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл өгчих юм. Мөн хууль бусаар алт олборлолт асар хурдацтайгаар нэмэгдэж байна. Энэ хэрээрээ газрын хэвлий маш ихээр гэмтэж компаниуд техникийн нөхөн сэргээлт бага зэрэг хийж хамгийн их хэрэгтэй биологийн нөхөн сэргээлтийг хийхгүй үлдээж байна.

9.2. Хувиараа алт олборлогч иргэдийн нийгмийн дэг журам сахилга, хариуцлагын байдал

Сумын цагдаагийн тасгийн мэдээгээр 2009 оны 12-р сарын байдлаар 48 хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн хэргийн 35,5% нь иргэдийн өмчийн хулгай, 29% нь иргэний эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг, 9% нь танхай, 5,9% нь эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэг байна.

Албан бус эх сурвалжаас үзвэл дээрх бүртгэгдсэн хэрэг, зөрчлүүдийн талаас дээш хувийг хувиараа алт олборлогч иргэд үйлддэг болохыг баталж байлаа.

Алт бол өнөө маргаашийн л ажил шүү дээ. Монгол хүний ажил чинь мал шүү дээ. Энд хаа газрын тэнэмэлүүд ирж алт ухна. Тэд нойтон мод огтолно, түүхий самар түүнэ, булагийн эхэнд шороо угааж ширгээнэ, хүн амины хэрэг гаргана, айлуудын малыг хулгайлж иднэ. Ер нь маш хэцүү дээ. Настай хөгшчүүд ч надтай хамт босоход бэлхэн байсан.

Уянга сумын иргэн 59 настай, эрэгтэй, А

Орон нутгийн засаг захиргааны зүгээс хувиараа алт олборлож байгаа иргэдийг зохион байгуулалтад оруулах, тэдний байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2007 оноос хойш удаа дараа арга хэмжээ авч ажиллаж ирсэн байна. Тухайлбал алт олбоорлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор тус сумын Өлт, Бөөрөлжүүтэд үүсээд байгаа нөхцөл байдал, хууль бусаад худалдаа наймаа эрхэлж буй иргэдийн хууль бус үйлдэлийг таслан зогсоох зорилгоор Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 15, цагдаагаас 15, онцгой байдлаас 10, байгаль орчин аялал жуулчлалын газраас 5, сумаас 15 бүгд 60 хүний бүрэлдэхүүнтэй баг хоног ажиллан Өлтийн хөндийд худалдаа гуйнз ажиллуулж буй өрхүүдийг 4 газар төвлөрүүлэн хууль бус эм, шатах, тослох материал, согтууруулах ундаа худалдахыг хориглож, орчны хог хаягдалыг цэвэрлүүлсэн. Үүний зэрэгцээ ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж нөхөн сэргээлтийн ажлын явцад шалгалт хийжээ.

Мөн 2005 онд Уянга суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийг бүртгэлжүүлэх ажлыг улс, аймаг, сумын Иргэний Бүртгэл мэдээллийн төвийн ажилчид хамтран хийх оролдлогыг хийсэн боловч төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Мөн 2008 онд улсын хэмжээнд хувиараа алт олборлож байгаа иргэдийг бүртгэлжүүлэх ажлыг улс, аймаг сумын нийгмийн халамж үйлчилгээ, иргэний бүртгэл мэдээллийн төвээс явуулсан боловч Уянга суманд алт олборлогч иргэдийг үнэн зөв тоолж, бүртгэлжүүлж чадаагүй.

Хүн амины хэрэг, хулгай дээрэм, танхай хүчин, биеэ үнэлэлт, осол аваар зэрэг нийгэмд байдаг бүхий л зүй бус үзэгдлүүд байдаг гэдгээрээ бараг домог болох шахсан Уянга сумын талаар судалгаа хийж байх явцдаа энэ талаар илүү дэлгэрэнгүй тодорхой мэдээлэл авахыг хичээсэн ч эдгээр асуудал нь өөрөө хувь хүний нэр хүндтэй холбоотой эмзэг асуудал учир судлахад хүндрэлтэй байлаа.

Өлтийг нутгийн нэгэн ахмад настан
“Шороогоо зардаг “Эрэл”-ийнхэн
Шоронгийн данстай азарганууд
Жийп унасан боссууд,
Жижгирч ядуурсан шороочид” хэмээн шоглон шүлэглэсэн байна.

9.3. Хувиараа алт олборлогч иргэдийн орчны эрүүл ахуй, усан хангамж

Судалгааны явцад алт олборлогчдын эрүүл мэндийн нөхцөл байдлын талаар танадалт судалгаа явууллаа. Алт олборлолтын явцад тоос маш ихээр дэгддэг ба ашигласан газартаа нөхөн сэргээлт хийдэггүй учраас алт олборлох ажлын явцад үүссэн сул шороо, элс тухайн орчинд байнга тоосжилтыг болгодог байна. Их тоостой орчинд , удаан хугацаагаар ажиллдаг учир амьсгалын замын ялангуяа уушиг тоосжих өвчнөөр өвддөг гэж сумын эмч ярьж байлаа.

Харьцангуй бага талбайд 20 гаруй жилийн туршид хэдэн мянгаараа нэг газар бөөгнөрөн амьдарч байгаа хэдий ч орчны тохижилт, эрүүл ахуйн шаардлагын наад захын хэрэгцээ болох төвлөрсөн хогийн цэг, муу усны цооног, нийтийн бие засах газар нэг ч байгаагүй. Үүнийг иргэдийн ухамсар, эрүүл ахуйн мэдлэг, дадлага муу байгаагийн тод жишээ гэж хэлж болохоор байна. Яагаад гэвэл ухсан нүхээ гарын доорх материалаар тойруулан жорлон болон муу усны цооног хийх, ахуйн хог хаягдааа нүхэндээ хийж булах, шатаах зэргээр устгаж, орчны бохирдлыг багасгаж, өөрсдийн амьдрах тав тухтай нөхцөл байдлыг бага ч гэсэн бүрдүүлж болох хэдий ч ийм алхам огт хийгдээгүй байлаа. Ахуйн хог хаягдал, бохир усаа ил задгай хаяж асгасан, хүн нохойн ялгадастай орчинд амьдарч байгаагийн улмаас дулааны улиралд суулгалт халдвар, халдварт шар өвчин, арьсны эмгэг загатнаа зэрэг өвчин маш их гардаг байна.


Хувиараа алт олборлогч иргэдийн ажиллаж амьдарч байгаа орчинд ундны, ахуйн, технологийн усны хангамж хэрэгцээ туйлын дутмаг байлаа. Энд хувийн портер машинаар том уурхайн худагнаас ус авчирч 25 литрийн 50 төгрөгөөр буюу литрийг нь 20 төгрөгөөр худалдан борлуулж байлаа. Шороогоо угаахдаа олборлолт хийж байгаа газарт ус байхгүй учир 6-10 километр зайнд орших том уурхайн хиймэл нууранд 10,000 төгрөг төлөн ачуулж мөстсөн усыг цоолон цооног гаргаж шороогоо түмпэнгээр угаадаг байна.

Эндхийн хүн малгүй л Онгийн голоо шүтэж амьдардаг.Манай энд Онги урсахаараа саваа хальж 1 км өргөн болдог байсан одоо саваа ч дүүрэхээ болиод байна.Сүүлийн үед голын эхэнд алт олборлох үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байгаагаас болдог гэж бид үздэг.Манай энд ингэж байгаа юм чинь адагтаа буюу Өмнөговь аймгийн булган мандал овоо сумдад бүр

хэцүү байгаа байх даа. Үүнийг төр засаг анхаралдаа авч зүй бус үзэгдлийг зогсоох хэрэгтэй гэж боддог.

Нэг литр усны үнэ Улаанбаатар хотоос 20 дахин их, Уянга сумын төвөөс 10 дахин байсан ба ийнхүү усны үнэ өндөр, хүрэлцээ олдоц муу байдаг учир хувиараа алт олборлогч иргэдийн хувийн ариун цэврийг сахих, хувцас хунараа угаах, усанд орох, орон гэрээ угааж цэвэрлэх боломжийг хязгаарлаж байна. Мөн сайтан дээр ус үнэтэй, олдоц муу байдаг учир өвөл иргэд цасны ус хайлуулан ундандаа хэрэглэдэг ба ингэж уурхайн эргэн тойрон ахуйн болон, технологийн үйл ажиллагааны улмаас бохирдсон хөрсний цасыг хайлуулан хэрэглэснээр дээрх эрхтэн өвчлөл тархах үндсэн нөхцлийг бүрдүүлдэг байна.

График 20. Уурхай дээр хувиараа алт олборлож байгаа иргэдийн дунд хамгийн хэрэгцээтэй зүйлс



9.4. Байгаль орчныг хамгаалах орон нутгийн байгууллага, иргэдийн санал, санаачлага хөдөлгөөн

Орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, байгаль орчноо хамгаалах зорилгоор “Байгаль хамгаалал Орон нутгийн хөгжил” ТББ олон нийтийн санал, санаачлагаар байгуулагдаж тус суманд нэлээд идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байна. Тус Төрийн бус байгууллага нь үйл ажиллагааныхаа хамрах хүрээг өргөжүүлэн “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ-д нэгдэн орсон байна. Энэ нэгдсэн хөдөлгөөнд Дундговь аймгийн “Онги голийнхон”, Төв аймгийн Заамар сумын “Тосон Заамар”, Говь Алтай аймгийн “Салхин Сандаг”, Сэлэнгэ аймгийн “Хүдэр гол”, Говь Алтай аймгийн “Ангир нүдэн мөндөөхэй”, “Уул усны дуудлага” гэсэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг


төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж багагүй үр дүнд хүрсэн байна. Үүний нэг тод жишээ бол 2009 оны УИХ хаврын ээлжит чуулганаар “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалатын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг ард иргэдийн хүчин чармайлт, идэвхи оролцооны үр дүнд батлуулж чадсан байна. Хууль батлагдснаас хойш даруй 4 сар гаруй хугацаа өнгөрөөд байна. Энэ хугацаанд нэгдсэн хөдөлгөөнийхөн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрсдийн төлөөлөлийг оролцуулах усны сан бүхий газрын хилийн заагийг тогтоох журмын төсөлд санал бодлоо оруулах ажлууд дээр идэвхитэй, гар бие оролцож байгаа юм байна. Тус хөдөлгөөний тэргүүн Г. Доржтой уулзаж ярилцахад Өлт Бөөрөлжүүтийн хөндий нь голын урсац бүрэлдэх эх сан газар учраас голын эх орчинд алт олборлож байгаа том жижиг компаниуд хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг хуулийн дагуу зохицуулах, цэгцлэх, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлуулах санал тавих зэрэг ажлыг орон нутгийн удирдлага, ард иргэдтэй хамтарч хийнэ. Орон нутаг гол усаа хамгаалж чадвал Монголын ирээдүй гэрэлтэй байх болно” гэж ярьж байлаа.

Бид энэ газрыг алт олборлох үйл ажиллагаанд өгөхгүй гээд их зүтгэсэн багийн хурлууд дээр хэлсээн.Тэгэхээр дээгүүрээ болсон,өгсөн,авсан гэж ярьцгаадаг.Бид нартай уулзах юм биш дээ.Нутгийн иргэд шороо ухдаг тэднийг хөөдөг. Өлтийн өвс ургамлыг ургуулж өгмөөр байх юм.Уул шиг шороо овоо босгочихоод явах юм.Бид энэ нутагтаа ч байх эрхгүй боллоо.5-р сараас эхлээд биднийг цөмийг нь Баарай руу нүү гэж хөөсөн.Ажиллаж байгаа үедээ хүн мал уухын аргагүй улаан ус болдог юм л даа.Тэдний ажил эхлэхээс өмнө үрээр хүн мал усаа авч ууна,малаа услаж авахгүй бол горьгүй.

9.5. Хувиараа алт олборлогч иргэд болон бусад талуудын хоорондын зөрчил, түүний зураглал

Уянга сумын “Өлт” хэмээх голын хөндий “Эрэл” компанийг ирэхээс өмнө ус ургамал нь тэгширсэн сайхан нутаг байжээ. Гэвч одоо шороо, овоорсон, элс шуурсан хөндий болжээ. Тэнд урсаж байгаа ус, ургаж байгаа ногоо гэж алга. Уянга суманд байгалийн нөөц ашиглахтай холбоотой гарч буй зөрчлүүд хувь хүмүүсийн хоорондын асуудлаас эхлээд хэд хэдэн талуудыг хамарсан төвөгтэй хэлбэрээр оршсоор байна. Энэ суманд хувиараа алт олборлогчид, бичил уурхайн компаниуд, томоохон уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа, иргэд, малчдын хооронд бэлчээр, ус, газар ашиглах, алт олборлохтой холбоотой олон арван зөрчлүүд байгаа талаар бүлгийн ярилцлагад оролцогч иргэд тодорхой жишээ татан ярьж байсныг дор сийрүүллээ..

График 21. Сонирхлын бүлгүүдийн зөрчлийн зураглал



“Эрэл” мэтийн том аж ахуйн нэгж цагдаа хөлсөөр ажиллуулж иргэдийг дарамтлуулдаг тухай маш их гомдол гаргаж байна. Том аж ахуйн нэгжийн хөлсөлсөн цагдаа, хамгаалалтын албаныхан харгислах гэдгийг үзүүлж өгдөг бололтой. Тэдний гарт “Өлт”-д жирэмсэн эх тэдний гарт үрэгдсэн тохиолдол гарч байлаа.

32 настай, эмэгтэй, Ц

БҮЛЭГ 10

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Өвөрхангай аймгийн Уянга сумын нийгэм, эдийн засгийн суурь судалгааны үр дүн дээр үндэслэн судалгааны багийн зүгээс дараах дүгнэлтийг хийж байна.

Бүлэг 3.

Уянга суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засаг, ашигт малтмал олборлолтын байдал

- Уянга сум нь Өвөрхангай аймгийн бусад сумдуудтай харьцуулахад алт олборлолтын хэмжээ, цар хүрээ, хувиараа алт олборлогч иргэдийн тоогоороо тэргүүлж байна.
- “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” батлагдсан хэдий ч он удаан жилийн хугацаанд том уурхайн болон бичил уурхайчдын зохисгүй үйл ажиллагааны улмаас газар нутаг, бэлчээр, ус сүйдсэн учир орон нутгийн иргэд, засаг захиргаа, малчид, иргэдийн хөдөлгөөнүүдийн хувиараа алт олборлох үйл ажиллагаанд хандах хандлага сөрөг хэвээр байлаа. Эдгээр нутгийн иргэд бичил уурхайн салбарыг орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг гэж харахаасаа илүү байгаль орчинг сүйтгэх, уламжлалт мал аж ахуйг эрхлэх үндэс бэлчээрийг сүйтгэдэг гол хүчин зүйл хэмээн харж дүгнэж байна.
- Уянга сумын хэмжээнд 10 аж ахуйн нэгж 21,357,4 га талбайн 15 хайгуулийн лиценз, 4 аж ахуйн нэгж 1762,5 га талбайд 6 ашиглалтын лиценз ашиглаж байна.
- Уянга суманд уурхайд өртсөн нийт талбай 257,6 га байна.
- Уянга суманд 9498 хүн амтай, түүнээс 49,5% эрэгтэй, 50,6% нь эмэгтэй хүмүүс байдаг.
- Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой 1031 өрхийн 5994 хүн амьдарч байгаа ба үүнээс 34,3 % нэн ядуу өрх байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжөөгүй учраас орон нутгийн хэмжээнд ажлын байр ховор, хөдөлмөрийн зах зээлийн хүрээ харьцангуй хязгаарлагдмал байна. Тиймээс сумын бараг ихэнх иргэд алт олборлох үйл ажиллагаанд оролцдог байна.
- Сумын нийт иргэдийн 38,5% нь хувиараа алт олборлох үйл ажиллагаа эрхэлдэг юм байна. Сумын залуучуудын хувьд биеийн хүчний ажил эрхлэх боломжтой найз нөхөд, ах дүү нар нартай нийлэн алт олборлодог, харин өндөр настнууд болон эмэгтэйчүүдийн шороо хайраглах, шигших, угаах зэрэг ажлыг голдуу хийдэг ч гэсэн эрчүүдийн нэгэн адил нүх ухах, нүхэд ажиллах, шороо үүрч зөөх зэрэг хүнд хүчир ажлыг хийдэг байна.

Бүлэг 4

Уянга суманд хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн байдал

- Уянга сумын Өлтийн хөндийд 2010 оны 1-р сарын байдлаар 3,500 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч иргэд найман цэгт буюу уулын ам, салаануудад бөөнөөрөө тосгон болон суурьшиж, алт олборлож байна. Тэдний 67,4% эрэгтэйчүүд 32,6% эмэгтэйчүүд байна.
- Нийт хувиараа алт олборлогч иргэдийн 82% нь Уянга суманд албан ёсны бүртгэлгүй, 18% бүртгэлтэй иргэд байлаа.
- Хувиараа алт олборлогч иргэдийн 55% нь гэрлэсэн, 21% ганц бие, 10% хамтран амьдрагчтай, 8% бэлэвсэн, 6% нь гэр бүлээсээ салсан хүмүүс байлаа.
- Нийт хувиараа алт олборлогч иргэдийн 78% нь алт олборлохоос өөр давхар ажил эрхэлдэггүй, зөвхөн алтнаас олох орлогоосоо 100% хамааран амьдардаг иргэд байна. Үлдсэн 22% нь малчид, төрийн болон төрийн бус байгууллагад ажилчид, мөн гэр гуанз, худалдаа наймаа эрхэлдэг хүмүүс байна.
- Уянга суманд алт олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа хүмүүсийн алт олборлосон дундаж хугацаа нь 6,3 жил байна.
- Өлтийн хөндийд хувиараа алт олборлож буй иргэдийн сарын дундаж орлогын хэмжээ нь Өвөрхангай аймгийн албан ёсоор ажил эрхлэгч иргэдийн сарын дундаж цалингаас 7,5%-иар их буюу дунджаар 310,000 төгрөг байна. Ер нь тэдний орлого нь алтны судал, гарц, тэдний ажилласан хугацаа, дадлага, туршлага, ур чадвар, тоног төхөөрөмж багаж хэрэгслийн хүчин чадал зэргээс шалтгаалдаг байна.
- Тэдний хувьд алт олборлох үед хамгийн түрүүнд тохиолддог бэрхшээл нь ус, цахилгаан, гэр оронтой байхаас илүүтэйгээр дарагдах, нурах, осол гэмтлээс айх, түгшүүртэй байдал гэж үзэж байгаа нь байр, хоол, хувцас зэрэг хүний суурь хэрэгцээнээс илүүтэйгээр сэтгэлзүйн бэрхшээл давамгайлж байна.

Бүлэг - 4

Хувиараа алт олборлогч нарын алт олборлолтын орлого ба зарлага

- Алт олборлодог иргэдийн сарын дундаж орлого нь МУ-ын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 42,000 – 380,000 төгрөгөөр илүү байдаг болохыг санал асуулгын судалгаагаар тодорхойлсон.
- Хувиараа алт олборлогч иргэд орлогоо тодорхойлоход нэлээд удаан бодох, хариулахаас татгалзах байдал олон тохиолдсон бөгөөд энэ нь нэг талаас “цагаан хэл эм” хүрэх магадлалтай гэсэн уламжлалт сэтгэлгээ, нөгөө талаас орлогоо хянах, зохицуулах, төлөвлөх хандлага, боловсрол багатай холбоотой байж болох юм.

- Дундаж хувиараа алт олборлогч иргэн өдөрт 7000 төгрөгний зардал гарган 13,500 төгрөгний ашиг олон 6,500 төгрөгний цэвэр ашигтай ажилладаг гэж оролцооны аргаар тодорхойлон гаргалаа.
- Өлтийн уурхай дээр худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүний үнэ сум аймгийн төвийн үнээс 70-500 төгрөгний илүү үнэтэй байна. Уурхайн газарт ундны усыг хамгийн их үнийн зөрүүтэй худалдаалж байсан ба 1 л ус 20 төгрөг байлаа.
- Нийт хувиараа алт олборлогч иргэдийн 84% нь хуримтлалгүй, 16% нь тодорхой хэмжээний хуримтлалтай байлаа.

Бүлэг 5:

Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал

- Тэдний алт олборлох ажлыг эрхлэх болсон шалтгаанд хүүхдийн сургалтын төлбөр, өр зээлээ төлөх, орон байртай болох, эмчилгээний зардал олох бөгөөд хамгийн шол шалтгаан нь ажил олдохгүйгээс амьжиргаа залгуулах эх үүсвэр болж байгаа гэсэн байна.
- Хувиараа алт олборлогч иргэд давчуу харанхуй хүйтэн тохиромжгүй нөхцөлд ажиллаж, биеийн хүчний хүнд ажлыг хийдэг бөгөөд нэг маягийн хөдөлгөөний давталт ихтэй, биеийн тохиромжгүй, албадмал байрлалд, давчуу зайнд ажилладаг, халтирах, тээглэх унах, юманд цохиулах, даруулах, иртэй болон хөдөлгөөнтэй багаж хэрэгсэлтэй харьцах үед хавчуулагдах, зүсэгдэх зэрэг осол гэмтэлд өртөх эрсдэл өндөртэй байна.
- Тэдгээр иргэд зориулалтын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэл хэрэглэдэггүй, өөрсдийн өдөр тутам өмсдөг ердийн гутал, ажлын хувцастайгаа ажилладаг бөгөөд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл, хувцсыг сонгох, хэрэглэх мэдлэг хандлага хангалтгүй байна.
- Хувиараа алт олборлож буй иргэд дунджаар 9-14 цаг ажиллан, ажлын өдрийн цаг, завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алтны олдоц, улирлын байдал, цаг агаар зэргээс хамаардаг бөгөөд тэдэнд баримтлах хөдөлмөр амралтын тогтсон горим байдаггүй.

Бүлэг 6:

Хувиараа алт олборлогч иргэлийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

- Хувиараа алт олборлож байгаа иргэдийн хувьд усан дотор зогсох, газар доор агааргүй, хүйтэн, харанхуй орчинд биеийн хүчний ажил хийснээс зүрх судас, амьсгалын тогтолцоо, бөөр, нуруу, шээсний

замын өвчин зэрэг эмгэгээр өвдөх цаашилбал хөдөлмөрийн чадваргүй болох тохиолдлууд байгаагүй тохиолддог байна.

- 2009 оны байдлаар Уянга суманд бэлгийн замын өвчнөөр нийт 169 хүн өвчилснөөс 80 хүн заг хүйтэн, 10 хүн тэмбүү, 76 хүн трихоминаз, 3 мөөгөнцрөөр өвдөж, эмчлүүлсэн тохиолдлууд бүртгэгдсэн. Эдгээр тохиолдлуудын 60% нь жирэмсний үеийн эмчийн хяналтын үед оношлогдож, эмчлэгдсэн байна. Өвчлөгсөд нь ихэвчлэн 20-35 насны жирэмсэн эмэгтэйчүүд байлаа. Эндээс харахад хувиараа алт олборлогч иргэд нь сайн дураараа бэлгийн замын өвчлөлийн оношлогоо, шинжилгээнд хамрагддаггүй л болохоос биш бэлгийн халдварт өвчний тархалт их байх магадлал өндөр байна.
- Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн дунд давхардсан тоогоор 63,3% нь гэмтэж байсан, 22% осолд орж байсан, хаин 32% нь гэмтэж байгаагүй байна.
- Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн 92% буюу 460 нь эрүүл мэндийн даатгалгүй харин 89 буюу 40 нь эрүүл мэндийн даатгалтай байлаа.
- Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, анхаарах орчин нөхцөл хувиараа алт олборлогч иргэдийн ажил, амьдралын орчинд тун бага. Хүнд өвдсөн, гарцаагүй тусламж шаардлагатай үед эмнэлэгт хандаж байна.
- Хувиараа алт олборлогсдын ажлын байрны тоос, шуугиан, доргион эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа нь ажилчид тоосны гаралтай уушиг тоосжих, шуугианы гаралтай сонсгол муудах, дүлийрэх, бөөр нуруу, яс булчин хөдөлгөөний тулгуур эрхтний эмгэг үүсэх эрсдэлтэй байна.
- Алт олборлогсдын тал хувь нь гэнэтийн, яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламжийг 3 цагийн дотор авах боломжгүй гэж хариулж байсан. Эрүүл мэндийн тусламж авахад гардаг гол бэрхшээлд тэднийг хаяг тодорхойгүй, алслагдмал байдал, тээврийн хэрэгсэл дутмаг, холбоо харилцаа байхгүй зэрэг орж байна. Тэдэнд баталгаат, зайлшгүй шаардлагатай эмийн үйлчилгээ, эмчийн үзлэг, оношлогоо, нарийн мэргэжлийн үзлэг, осол гэмтлээс сэргийлэх, өвчнөөс сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ шаардлагатай байна.

Бүлэг 7:

Хувиараа алт олборлогч иргэлийн зохион байгуулалт хамтын ажиллагаа

- Нийт судалгаанд оролцогчдын 78% найз нөхөдтэй, 58% гэр бүлийн гишүүд, хамаатнуудтайгаа, 42% нутгийнхантайгаа гал болон хөдөлмөрөө хоршин ажилладаг байна. 185 галын 65% нь холимог бүтэцтэй ах дүү, хамаатан садан болон найз нөхдийн хүрээллээр бүрдсэн, 21% дан найз нөхөд, үе тэнгийнхнээс бүрдсэн гал, 12% дан ганц гэр бүлийн гишүүд, эхнэр хүүхдүүдээс бүрдсэн, үлдсэн 4% нь урьд өмнө нь бие биеэ таньдаггүй байсан өөр өөр орон нутгаас ирсэн

санаа нийлэн ажиллаж байгаа хүмүүсээс бүрдсэн бүтэцтэй галууд байлаа.

- Хувиараа алт олборлогч иргэдийн галуудаас 78% нь олсон орлогоосоо дундын сан үүсгэн, галын ахлагчийн удирдлага, зааварчилгаан дор ил тодоор олборлолтын үйл ажиллагаа болон хоол, хүнс, тээвэр, тоног төхөөрөмж авах, түрээслэх зэрэгт зарцуулдаг, харин үлдсэн 22% нь ажлын явцад гарсан зардлаа тухай бүрд нь галын гишүүдээс хураан авч төлж, олсон орлогоо оруулсан мөнгө, хийсэн ажлынхаа хэмжээгээр харилцан адилгүй хэмжээгээр хуваадаг байна.
- Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын талаар Уянга суманд хувиараа алт олборлож байгаа иргэдийн мэдлэг мэдээлэл ямар байгааг, энэхүү түр журмыг хэрхэн үйл ажиллагаандаа ашиглан мөрдлөгө болгодог талаар асуухад 91% энэ талаар ямар ч мэдээлэлгүй байлаа.

Бүлэг 8.

Байгалийн нөөц ашиглалт, түүнээс үүдэн гарч байгаа зөрчлүүдийн зураглал

- 2009 оны байдлаар Уянга суманд нөхөн сэргээх шаардлагатай талбай 161 га газар байлаа.
- Ашиглалтын болон хайгуулын лицензтэй 20 гаруй компани, 60 гаруй бичил уурхайн компани, 3500 гаруй хувиараа алт олборлогч иргэд тус сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ч нөхөн сэргээлтийг огт хайхардаггүй байна.
- Өлтийн хөндий дэх байгалийн нөөц нь олон мянган хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, орон нутгийн хөгжилд ихээхэн түлхэц болсон ч гэсэн байгаль орчин, гол усны ундарга, байгаль экологид маш сөрөг нөлөө үзүүлэн байгалийн унаган төрхийг дахин сэргэхээргүй эвдэж сүйтгэсэн байна.
- Уянга суманд байгалийн нөөц ашиглахтай холбоотой гарч буй зөрчлүүд хувь хүмүүсийн хоорондын асуудлаас эхлээд хэд хэдэн талуудыг хамарсан төвөгтэй хэлбэрээр оршсоор байна. Энэ суманд хувиараа алт олборлогчид, бичил уурхайн компаниуд, томоохон уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа, иргэд, малчдын хооронд бэлчээр, ус, газар ашиглах, алт олборлохтой холбоотой олон арван зөрчлүүд байдаг байна.

ЗӨВЛӨМЖ

Хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээг судлах ажлын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг толилуулж байна. Үүнд:

- Уянга сумын Өлтийн аманд алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн дунд Засгийн газрын 72-р тогтоол, түр журмын дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, олборлолтын газрын асуудлыг шийдэхэд мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх
- Уянга сумын Өлтийн аманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдээр техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухай бүрд хийлгүүлж, нөхөн сэргээлтийн ажлын явцад хяналт тавих, стандарт шаардлагын дагуу хүлээн авч, нийтэд мэдээлж байх
- Хувиараа алт олборлогч иргэд Өлтийн уурхайн алтны нөөц багасаж байгаагаас болж Говь Алтай аймгийн Бигэр сум руу очиж, ямар ч эсэргүүцэл, хориг саадыг үл тоон алт олборлох боломж бололцооны төлөө тэмцэнэ хэмээн ярьж байгаа учир иргэд хоорондын болон төр засаг иргэд хоорондын болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ асуудлыг зөвшилцлийн замаар шийдэх боломжийг даруй хайж эхлэх
- Бичил уурхайн хуулийг яаралтай батлан гаргах шаардлагатай байгаа бөгөөд хуулийн төслийг боловсруулахдаа ХАМО иргэдийн хэрэгцээ, шаардлага, бодол зөвлөмжийг сайтар тусгах
- 2009 онд УИХ-аар батлагдсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашигт малтмал олборлох тухай” хуулийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн заагийг бодитой гол мөрөн бүрэн хамгаалагдахуйц байдлаар тогтоох ажлыг даруй эхлэх
- Орон нутгийн тусгай хэрэгцээнд ашигт малтмалын нөөц бүхий газрыг шилжүүлэх, мөн орон нутгийн удирдлагад олборлолтын газар олгох эрхийг өгөх замаар ХАМО иргэдийн газрын асуудлыг шийдэх боломжийг судлах
- Бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын талаар бусад орнуудын туршлага, сургамжаас суралцах
- Хувиараа алт олборлогчдын тухай мэдээллийг тухайн орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан жил тутам гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, хөдөлмөрийн зах зээлийн албан бус хэвшил дэх тэдний үүрэг, оролцоог тодорхойлж байх, бодлого боловсруулагч, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах

- Хувиараа алт олборлогчдын эрхэлж буй үйл ажиллагаа нь хөдөлмөр зарцуулалт ихтэйг анхааран тэднийг энгийн, хямд төсөр, ашиглаж болохуйц техник, тоног төхөөрөмжтэй болоход туслах, үүнийг бичил санхүүгийн харилцаа буюу жижиг зээл, түрээсээр дамжуулан хэрэгжүүлэх
- Орон нутгийн түвшинд алт худалдах, худалдан авах журмыг боловсруулах
- Өлтийн хөндийд төвлөрсөн бие засах газар, нэгдсэн хогийн цэгүүдийг бий болгох зэргээр орчны эрүүл ахуйг сайжруулж болзошүй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах
- Олборлолт хийж буй газар ундны усны хангамжийг сайжруулах, баталгаагүй ус хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө, зөвлөмж өгөх, дорвитой ажил хийх хэрэгтэй байна
- Хувиараа алт олборлогчдын эрхэлж буй үйл ажиллагааны аюултай, эрсдэлтэй, эрүүл мэндэд сөрөг нөлөөлтэй байдлыг харгалзан тэднийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд хоёроос доошгүй удаа хамруулж, тогтмолжуулах
- Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, хандлага, дадал туршлага хангалтгүй байгааг анхааран энэ талаарх сургалт, сурталчилгаа, мэргэжлийн тусламж, үйлчилгээ, зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллага, сайн дурынхнаар дамжуулан зохион байгуулах,
- Хувиараа алт олборлогчдыг эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд хамруулах тал дээр холбогдогч талуудтай хамтран ажиллаж тэдний нийгмийн халамжийн суурь үйлчилгээ авах боломжийг сайжруулах
- Хувиараа алт олборлогчдын бие хүний хувьд хөгжих боломж хязгаарлагдмал, хүмүүс хоорондын харилцаа сул, доголдолтой байдгаас сэтгэлээр унах, айж эмээх, сэтгэл санаа тавгүйтэх зэрэг үзэгдэл түгээмэл байдаг тул тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх,
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, бүтээмж өндөртэй, гар багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийн загварыг боловсруулан олборлолтын үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх

ХАВСРАЛТ 1

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, Үндэсний Статистикийн газар, УБ хот, 2008 он
2. Өвөрхангай аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн мэдээлэл, Аймгийн Статистикийн алба, Арвайхээр сум, 2009 он
3. Socio-economic situation of informal gold miners in Mongolia (survey report), joint: UNFPA, Government of Japan, School of public health, health sciences university of Mongolia; UB, 2007
4. Informal gold mining in Mongolia, International Labor office, UB, 2006
5. Бичил уурхай, хэтийн төлөв, зохицуулалт, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2008
6. Blue Sky Mining: community and mining in Omnogovi aimag, Pact Mongolia, UB, 2008
7. Artisanal and Small-scale mining in Mongolia, research paper 4, J.Janzen and others, UB, 2007
8. Олон улсын туршлагаас товч танилцуулах нь, М. Приестэр (орчуулга), ШХА, УБ, 2005
9. Монголын хувиараа ашигт малтмал олборлогчдын техник, технологийн үнэлгээ, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2007
10. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, заавар, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009
11. Нинжа нарын нэн шинэ түүх, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009
12. “Бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” үндэсний зөвлөгөөн, ТоБУ, ШХА, УБ, 2009